

МОНГОЛ УЛСЫН ОЛБОРЛОХ САЛБАРЫН ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ИЛ ТАЙЛАГНАЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Н.Дорждарь

2024 оны 7 дугаар сар

Natural Resource Governance Institute

Агуулга

1. Удиртгал 4
Ерөнхий мэдээлэл 4
Зорилго 7
2. Судалгааны арга барил 7
Аргачлал 7
Хамрах хүрээ 8
3. Судалгааны үр дүн 12
Олборлох салбарын ТӨК-ийн ил тайлагналын шаардлага 12
Холбогдох бүх ТӨК-ууд мэдээллээ ил тод нийтэлдэг үү? 15
ТӨК ямар мэдээллийг ил тод нийтлэх ёстой вэ? 18
Шаардлага 1. Олон талт оролцогчдын бүлгийн зүгээс тавих хяналт 19
Шаардлага 2. Эрх зүйн болон институтийн тогтолцоо, гэрээ, тусгай зөвшөөрөл 21
Шаардлага 3. Хайгуул ба бүтээгдэхүүн үйлдвэрлэл 33
Шаардлага 4. Орлого төвлөрүүлэлт 36
Шаардлага 5. Орлогын менежмент ба зарцуулалт 41
Шаардлага 6. Нийгэм ба эдийн засгийн зардал 41
4. Дүгнэлт, зөвлөмж 44
Дүгнэлт 44
Зөвлөмж 46
Хавсралт 1. ТӨК болон төрийн эзэмшил (хувиар)-ийн жагсаалт 49
Хавсралт 2. ТӨК-ийн мэдээллийг ил тод нийтлэх талаарх ОУИТБС-ын шаардлага 50
Хавсралт 3. Шилэн дансны ТӨК-ийн ил тайлагналын шаардлага 56
Хавсралт 4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль дах ТӨК-д тавих ил тайлагналын шаардлага 57
Хавсралт 5. Уул уурхайн салбарын ТӨК, бүтээгдэхүүний төрлөөр 61
Хавсралт 6. ТӨК-ийн Шилэн дансанд нийтэлсэн байдал 62
Хавсралт 7. ОУИТБС-ын стандарт болон хууль эрх зүйн шаардлагын харьцуулалт 63
Эх сурвалж 70

Хавтасны зургийг Ниалл&Мэрианн, Криэтив Коммонс лицензийн дор Фликр-ээс авч ашиглав

Монгол Улсын олборлох салбарын төрийн өмчит компаниудын ил тайлагналын тойм судалгаа

Судалгааг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын дэмжлэг, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр гүйцэтгэв.

1. Удиртгал

Ерөнхий мэдээлэл

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн гүйцэтгэсэн Монгол Улсын төрийн өмчит уул уурхайн компаниудын ил тайлагналын тойм судалгааг уг тайланд танилцуулж байна. Судалгааг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дэмжлэг, санхүүжилтээр гүйцэтгэв.

Монгол Улсын олборлох салбар нь улсын төсвийн орлогын 31.6 хувь, экспортын орлогын 92 хувь[1], ДНБ-ий 28.2 хувийг[2] бүрдүүлдэг эдийн засгийн хувьд чухал үүрэгтэй. Тус салбарт олон тооны компани үйл ажиллагаа явуулдаг бөгөөд төрийн өмчит компани (ТӨК)-ууд ашигт малтмалын хайгуул, олборлолт, менежментэд голлох үүрэг гүйцэтгэдэг. Холдинг компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг “Эрдэнэс Монгол” ХХК нь хамгийн том ТӨК юм. Энэ компани Оюутолгойн зэсийн (34 хувь), Тавантолгойн нүүрсний (65 хувь), Шивээ-Овоогийн нүүрсний (90 хувь), Баганууурын нүүрсний (75 хувь)[3] уурхайд тус тус хувь эзэмшдэг бөгөөд тус компанийн харьяанд Эрдэнэтийн зэсийн үйлдвэр болон Монголросцветметийн төслүүдийг[4] нэгтгэсэн байна. Эдгээр төслийг "стратегийн" гэж тодорхойлж, уг төсөлд төр хувь эзэмших асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулдаг. “Эрдэнэс Монгол” компани нь мөн алт, мөнгө, ураны хайгуул, олборлолтын компаниудад хувь эзэмшдэг.

Хэдийгээр Монгол Улсын эдийн засагт голлох үүрэг гүйцэтгэж байгаа ч уул уурхайн салбарын ТӨК-иудын засаглал, ил тод байдалд олон бэрхшээл тулгарч байна. Тухайлбал, “Эрдэнэс Монгол” компанийн санхүүгийн гүйлгээ ба олборлолтын асуудал ил тод бус байгаа нь Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (ББЗХ)-ийн Баялгийн засаглалын индексэд “хангалтгүй” оноо авснаас тодорхой харагдаж байна. Олборлох салбарын ил тод байдлын санаачилга (ОҮИТБС)-ын Баталгаажуулалтын тайланд[5] олборлох салбарын ТӨК-иуд нь санхүүгийн харилцаа, зарцуулалтын практик, засаглал зэрэг асуудлын хүрээнд ил тайлагналыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн. Түүнчлэн уул уурхайн ТӨК-иуд олон

[1] Уул уурхай, үйлдвэрийн яам. “Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл 2023.” Уул уурхай, үйлдвэрийн яам, 2023. www.mmhi.gov.mn/%d1%81%d0%b0%d0%bb%d0%b1%d0%b0%d1%80%d1%8b%d0%bd-%d1%81%d1%82%d0%b0%d1%82%d0%b8%d1%81%d1%82%d0%b8%d0%ba/.
[2] Үндэсний статистикийн хороо, “Үндэсний тооцоо.”
[3] Эндрю Бауэр, Намхайжанцангийн Дорждарь. "Барьцгүй өсөлт: Эрдэнэс Монголын үнэлгээ"
[4] Монгол Улсын Засгийн газар. “Эрдэнэт үйлдвэр, Монголросцветмет ТӨҮГ-ын тухай тогтоол.”
[5] ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар, “Монгол Улсын 2022 баталгаажуулалтын тайлан.”

жилийн туршид авлига, хээл хахуулийн асуудалд өртөж байна. Тухайлбал, “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал авлига авснаа хүлээж[6], ажлаасаа чөлөөлөгдсөн, “Эрдэнэс Монгол” компанийн охин компани, нүүрсний гол экспортлогч болох “Эрдэнэс Тавантолгой” компанийн гүйцэтгэх захирал асан эрх мэдлээ урвуулан ашигласан хэргээр[7] саяхан шийтгүүлсэн зэрэг жишээг дурдаж болно. “Нүүрсний хулгай” гэж нэрлэгдэх болсон дуулианы хүрээнд Улсын Их Хурал нь нүүрсний ТӨК-ийн борлуулалт, тээвэрлэлт, татварын төлбөрт гарсан зөрчил, төсвийн хөрөнгийг зориулалтаас гадуур зарцуулсан зэрэг ноцтой зөрчлийг илчилсэн нээлттэй сонсголыг 2023 оны 12 дугаар сард зохион байгуулсан. Олон тооны хоосон ачааны машин хилээр нэвтэрсэн гэж нээлттэй сонсголд оролцсон гэрчүүд мэдүүлсэн нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, татвар төлөхөөс зайлсхийсэн үйлдэл гэх хардлагыг төрүүлж байв. Ийм нөхцөлд ТӨК-ийн ил тод байдлыг сайжруулах, олон нийтийн хяналт тавихын ач холбогдол өндөр байх нь эргэлзээгүй юм.

ОҮИТБС нь олборлох салбарын сайн засаглалыг дэмжих түүчээлэгч санаачилга болохын хувьд ТӨК-ийн ил тод байдал нь эрдэс баялгийн ил тод байдал, сайн засаглалын үндэс суурь гэдгийг хүлээн зөвшөөрч ирсэн. Тухайлбал, ОҮИТБС-ын 2010 оны дүрэмд зааснаар ОҮИТБС-ын тайланд ТӨК-ийг оролцуулан бүх компанийг хамруулж, компаниудад хамаарах стандарт шаардлагуудыг хангахын сацуу ТӨК-иудын үйлдвэрлэлийн мэдээллийг тайлагнахыг тусгайлан заасан байдаг[8]. Уг дүрэм нь олон улсын стандарт болтлоо хөгжсөн бөгөөд 2023 онд шинэчлэгдсэн стандарт нь ТӨК-ийн ил тод байдал, төрийн оролцооны талаар илүү өргөн хүрээний, нарийвчилсан шаардлага, хүлээлтийг тусгасан байна. Тодруулбал, уг стандартад төрийн оролцоотой холбоотой ил тайлагналын зорилгыг ТӨК-ийн үйл ажиллагааны хамрах хүрээг тодорхойлох бөгөөд бүх компанийн мэдээллийг агуулах ОҮИТБС-ын үндэсний тайланд “шаардлага, дэмжлэг, хүлээлт” байдлаар тайлагнах мэдээллийн жагсаалтыг боловсруулахад оршино гэж тусгажээ.[9] Стандартын хамгийн сүүлийн хувилбарыг 2023 онд баталсан тул улс орнууд, түүн дотор Монгол Улс ОҮИТБС-ын үндэсний тайлан, ялангуяа ТӨК-ийн ил тайлагнал нь шинэ стандартын шаардлагуудад бүрэн нийцэж байгаа эсэхийг нягтлахын тулд дотоодын баримт бичиг, төлөвлөгөөгөө нягтлан үзэх шаардлага үүсэж байна.

---

[6] Эрдэнэс Монголын гүйцэтгэх захирал Д.Хаянхярваа авлига авснаа хүлээн зөвшөөрөв.
[7] Эрдэнэс Тавантолгой ХХК-ын гүйцэтгэх захирал асан Б.Ганхуяг, УИХ-ын гишүүн асан Т.Аюурсайхан нарыг цагдан хорив.
[8] ОҮИТБС-ын дүрэм 2010.”
[9] ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар. ОҮИТБС-ын 2023 оны стандарт.”

Монгол Улсад шинэтгэл хийж, ил тод байдлыг сайжруулах ажлын нэг нь ОҮИТБС болсны зэрэгцээ Засгийн газрын хэрэгжүүлж буй бусад санаачилга, арга хэмжээ нь ТӨК-ийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, мэдээллийг олон нийтэд зориулж нийтлэх ажлыг урагшлуулж байна. Тухайлбал, Монгол Улс Нээлттэй засгийн түншлэлийн гишүүнээр элсэж, энэ түншлэлийн хүрээнд Засгийн газар ТӨК-ийн ил тод байдлыг сайжруулах үүрэг амлалтыг авсан. Мөн энэ чиглэлд ахиц гаргасан хоёр хууль хэрэгжиж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль[10] нь Засгийн газар болон ТӨК-иас олон нийтэд хүргэх шаардлагатай мэдээллийн жагсаалтыг нарийвчлан тусгасан бол Шилэн дансны тухай хууль[11] нь төсвийн байгууллага, ТӨК-ийн талаар олон нийтэд мэдээлэх нэгдсэн тогтолцоог бүрдүүлж өгсөн. Тухайлбал, санхүүгийн өндөр нарийвчлалтай гүйлгээний өгөгдлийг шилэн дансанд байршуулснаар ТӨК-ийн санхүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх цоо шинэ боломж оролцогч бүх талуудын өмнө нээгдсэн.[12] Төрийн байгууллагуудын сайн засаглал, ил тод байдлыг хангахад хувь нэмрээ оруулж буй бас нэгэн чухал байгууллага бол Авлигатай тэмцэх газар (АТГ) юм. АТГ нь ТӨК-д нөлөөлж болох улс төрийн хөндлөнгийн оролцоог хязгаарлах, худалдан авах ажиллагааг оновчтой болгох, ил тод байдал болон мэдээллийг нийтлэх ажлыг сайжруулах, ногдол ашгийн бодлого зэрэг зорилго, бодлогын ойлгомжтой байдлыг нэмэгдүүлэх зорилготой Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.[13] Гэсэн хэдий ч эдгээр санаачилгуудын ихэнх нь олборлох салбарын засаглалын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хангалттай бус бөгөөд хоорондын уялдаа холбоо сул байна. Улмаар ОҮИТБС нь олон улсын стандарт болсон, хэрэгжүүлж буй арга зам тогтсон бөгөөд салбарын оролцогч талуудыг татан оролцуулдаг зэрэг давуу талаараа салбарын хувьд чухал байр суурийг эзэлсэн хэвээр байна. Энэхүү тайлан нь салбарын засаглалын нэг гол сэдэв болох ТӨК-ийн мэдээллийг ил тод нийтлэх, тайлагнахад төвлөрөх замаар Монголын ОҮИТБС-ыг шинэ шатад гаргах ажилд дэмжлэг өгч, ОҮИТБС-ын оролцогч талуудыг мэдээллээр хангахад чиглэсэн болно.

[10] Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
[11] Шилэн дансны тухай хууль
[12] Намхайжанцангийн Дорждарь. "Монголын төрийн өмчит уул уурхайн компаниуд: Шилэн дансны мэдээллийн гүнд
[13] УИХ. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030,” 2023. www.legalinfo.mn/mn/detail?lawId=16760139781851.

Зорилго

Энэхүү тойм судалгаа нь өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, Монгол Улсын олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй ТӨК-тай холбоотой мэдээллийг ил тод нийтлэх хууль эрх зүйн орчин, өнөөгийн туршлагыг судалж, Монгол Улс ОУИТБС-ын Стандартыг бүрэн мөрдөх, хэрэгжүүлэх, түүнчлэн ТӨК-иудад ил тод байдлын шаардлагыг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар, бусад оролцогч талуудын хэрэгжүүлэх ёстой арга хэмжээнд төвлөрсөн болно. Судалгааны үндсэн зорилго нь Монгол Улсын уул уурхайн ТӨК-иуд нь ОУИТБС-ын 2023 оны Стандарт, холбогдох бусад дүрэм, журмыг хангахгүй байгаа талбарыг тодорхойлж, эдгээр дутагдлыг арилгах талаар Монголын ОУИТБС-д зориулсан зөвлөмж боловсруулах явдал юм. Холбогдох баримт бичгийн судалгаа хийж, ОУИТБС-ын шаардлага болон стандартыг ТӨК-иуд үр дүнтэй мөрдөж байгаа эсэхэд, мөн тодорхой мэдээллийг ил тод нийтлэхэд тулгарч буй саад бэрхшээлд дүн шинжилгээ хийлээ. ББЗХ нь энэ судалгаагаар дамжуулан ТӨК-д тавьдаг шаардлага, хүлээлтийн талаарх ойлголтыг сайжруулах, мэдлэгийг гүнзгийрүүлэх, уг санаачилгын ач холбогдлыг харуулах, үр нөлөөг сайжруулахын тулд Монголын ОУИТБС-аас хэрэгжүүлж болох арга хэмжээний талаар санал дэвшүүлэх давхар зорилготой юм.

2. Судалгааны арга барил

Аргачлал

Судалгааны асуултыг дараах байдлаар тодорхойлж, холбогдох дүн шинжилгээг гүйцэтгэсэн болно. Үүнд:

- ОУИТБС-ын 2023 оны стандартын дагуу уул уурхайн ТӨК ямар мэдээллийг ил тод нийтлэх шаардлагатай эсхүл нийтэлбэл зохих вэ?
- Монгол Улсад ТӨК-ийн мэдээллийг ил тод болгохыг зохицуулдаг хууль эрх зүйн ямар шаардлага, үүрэг үйлчилж байна вэ? ОУИТБС-ын Стандартаас зөрсөн эсхүл давхцаж буй ямар асуудлууд байна вэ?
- Монгол дахь ТӨК-ийн ил тайлагналын өнөөгийн практик нь ОУИТБС-ын 2023 оны стандарттай хэрхэн нийцэж байна вэ? Ямар нэгэн ялгаатай байдал эсхүл саад тотгор байна уу?

Эдгээр асуултын хариултад үндэслэн оршин буй саад тотгор, мөн тулгарч буй бэрхшээлийг даван туулах, шийдвэрлэх зөвлөмжийг Монгол дахь ОУИТБС-ын оролцогч талуудад зориулан боловсруулаа.

Судалгаанд олон арга хэрэгслийг хамтад нь ашиглах аргачлалыг хэрэглэсэн болно. Баримт бичгийн судалгаанаас гадна мэргэжилтэн, оролцогч талуудтай ярилцлага хийх замаар мэдээлэл, тоо баримт цуглуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аргыг ашигласан. Цуглуулсан мэдээлэл, тоо баримтад чанарын болон тоон дүн шинжилгээ хийх арга хэрэгслийг мөн хэрэглэсэн. Жишээлбэл:

- ОҮИТБС-аас гаргасан жилийн төлөвлөгөө, тайланг өргөн хүрээнд нягталснаас гадна холбогдох судалгаа, эх сурвалж, тайлан, ОҮИТБС-ын стандартын заавар, шаардлага, хууль эрх зүйн баримт бичгийг нарийвчлан судалж үзсэн. Энэхүү өргөн хүрээнд хийсэн баримт бичгийн судалгаа нь дүн шинжилгээ хийх үндэс болж, Монгол дахь олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТӨК-ийн ил тайлагналын талаар гүнзгий ойлголт өгсөн.
- Олборлох салбарын ТӨК-ийн ил тайлагналын талаар цогц ойлголттой болохын тулд төрийн албан хаагчид зэрэг чухал оролцогч талуудтай ярилцлага хийж, санал солилцсон нь хууль эрх зүйн орчин, зохицуулалтын орчны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. ОҮИТБС-ын Ажлын албатай хамтран ажилласнаар ОҮИТБС-ын Стандарт, шилдэг туршлага, мөн ТӨК-ийн ил тайлагналын талаар одоог хүртэл гүйцэтгэсэн ажлын тухай түүхэн мэдээлэл, өнөөгийн тэргүүлэх чиглэл, сорилтын талаар үнэ цэнтэй мэдээллийг олж авсан болно. Мөн ТӨК-ийн мэдээллийг ил тод болгох талаар иргэний нийгмийн байгууллагууд болон салбарын төлөөлөлтэй зөвлөлдөж, тэдний санал бодол, хийж ирсэн ажлыг судалсан. Эдгээр оролцогч талуудаас олж авсан мэдээлэл нь судалгааны тайланд олон ургалч үзэл бодол, туршлагыг тусгах боломжийг олгож, дүн шинжилгээг баяжуулсан болно.

Хамрах хүрээ

Дээр дурдсан судалгааны арга нь ТӨК-ийн нөхцөл байдал, өнөөгийн бодлого, хууль эрх зүйн орчныг ойлгох, тогтсон болон шинээр гарч ирж буй практикийг судлах, Монгол дахь олборлох салбарын ТӨК-ийн талаарх мэдээллийг ил тод болгоход тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлоход тустай байв.

Харин судалгаа нь уул уурхайн ТӨК-тай холбоотой бодлогын тодорхой асуудлыг үнэлэх эсхүл уул уурхайн салбар дах төрийн оролцооны асуудлаар тодорхой байр суурийг илэрхийлэхийг зориогүй болно.

ОҮИТБС-ын Стандарт, дотоодын болон олон улсын зохицуулалт, Засгийн газрын үүрэг амлалт, ОҮИТБС-ын хүрээнд ил тайлагнах өнөөгийн практик болон бусад санаачилгад анхаарлаа хандуулж судалгааг гүйцэтгэлээ.

ОҮИТБС-ын Стандарт нь оролцогч талуудын хүлээсэн үүрэг, тэдэнд тавих шаардлага, зөвлөмж, мөн ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх үйл явц, засаглалын механизмыг тусгасан дүрмийн багц юм. ОҮИТБС-ын Стандарт гурван хэсгээс бүрддэг. Эхний хэсэгт ОҮИТБС-ын зарчим, хэрэгжүүлэгч улс орнууд ба олборлогч компаниудад тавих шаардлага, хүлээх хүлээлтээс гадна иргэний нийгмийн оролцоо болон нээлттэй өгөгдөлтэй холбоотой бодлогын баримт бичгийг агуулдаг. Хоёр дахь хэсэг нь ОҮИТБС-ын Стандартыг тогтоох, хэрэгжүүлэх, хянах асуудлыг авч үздэг бөгөөд үүнд удирдах хороо, баталгаажуулалтын асуудлыг авч үзсэн байдаг. Баримт бичгийн гурав дахь хэсэгт ОҮИТБС-ын засаглал, удирдлагатай холбоотой асуудлыг тусгасан болно. Энэхүү судалгааны хүрээнд ОҮИТБС-ын 2023 оны стандартын зөвхөн эхний хэсэг хамааралтай болно.

Сайн засаглалыг дэмжих олон улсын санаачилгуудын нэг нь Нээлттэй засгийн түншлэл[14] бөгөөд засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн үүрэг, амлалт боловсруулахыг гишүүн улс орнуудаас шаарддаг. Монгол Улс 2013 онд гишүүнээр элссэн бөгөөд 2023 онд авч буй үүрэг, амлалтын шинэ хувилбараа зарласан. Эдгээр амлалтад ОҮИТБС-ын үйл явцыг хуульчлах, ТӨК-ийн ил тод байдлыг сайжруулах зэрэг олон асуудал багтсан болно.

Олон улсын түвшинд хүлээсэн эдгээр үүргийн зэрэгцээ Монгол Улс нь ТӨК-ийн засаглал, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн олон хууль, тогтоомжтой бөгөөд үүнд өмнө дурдсанчлан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль,[15] Шилэн дансны тухай хууль[16] зэргийг нэрлэж болно. Эхний хууль нь олон нийтэд нээлттэй байх ёстой мэдээллийн жагсаалтыг баталсан бол Шилэн дансны тухай хууль нь төсвийн байгууллага, ТӨК нь мэдээллийг хэрхэн ил тод нийтлэх үйл явцыг дэлгэрэнгүй тодорхойлсон. Хууль тогтоогч байгууллага болох Улсын Их Хурал (УИХ) хууль батлахаас гадна улсын эдийн засаг, нийгмийн амьдралтай холбоотой олон асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй. УИХ-аас баталсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг Засгийн газрын гишүүд буюу яам, төсвийг захирагч нараас бүрдсэн Монгол Улсын гүйцэтгэх засаглал буюу Засгийн газар хариуцдаг. УИХ-аас баталсан

[14] Нээлттэй засгийн түншлэл. “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө.”
[15] Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль.
[16] Шилэн дансны тухай хууль.

бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар тогтоол гаргадаг. Салбарын яам, төрийн агентлаг нь дээд түвшний бодлого тодорхойлогч байгууллагуудын шийдвэрийг тодорхой болгох, хэрэгжүүлэхэд чиглэсэн тушаал шийдвэр гаргадаг.

Олон улсын стандарт, хэм хэмжээ нь ихэвчлэн ТӨК-ийн үйл ажиллагааны талаар тухайн компани эсхүл засгийн газраас хүлээгдэж буй ил мэдээллийн доод босгыг илэрхийлдэг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Зарим ТӨК эдгээр стандарт, хэм хэмжээ, заримдаа бүр дотоодын хууль тогтоомжийн шаардлагын босгоос давж, ил тод байдлаа бэхжүүлэх арга хэмжээ авдаг. Тухайлбал, нүүрсний олборлогч, экспортлогч, төрийн өмчийн оролцоотой “Эрдэнэс Тавантолгой” компани нь өөрийн худалдан авагч, ханган нийлүүлэгч, тээвэрлэгчийн талаарх мэдээллийг ОҮИТБС болон дотоодын хууль тогтоомжийн хүлээлтээс давсан түвшинд ил тод болгоход ахиц гарган ажиллаж байна. Гэвч энэ нь онцгой тохиолдол бөгөөд салбарын хэмжээнд практик болж хэвшээгүй байна.

Нэлээд өргөн хүрээний эх сурвалжид үндэслэж тодорхой ТӨК-иудыг сонгон, энэ судалгааны хүрээнд мэдээллийн ил тод байдлыг нь нарийвчлан судаллаа. Монгол Улсын олборлох салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ТӨК-ийн жагсаалт нь эх сурвалж бүрд ялгаатай, өөр өөр байгааг тэмдэглэх нь зүйтэй. ТӨК-ийн жагсаалтын эхний эх сурвалж нь ОҮИТБС-ын 2021, 2022 онуудын нэгтгэл тайлан байв. ОҮИТБС-ын тайлангаа илгээсэн компаниудын цөөн хэсгийг материаллаг байдлын босго дээр үндэслэн нэгтгэлд хамруулдаг. Тухайлбал, Засгийн газраас 2022 онд нийт 1,184 аж ахуйн нэгжийн тайлан ирүүлснээс 104 аж ахуйн нэгжийн тайланг нэгтгэл тайланд хамруулсан. Ингэхдээ тухайн компанийн төлбөрийн материаллаг байдлыг чухалчилдаг бөгөөд өмчлөлийн хэлбэр буюу төрийн өмчит эсэхийг харгалзан үзэлгүйгээр нэгтгэлд хамруулах компанийг сонгож байна. 104 компанийн 13 нь төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж бөгөөд эдгээр 13 нь бидний судалгааны зорилтот компаниуд юм. Мөн Хавсралт 5-т үзүүлсэн уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ТӨК-ийн дэлгэрэнгүй жагсаалтыг гаргахын тулд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Эрдэнэс Монгол” холдинг компанийн тайлан, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг судалж үзсэн болно.

Уул уурхайн ТӨК-иуд Монгол Улсын эдийн засагт олон чухал үүргийг гүйцэтгэдэг. Сүүлийн жилүүдэд эдгээр ТӨК-ийн удирдлагыг харьяа компаниуддаа менежментийн үйлчилгээ үзүүлэх байдлаар ажилладаг “Эрдэнэс Монгол” холдинг компанийн мэдэлд үе шаттайгаар шилжүүлсэн. “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэт”, “Багануур”, “Шивээ-Овоо”,

Монгол Улсын олборлох салбарын төрийн өмчит компаниудын ил тайлагналын тойм судалгаа

“Монголросцветмет” зэрэг охин компаниудын зарим нь стратегийн ордод хамаарах уул уурхайн томоохон төслийг хэрэгжүүлдэг. Зарим харьяа компаниуд нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй хамтран тодорхой төслийг удирдаж, үйл ажиллагааг нь хариуцдаг. Жишээлбэл, “Эрдэнэс Оюутолгой” компани нь үндэстэн дамнасан Рио Тинто компанитай хамтран Оюу Толгой компанийн хувийг эзэмшдэг. Мөн Францын Орано компанитай хамтрах замаар Бадрах Энержи-д болон бусад компанид хувьцаа эзэмшдэг Мон-Атом компанийг нэрлэж болно. Эрдэнэс Метан, Метан Газ Ресурс, Эрдэнэс Баянбогд зэрэг цөөн хэдэн харьяа компани хэд хэдэн төрлийн ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулдаг. Бусад компаниудын хувьд боловсруулалтын чиглэлийн Монгол газрын тос боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн үйлчилгээг хангах Гашуун сухайтын зам, санхүүгийн үйлчилгээг хангах Эрдэнэс ашид зэргийг дурдаж болно. ТӨК нь томоохон татвар төлөгч байгаад зогсохгүй олборлох салбарт эсхүл уул уурхай, хайгуулын үйл ажиллагаатай холбоогүй Засгийн газрын янз бүрийн төсөл хөтөлбөрт хувь нэмэр оруулдаг. Эрдэнэс Монгол компани нь Монголын түүхий эдийн бирж, нэг тэрбум мод тарих санаачилга, нийгмийн бусад хөтөлбөрийг дэмжиж ирсэн. ТӨК-ийг хөрөнгө оруулагчдад Монгол Улсыг гадаадад сурталчлах хэрэгсэл, гадаадын хөрөнгө оруулагчидтай хэлцэл хийх мэдлэгийн төв гэж үзэх нь бий. Зарим бүс нутагт уул уурхайн ТӨК нь хамгийн том ажил олгогч болж, орон нутгийн иргэдэд дэд бүтэц болон бусад үйлчилгээг давхар үзүүлдэг. Товчхондоо улс орны эдийн засаг, орон нутгийн иргэдийн нийгмийн амьдралд ТӨК-ийн гүйцэтгэх үүрэг асар их юм.

ТӨК-ийн засаглал сүүлийн жилүүдэд өөрчлөгдөж байгаа бөгөөд тухайлбал уул уурхайн ихэнх ТӨК-ийн хувьцааг “Эрдэнэс Монгол” болон түүний харьяа компаниудад шилжүүлсэн. Үүнээс өмнө яамд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар зэрэг төрийн байгууллага ТӨК-ийн хувьцааг албан ёсоор эзэмших нь элбэг байв. Түүнчлэн яамд, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Эрдэнэс Монгол нэгдэл зэрэг төрийн байгууллага болон компаниудыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдээр Засгийн газрын зүгээс томилдог. Хувьцаа эзэмшигчид нь ТӨК-ийн удирдах зөвлөлд өөрсдийн төлөөллийг томилдог бөгөөд тэдгээр төлөөлөл нь засгийн газар эсхүл хувьцаа эзэмшигчдийн нэрийн өмнөөс компанийн үйл ажиллагаатай холбоотой албан ёсны шийдвэрийг гаргадаг. Хувьцаа эзэмшигчид төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд чухал асуудлаар санал өгөх талаар удирдамж өгдөг. Удирдах зөвлөлийн гишүүд нь ихэвчлэн янз бүрийн яам, агентлагийн төрийн албан хаагчид байдаг ч ТӨК-ууд төлөөлөн удирдах зөвлөлдөө хараат бус гишүүдийг урьж оролцуулах хандлага нэмэгдэж байна.

3. Судалгааны үр дүн

Энэ хэсэгт Монголын уул уурхайн салбарт ТӨК-ийн гүйцэтгэж буй үүрэг, тэдгээрийн ил тайлагнал, ил тод байдлын талаар судалсан үр дүнгээ толилуулж байна. Уул уурхайн салбарын ТӨК-д хамаарах ОҮИТБС-ын стандарт шаардлагын бүтцийг ашиглах замаар ТӨК-ийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг, уул уурхайн ТӨК-ийн ил тод байдал, тайлагналын стандарт, практик байдлыг нягталсан болно. Шаардлага тус бүрд тусгасан тодорхой асуудлыг ОҮИТБС-ын жилийн тайланд хамруулсан эсэх, дотоодын болон олон улсын зохицуулалт, Засгийн газрын үүрэг, амлалт нь эдгээр шаардлагын биелэлтийг дэмжиж байгаа эсэхийг судалж, дүгнэв. Уул уурхайн ТӨК-ийн ил тод байдал, тайлагналын өнөөгийн практикийг төгсгөлд нь үнэлж тайлбарлав.

Олборлох салбарын ТӨК-ийн ил тайлагналын шаардлага

Дээр дурдсанчлан олборлох салбарын ТӨК-ийн ил тайлагналд төвлөрсөн олон улсын болон дотоодын хэд хэдэн хэм хэмжээ сүүлийн жилүүдэд шинээр мөрдөгдөж байна. Энэ бүлэгт ТӨК-ийн ил тайлагналтай холбоотой ОҮИТБС-ын шаардлагыг дэлгэрэнгүй танилцуулах бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай болон Шилэн дансны тухай хоёр гол хуульд тусгасан шаардлагыг мөн хэлэлцэх болно.

ОҮИТБС нь долоон багц шаардлага тавьдаг бөгөөд үүнээс зургаа нь ТӨК-ийн ил тайлагналтай шууд болон шууд бусаар холбоотой заалт агуулдаг. Дараах Хүснэгт 1-д харуулсны дагуу эдгээр заалтуудыг “тайлагнах шаардлагатай, тайлагнахыг хүлээж байгаа, тайлахыг дэмжиж байгаа” гэсэн ангиллаар харуулав. ОҮИТБС-ын Стандартын ТӨК-ийн ил тайлагналтай холбоотой дийлэнх шаардлага нь хууль эрх зүйн орчин, гэрээ болон тусгай зөвшөөрөл, орлого бүрдүүлэлт зэрэг сэдэвтэй холбоотой байна. Эдгээрээс 16 нь тайлагнах шаардлагатай, 4 нь тайлагнах хүлээлттэй, 15 нь тайлагнахыг дэмжсэн заалтууд байна. ОҮИТБС-ын Стандартын шаардлагын жагсаалтыг Хавсралт 2-д харуулав. ОҮИТБС нь Стандартын дагуу бүхэлдээ төрийн өмчит болон төр дийлэнх хувийг эзэмшдэг компаниудыг ил тод байдлын шаардлагад хамруулдаг бөгөөд төр аль нэг компанид жижиг хувьцаа эзэмшигч бол ТӨК-тай холбоотой ил тод байдлын шаардлагыг бүхэлд нь эсхүл заримыг нь тайлагнахгүй байх нөхцөл үүсэх юм.

Хүснэгт 1. ОҮИТБС-ын Стандартын шаардлага ба тэдгээрийн түвшин

Шаардлагын түвшин		Шаардлагын тоо
Шаардлага 1. Олон талт оролцогчдын бүлгийн зүгээс тавих хяналт		
	Шаардлагатай	1
	Хүлээж байгаа	1
		2
Дүн		
Шаардлага 2. Эрх зүйн болон институтийн тогтолцоо, гэрээ, тусгай зөвшөөрөл		
	Шаардлагатай	8
	Хүлээж байгаа	1
	Дэмжиж байгаа	4
Дүн		13
Шаардлага 3. Хайгуул ба бүтээгдэхүүн үйлдвэрлэл		
	Дэмжиж байгаа	5
Дүн		5
Шаардлага 4. Орлого төвлөрүүлэлт		
	Шаардлагатай	4
	Хүлээж байгаа	2
	Дэмжиж байгаа	3
Дүн		9
Шаардлага 5. Орлогын менежмент ба зарцуулалт		
	Дэмжиж байгаа	1
Дүн		1
Шаардлага 6. Нийгэм ба эдийн засгийн зардал		
	Шаардлагатай	3
	Дэмжиж байгаа	2
Дүн		5

ОҮИТБС-ын дагуу Монгол Улсын мөрдөх ёстой олон шаардлага байгаа учраас эдгээрийн алийг нь биелүүлээд байгаа, харин алийг нь биелүүлэхийн тулд ОҮИТБС-ын Олон талт оролцогчдын бүлэг чармайлт гарган ажиллах ёстойг зааглах нь чухал юм. Үүний тулд ТӨК-ийн ил тод байдлыг тодорхойлдог дотоодын хууль тогтоомж болон практикийг судлах нь зүйтэй. ТӨК-ийн асуудлыг зохицуулдаг хэд хэдэн хууль тогтоомж байдгаас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай (2021), Шилэн дансны тухай (2014) гэсэн хоёр хууль ТӨК-ийн ил тайлагналтай ихээхэн холбоотой юм. ОҮИТБС-ын стандарт шаардлагын нэлээд нь эдгээр хуулийн хүрээнд нэгэнт зохицуулагдаж байгаа.

Шилэн дансны хууль нь төсвийн бүх байгууллага, мөн төрийн өмчит дийлэнх аж ахуйн нэгжийн олон нийтэд зориулж нийтлэх ёстой үйл ажиллагааны болон санхүүгийн баримт бичгийн жагсаалтыг тодорхойлсон гэдэг утгаараа төрийн ил тод, хариуцлагатай байдлыг эрс шинэчилсэн санаачилга байв. Засгийн газар нь Сангийн яамаар дамжуулж ил тод нийтлэх баримт бичгийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, ил тод байдлаа тайлагнах ёстой төрийн байгууллага бүр өөрийн веб хуудас дээр Шилэн данс гэсэн бие даасан цэс үүсгэсэн. Гэвч зарим нэгэн ТӨК энэ хуулийн хүрээнд хамардаггүй буюу хуулийн хүрээ нь хязгаарлагдмал байна. Тухайлбал, бүхэлдээ эсхүл дийлэнх хувийг нь төр эзэмшдэг компаниуд эсхүл орон

нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд л энэ хуулийн шаардлагыг мөрддөг. Энэ хамрах хүрээ нь ОУИТБС-ын Стандарттай төстэй бөгөөд төр үнийн хувьд өндөр дүнтэй ч цөөнх хувийг эзэмшдэг Оюу Толгой зэрэг уул уурхайн чухал компаниуд хуулийн үйлчлэлд хамрахгүй байж мэдээллээ ил тод нийтлэхгүй байна.

Шилэн дансны хүрээнд ТӨК нь 14 төрлийн мэдээллийг нийтлэх ёстой бөгөөд эдгээрийн дийлэнх нь Хүснэгт 2-д харуулсны дагуу компанийн төсөв, санхүүгийн байдалтай холбоотой мэдээлэл юм. Шилэн дансны тухай хуулийн хүрээнд ТӨК-ийн нийтэд зориулж нийтлэх ёстой шаардлагын бүрэн жагсаалтыг Хавсралт 3-д харуулав.

Хүснэгт 2. Шилэн дансны дагуу нийтлэх ёстой мэдээллийн төрөл

	Мэдээллийн төрөл	**Шаардсан мэдээллийн тоо**
1.	Санхүү	11
2.	Төсөв	8
3.	Гэрээлэгч	5
4.	Үйл явц	5
5.	Нэмэлт өөрчлөлт	2
6.	Аудит	2
7.	Гэрээ	1
8.	Үйл ажиллагаа	1
9.	Борлуулалт	1
10.	Нийгэм	1
	Нийт	37

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг 2021 онд батлахдаа төрийн байгууллага, ТӨК-ууд нээлттэй мэдээлэх ёстой тодорхой баримт бичгийн жагсаалтыг хуульчилсан нь мэдээллийг нийтлэх журамд түлхүү анхаарсан Шилэн дансны хуулийн хамрахгүй орон зайг нөхөж, олон нийтэд ил хүргэх ёстой тодорхой мэдээллийн агуулгад анхаарсан юм. Олон нийтэд зориулж дэлгэх шаардлагатай мэдээллийн урт жагсаалтаас ТӨК-тэй холбоотой 88 асуудлыг хамарсан 40 гаруй төрлийн мэдээллийг энэ хуулийн дагуу ТӨК-ууд ил тод нийтлэх үүрэгтэй байна. Шилэн дансны хуультай харьцуулахад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль нь ТӨК-ийн дотоод бүтэц, үйл ажиллагаа, засаглалтай холбоотой илүү олон тооны мэдээллийг ил тод болгох шаардлагыг тавьдаг (Хүснэгт 3). Тухайн хуулиар нийтлэх ёстой мэдээллийн бүрэн жагсаалтыг Хавсралт 4-д харуулав.

Хүснэгт 3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу шаарддаг мэдээллийн төрөл

	Мэдээллийн төрөл	**Шаардсан мэдээллийн тоо**
1.	Бүтэц	18
2.	Үйл ажиллагаа	15
3.	Санхүү	11
4.	Засаглал	11
5.	Төсөв	5
6.	Гэрээлэгч	5
7.	Аудит	4
8.	Байгаль орчин	4
9.	Гэрээ	3
10.	Нийгэм	3
11.	Төсөв	2
12.	Хувь эзэмшил	2
13.	ТӨК-ийн үүрэг	2
14.	Эзэмшил	1
15.	Төсөл	1
16.	Тээвэр	1
	Нийт	88

ОҮИТБС-ын Стандарт болон энд тайлбарласан хоёр хууль хамтдаа Монгол Улсын ТӨК-ийн ил тод байдлыг хангах нэлээд бат бөх суурийг бүрдүүлж байна.

Холбогдох бүх ТӨК-иуд мэдээллээ ил тод нийтэлдэг үү?

ОҮИТБС-ын Стандартын дийлэнх хэсэг нь олборлох салбарын компаниудад ерөнхийд нь хамаатай бөгөөд хувийн болон төрийн өмчит компанийг хооронд нь ялган заагладаггүй. Жишээлбэл “компаниуд ОҮИТБС-ын бүх үйл явцад бүрэн, идэвхтэй, үр нөлөөтэй оролцох ёстой” гэсэн шаардлага нь салбарын бүх компанид хамаарах буюу төрийн өмчит болон хувийн компанийн аль алинд нь үйлчилнэ гэсэн үг юм. Гэвч олон улсад болоод Монголд олон янзын ТӨК ажилладаг бөгөөд хуулийн этгээдийн болон үйл ажиллагааны хувьд маш олон төрөлд хуваагддаг. Дотоодын хууль тогтоомжийн хувьд бүх аж ахуйн нэгжийг тодорхой мэдээллээ нээлттэй болгохыг үүрэг болгодог хэдий ч ТӨК-иудад ил тод байдлын нэмэлт шаардлага тавигддаг. Түүнчлэн зарим ТӨК-д тавьдаг ил тод байдлын шаардлага нь заримд нь хамаарахгүй харин хуулийн этгээдийн төрөл, үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж, тодорхой хэсэгт нь үйлчилж болно. Жишээлбэл Шилэн дансны тухай хууль нь төрийн өмчит болон төр дийлэнх хувийг эзэмшиж буй компаниудыг санхүүгийн тайлангаа шилэнд дансаар тайлагнахыг шаарддаг бөгөөд харин төр цөөн хувьцаа эзэмшдэг бол тайлагнах шаардлага тавьдаггүй.

ОҮИТБС-ын Стандарт нь “засгийн газрыг төлөөлөн олборлох үйл ажиллагаа эрхэлдэг, төрийн өмчит эсхүл төр дийлэнх хувийг эзэмшиж буй компани” гэж ТӨК-ийг тодорхойлдог. Дотоодын

олон талт оролцогчдын бүлэг нь энэ тодорхойлолтод үндэслэж, мөн дотоодын хууль тогтоомжийн онцлогийг харгалзан ТӨК-ийн талаарх өөрийн тодорхойлолтыг гаргахыг ОҮИТБС-аас зөвлөдөг.[17] "Төр дийлэнх хувийг эзэмшиж буй компани" гэдэг нэр томьёо нь төр 50-аас багагүй хувийг тухайн компанид эзэмших тохиолдол байж болох ч зарим нэг тодорхойлолтод төр бусад хувьцаа эзэмшигчдээс илүү хувь эзэмших тохиолдлыг ойлгох нь бий. Ийм учраас "Төр дийлэнх хувийг эзэмшиж буй компани" гэдэг нэр томьёо нь ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд ямар утгатай болохыг хэлэлцэж, тодорхойлох нь оролцогч талуудын дунд зөрүүтэй ойлголт үүсэхээс сэргийлж, тэдний хүлээлтийг нэг мөр болгох юм.

Судалгааны явцад ОҮИТБС-ын тайланд зориулж дотоодын ТӨК-ийн нэр томьёог тодорхойлж, хэлэлцсэн баримт олоогүй боловч ОҮИТБС-ын нэгтгэл тайланд Монгол Улсад мөрддөг ТӨК-ийн хэд хэдэн төрлийг дурдсан байна.[18] Гэвч уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг бүх ТӨК-ийг энэ тайланд хамруулаагүй бөгөөд ОҮИТБС-ын тайлангуудад дурдсан компанийн жагсаалт нь энэ салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ТӨК-ийг жагсаасан бусад эх сурвалжийн мэдээллээс зөрж байна. Эдгээр ТӨК-ийн олонх нь хайгуул эсхүл олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэггүй учраас ОҮИТБС-ын тайланд хамаарахгүй байж болох ч үүнийг тодорхой болгож, тайлбарлах нь зүйтэй юм. ОҮИТБС-ын тайланд болон бусад эх сурвалжаас авсан ТӨК-ийн бүрэн жагсаалтыг Хавсралт 5-д нэгтгэв. Харин ОҮИТБС-ын дагуу тайлагнасан болон тайлагнаагүй ТӨК-ийн нэгтгэсэн жагсаалтыг Хүснэгт 4-д ангилж харуулав.

Хүснэгт 4. ТӨК, үйл ажиллагааны чиглэл болон ОҮИТБС-ын нэгтгэлийн төрлөөр

Үйл ажиллагааны чиглэл	**Олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ТӨК-ийн жагсаалт**
Холдинг	**Эрдэнэс Монгол**
Олборлолт	**Адуунчулуун, Багануур, Баянтээг**, Эрдэнэс Алт Ресурс, Эрдэнэт Оюу Толгой, **Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэт, Могойн гол, Монголросцветмет, Оюу Толгой**, Сэлэнгэ байгалийн нөөц, **Шивээ-Овоо, Таван Толгой**
Хайгуул	**Бадрах Энержи**, Баян Хишиг Хараа, Эрдэнэс Баянбогд, Эрдэнэс Метан, Гурван сайхан, Метан Газ Ресурс, Мон-Атом, Мончех Ураниум
Боловсруулалт	**Дарханы төмөрлөгийн үйлдвэр**, Эрдэнэс Стийл, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр, Таван толгой түлш
Үйлчилгээ	Багануур Илч, Эрдэнэт медикал эмнэлэг, Эрдэнэт минерал солюшн, Шивээ сервис

[17] ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар. ОҮИТБС-ын 2023 оны стандарт, Хуудас 21.
[18] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. Монголын ОҮИТБС-ын 2022 оны баталгаажуулалтын тайлан. Хуудас 107.

Монгол Улсын олборлох салбарын төрийн өмчит компаниудын ил тайлагналын тойм судалгаа

Үйл ажиллагааны чиглэл	**Олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ТӨК-ийн жагсаалт**
Дэд бүтэц	**Цемент шохой**, Эрдэнэс Шивээ Энержи, Эрдэнэс үйлдвэрлэл, технологийн парк, Гашуун сухайт авто зам, Уул уурхайн бирж, Мон Цахим, Таван толгой төмөр зам, **Улаанбаатар төмөр зам**
Санхүү	Эрдэнэс ашид, Эрдэнэс ассет менежмент
Тодруулсан компаниуд нь ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэл тайланд багтсан. Эх сурвалж: ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэл тайлан, Эрдэнэс Монгол ХХК-ийн вэбсайт	

Монгол Улсын ТӨК-ийн асуудлыг зохицуулдаг гол хуульд төрийн өмчит аж ахуйн нэгж болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг ялгаатай тодорхойлдог. Төрийн өмчит аж ахуйн нэгж гэдэг нь төр дангаараа өмчилдөг, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажилладаг, төрийн өмчит аж ахуйн нэгж гэсэн хуулийн томьёололтой бөгөөд Төр болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу зохицуулагддаг. Судалгаанд энэ нэр томьёог төрийн өмчит компанийн хуулийн хэлбэрийг тайлбарлахдаа хэрэглэхээс гадна бүх төрийн өмчит хуулийн этгээдийг ерөнхийд нь тайлбарлахад ашигласан болно. Төрийн өмчийн оролцоотой эсхүл төр хувь эзэмшдэг хуулийн этгээдийг хязгаарлагдмал хариуцлагатай компани, хувьцаат компани хэлбэртэй байгуулдаг бөгөөд Компанийн тухай хуулийн дагуу зохицуулдаг.

Төрийн өмчлөлийг тодорхойлоход гардаг өөр нэгэн ярвигтай асуудал бол төр болон орон нутгийн өмчлөлийн зааг юм. Зарим уул уурхайн компанийг орон нутгийн удирдлага өмчилдөг тул “орон нутгийн өмчит” гэж тодорхойлон, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал эдгээр компанийг хянадаг. Энэ нь Өмнөговь аймагт үйл ажиллагаа эрхэлж, асар их хэмжээний нүүрс экспортлон, аймгийн эдийн засагт чухал нөлөөтэй байдаг Таван Толгой зэрэг орон нутгийн өмчийн компанийн хувьд маш чухал асуудал юм. Орон нутгийн өмчит бүх компаниуд Таван Толгой шиг хэмжээний үйлдвэрлэл, экспорт эрхэлдэггүй байсан ч аймгийн эдийн засаг, орон нутгийн иргэдийн хувьд нэлээд чухал нөлөөтэй байх магадлалтай тул ОҮИТБС нь орон нутгийн түвшинд хүрч ажилладаг чухал санаачилга болохын хувьд эдгээр компанийг хамруулан ажиллах ёстой.

ТӨК нь Монголын уул уурхайн салбарт ихээхэн ач холбогдолтой нь тодорхой боловч энэ салбарт нийт хэдэн ТӨК үйл ажиллагаа эрхэлж байгаа нь хүртэл тодорхой биш байна. Засгийн газрын албан ёсны статистик мэдээллийг нэгтгэдэг хуулийн этгээдийн бүртгэлд энэ салбарт үйл ажиллагаа эрхэлж буй төрийн болон орон нутгийн өмчит зөвхөн зургаан

компани байна.[19] Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтыг хариуцдаг засгийн газар агентлагийн мэдээлснээр төрийн өмчит холдинг компани болох Эрдэнэс Монголын эзэмшлийн 12 компани, Эрдэнэс Монголын харьяаллаас гадна дөрвөн компани[20] байна. Эрдэнэс Монгол нэгдэл жилийн санхүүгийн тайландаа 14 компанийг эзэмшдэг холдинг гэж тайлагнасан байна. Харин өөрийн вэбсайтад тус нэгдэл тодорхой хувийг нь эзэмшдэг, төсөл хэрэгжүүлдэг, мөн уул уурхайн хайгуул, олборлолтоос гадуур бусад салбарт туслах үйлчилгээ[21] үзүүлдэг 17 компанийг[22] дурдсан байна. ОҮИТБС-ын нэгтгэл тайлан дах ТӨК-ийн жагсаалтад найман компани байгаа бөгөөд нэгтгэл тайлангийн хавсралтад ТӨК-ийн жагсаалтыг нийтлээгүй боловч Шилэн дансны хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит 12 компанийн[23] мэдээллийн ил тод байдалд дүн шинжилгээ хийсэн байна.

Түүнчлэн Монгол Улсын ОҮИТБС-ын 2022 оны баталгаажуулалтын тайланд үнэлснээр 2020 оны тайланд 20 ТӨК-ийг багтаасан, нэгтгэл тайланд эдгээр 20 компанийн тайлбарыг оруулсан боловч зөвхөн таван компанийг нэгтгэл тайланд оруулсан байна. Жил бүрийн тайланд ялгаатай мэдээлэл оруулж буй нь компанийн нөхцөл байдал өөрчлөгдөх, шинэ компани байгуулагдах, зарим тохиолдолд шүүхийн шийдвэр биелүүлэх газар (цагдан хорих анги) гэх мэт төрийн байгууллагыг барилгын материал олборлох уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч гэдэг утгаар нь ТӨК хэмээн ОҮИТБС-ын хүрээнд тайлагнахтай холбоотой байх магадлалтай байна.

Ийм нөхцөлд уул уурхайн салбарын ТӨК-ийн тодорхой жагсаалтыг гаргах, улмаар ОҮИТБС-ын хүрээнд нийтлэхийн тулд жагсаалтын шалгуурыг боловсруулах тусгай хэлэлцүүлгийг Монгол Улсын ОҮИТБС-ын зүгээс зохион байгуулах шаардлагатай. ОҮИТБС-ын жилийн нэгтгэл тайланд компаниудыг бүхэлдээ төрийн өмчит болон төр дийлэнх хувийг эзэмшдэг гэж нарийн зааглан тайлагнах нь зүйтэй.

ТӨК ямар мэдээллийг ил тод нийтлэх ёстой вэ?

ОҮИТБС-ын Стандарт нь ТӨК-ийн ил тод байдлын талаар тайлагнах ёстой, тайлагнах хүлээлттэй, тайлагнахыг дэмжих гэж ангилсан шаардлагуудыг хэрэгжүүлэгч улс орнуудад тавьдаг. Эдгээрийн зарим нь олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бүх компанид

[19] Үндэсний статистикийн хороо, Хуулийн этгээдийн бүртгэл
[20] Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 оны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.
[21] Эрдэнэс Монгол нэгдлийн санхүүгийн тайлан. 2022.
[22] Эрдэнэс Монгол вэбсайт.
[23] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба, "Монголын ОҮИТБС-ын санаачилгын 2022 оны нэгтгэл тайлан.

хамааралтай бол зарим нь зөвхөн ТӨК-т хамаардаг. Энэ хэсэгт ТӨК-т хамааралтай тодорхой дүрэм журмыг авч үзэхийн зэрэгцээ Монголын ОҮИТБС эдгээр шаардлагыг биелүүлж буй эсэх талаар танилцуулах болно. ОҮИТБС-ын Стандартын шаардлагаас эшлэл авч, эдгээр шаардлагыг биелүүлж буй эсэх талаарх дүгнэлтийг танилцуулах юм.

Шаардлага 1. Олон талт оролцогчдын бүлгийн зүгээс тавих хяналт

1.2.a "Компаниуд нь ОҮИТБС-ын үйл ажиллагаанд бүрэн дүүрэн, идэвхтэй, үр дүнтэйгээр оролцох шаардлагатай."

Монголд ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд ТӨК-ийн чухал оролцоотой. ОҮИТБС-ын баталгаажуулалтын тайланд "...Олон талт оролцогчдын бүлгийн компаниудын төлөөлөл нь ОҮИТБС-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог боловч салбарын өргөн хүрээний төлөөлөл ОҮИТБС-ын үйл ажиллагаанд бүрэн хэмжээнд, үр нөлөөтэй оролцдог гэх нотолгоо бага байна" гэж мэдэгдсэн. Түүнчлэн "ОҮИТБС-ын тайланг бэлдэхэд салбарын ялангуяа том хэмжээний компанийн төлөөлөл оролцдог боловч ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх бусад үйл ажиллагаанд, тухайлбал олон нийттэй харилцах, мэдээлэл түгээх гэх мэт ажилд компаниудын төлөөллийн идэвхтэй оролцоо тун бага харагддаг"[24] хэмээн онцолсон байна. Мөн "оролцогч талуудын хэлэлцүүлгийн явцад олон нийттэй харилцах, мэдээлэл түгээх ажилд компаниуд идэвхтэй оролцдог гэсэн жишээ харагдаагүй" гэсэн дүгнэлт хийж, компаниуд энэ санаачилгад идэвхтэй оролцдог талаар эргэлзээ байгааг тэмдэглэжээ. Эдгээр дүгнэлт нь бүх хэлбэрийн компанид хамааралтай боловч ялангуяа ТӨК-ийн хувьд илүү холбогдох асуудал юм.

Монголын ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч гол нэгж нь 29 гишүүн бүхий Үндэсний зөвлөл юм. Гэвч зөвхөн хоёр ТӨК-ийн төлөөлөл, төрийн оролцоотой компанийн нэг төлөөлөл энэ бүрэлдэхүүнд ажиллаж байгаа нь Монгол Улсын хувьд тэргүүлэх уул уурхайн компаниудыг төлөөлж байна.[25] Үүнтэй төстэйгөөр ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй Олон талт оролцогчдын бүлгийн 33 гишүүнтэй Ажлын хэсэгт ТӨК-ийн дөрвөн компанийн төлөөлөл[26] багтаж байна. Монголын олборлох салбарт үзүүлэх ТӨК-ийн нөлөө их учраас ОҮИТБС-ын салбарыг төлөөлөх талынхан ТӨК-ийн төлөөллийг өргөн хүрээнд татан оролцуулах талаар

[24] ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар, "Монгол Улсын 2022 оны баталгаажуулалтын тайлан."
[25] "ОҮИТБС-ын вэбсайт. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн."
[26] "ОҮИТБС-ын вэбсайт. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн."

бодолцож, энэхүү санаачилгыг хэрэгжүүлэх бүхий л ажилд тэднийг идэвхтэй оролцоог хангах нь чухал юм.

1.2.b Тайлагнагч компаниуд нь авлигын эсрэг бодлогоо, үүнд эцсийн өмчлөгчийн мэдээллээ нийтлэх нь зүйтэй.

Авлигын эсрэг Монгол Улсын хууль тогтоомж нь ТӨК-иуд авлигын эсрэг бодлого хэрэгжүүлэхийг шаардах тал дээр нэг мөр биш юм. Авлигын эсрэг хууль тогтоомж нь ТӨК-ийн түвшинд ийм төрлийн бодлого хэрэгжүүлэхийг үүрэг болгодоггүй ч авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, хэрэгжилтийн төлөвлөгөө нь ТӨК-ийг ийм бодлого, төлөвлөгөөтэй байхыг заасан байдаг. Жишээлбэл “Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлнэ” гэсэн үндсэн зорилго, “Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж хэвшүүлнэ” гэсэн зорилгыг[27] тус тус дэвшүүлсэн байдаг.

Зөвхөн цөөн тооны ТӨК нь авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нийтэлдэг болохыг судалгааны явцад тогтоосон. Тухайлбал, Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой, Багануур, Шивээ-Овоо болон Таван толгой түлш (уул уурхайн бус чиглэлийн) компаниуд өөрсдийн вэбсайтад үйл ажиллагааны төлөвлөгөөгөө нийтэлсэн байна.[28] ОҮИТБС-ын жилийн нэгтгэл тайлангууд компаниуд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөтэй эсэх талаар мэдээллийг дурдаагүй. ОҮИТБС нь компаниудыг ийм төрлийн төлөвлөгөө боловсруулсан эсэх, төлөвлөгөөг олон нийтэд зориулж нийтэлдэг эсэх талаар мэдээлэл өгөхийг үүрэг болгох хэрэгтэй.

Бенефицар (ашиг хүртэгч эцсийн өмчлөгч) өмчлөгчийн мэдээллийн тухайд ОҮИТБС-ын нэгтгэл тайланд эцсийн өмчлөгч хувь хүний талаар мэдээлдэг бөгөөд хувьцаат компани нь хувьцаагаа бүртгүүлсэн хөрөнгө биржийн нэрийг мөн мэдээлдэг.[29] Эцсийн өмчлөгчийн жагсаалтад хуулийн этгээдийг оруулж нийтэлж байгаа нь өмчлөгчдийг ил тайлагналд дутагдал байгааг илтгэж байна. Учир нь тодорхойлолт ёсоор хуулийн этгээд нь компанийн эцсийн өмчлөгч байх ёсгүй буюу хувь хүн байх учиртай. Түүнчлэн энэ жагсаалтад ТӨК-иуд багтаагүй байна. Хэдийгээр ТӨК-ийн өмчлөлтэй шууд хамааралгүй асуудал боловч эцсийн өмчлөлийн талаарх ил мэдээлэлд Монгол Улсын иргэний угсаа гарлыг нийтэлсэн[30] нь оновчгүй бөгөөд Монголын ОҮИТБС энэ асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэж байна.

---

[27] УИХ. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ын 2.6.2 заалт.
[28] Эрдэнэт үйлдвэрийн авлигын эсрэг төлөвлөгөө: www.erdenetmc.mn/anti-corruption-activities/plan.
[29] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба, “ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэлийн тайлан. Хавсралт 20b, 20c.”
[30] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. Хавсралт 20b.

Эцсийн өмчлөлийн мэдээллийг ил тод нийтлэх асуудлыг зохицуулах Монгол Улсын хууль тогтоомжийн хувьд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг 2021 онд баталснаар илт сайжирсан. Тухайлбал энэ хууль төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг "мэдээлэл хариуцсан хуулийн этгээд"[31] гэж тодорхойлж, тэднийг "хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаарх"[32] мэдээллийг "тогтмол ил тод бөгөөд нээлттэй"[33] байлгах үүрэг хүлээлгэсэн. Энэ хуулийн шаардлага нь эцсийн өмчлөлийн ил тод байдлыг сайжруулах суурь болсон хэдий ч "эзэмшигч, өмчлөгч" бус харин "эзэмшигч, өмчлөгчийн талаарх" мэдээллийг нийтлэх шаардлага нь нэр томьёог ойлгох, хуулийг хэрэгжүүлэхэд гажуудал үүсгэх магадлалтай байна. Компаниуд эцсийн өмчлөлийн мэдээллийг татвар болон улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлэх шаардлагыг мөн тавьдаг.

ТӨК-ийн эцсийн өмчлөлийг тайлагнах талаар Шаардлага 2.5.с хэсэгт хэлэлцэх болно.

Шаардлага 2. Эрх зүйн болон институтийн тогтолцоо, гэрээ, тусгай зөвшөөрөл

Энэ хэсэгт авч үзсэн ОҮИТБС-ын багц шаардлага нь олборлох салбарын компаниуд, үүнд ялангуяа ТӨК, тэдгээрийн санхүү, үйл ажиллагаа, мөн эцсийн өмчлөлийн гэх мэт мэдээллийн ил тод байдлыг сайжруулахад чиглэгдсэн болно. ББЗХ-ийн гаргасан Авлигын эрсдэлийн үнэлгээнд ТӨК-ийн засаглал нь Монгол Улсын олборлох салбарын өндөр эрсдэлтэй талбарын нэг[34] болохыг, мөн Баялгийн засаглалын индексэд ТӨК-ийн засаглалын хувьд Монгол Улс бусад асуудлаас илүү их дутагдалтай[35] гэж удаа дараа дүгнэсэн. Ерөнхийдөө эцсийн өмчлөлийн мэдээллийг цуглуулах, нийтлэхийг сүүлийн жилүүдэд бодлогын чухал асуудал болгож, түүгээр дамжуулж олборлох салбарын авлигын эрсдэлийг шийдвэрлэхээр засгийн газар зорьж, улмаар олон санаачилгын хүрээнд чухал ажлуудыг хэрэгжүүлж ирсэн. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг 2021 онд баталж, эцсийн өмчлөлийн мэдээллийг ил тод болгохыг хуульчилсан нь чухал алхам болсон юм. Түүнчлэн Монгол Улс Мөнгө угаах, терроризмтой тэмцэх олон улсын байгууллага (ФАТФ)-ын саарал жагсаалтаас гарах, үнэ шилжилт, үндэстэн дамнасан компаниудаас татвар хураахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх[36] зорилгоор эцсийн өмчлөлийн мэдээллийг цуглуулж эхэлсэн. Монголын ОҮИТБС

[31] Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль. 6.1.2 заалт.
[32] Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль. 8.6.19 заалт.
[33] Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль. 8.6 заалт.
[34] "Уул уурхайн салбарын авлигатай хэрхэн тэмцэх вэ."
[35] Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, "Монгол Улсын уул уурхайн засаглал бага зэрэг сайжирсан боловч төрийн өмчит компаниудын засаглал, ил тод тайлагналын асуудалд анхаарах шаардлагатай байна.
[36] "Мөнгө угаах, терроризмтой тэмцэх олон улсын байгууллага (FATF): Монгол Улсын үнэлгээ."

нь эцсийн өмчлөлийн ил тод байдлыг сайжруулах замын зураг боловсруулж, ОҮИТБС-ын тайлан энэ талаарх мэдээллийг цуглуулж байгаа ч үнэн зөв мэдээллийг тогтсон хугацаанд цуглуулах, нягтлах тогтолцоо бүрдүүлэх талаар хийх ажил их байна. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил нийтлэх нь авлигатай тэмцэх чухал хэрэгсэл гэдэг нь олборлох салбарт гарч буй авлигын дуулиант хэргүүдээс тодорхой харагддаг. Тухайлбал, Таван толгойн нүүрсний уурхайн олонх хувьцааг орон нутаг өмчилдөг хэдий ч компанийн жижиг хувьцаа эзэмшигчид, уг компаниас давуу нөхцөлтэйгөөр нүүрс худалдан зуучлах компаниудыг байгуулах замаар улс төрчид нүүрс “завшсан” гэж буруутгагдсан. Хэрвээ эцсийн өмчлөгчдийн талаарх мэдээлэл байсан бол энэ мэт үйлдлээс урьдчилан сэргийлэх боломж байх байсан.[37]

2.4.а “Хэрэгжүүлэгч улс орнууд нь 2021 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн олгогдсон лиценз, хийсэн гэрээ эсхүл нэмэлт өөрчлөлт орсон гэрээ, лицензийг ил тод болгох ёстой. Санаачилгыг хэрэгжүүлэгч орнууд нь ашигт малтмал, байгалийн хий, газрын тос олборлох нөхцөлийг агуулсан аливаа гэрээ болон лицензийг, мөн материаллаг гэж үзэх хайгуулын гэрээг ил тод болгохыг дэмжиж байна.”[38]

Гэрээний ил тод байдал нь ОҮИТБС-ын Стандартын гол шаардлагын нэг бөгөөд энэ нь уул уурхайн компаниуд үүргээ биелүүлэх явцыг хянах боломжийг оролцогч талуудад олгодог юм. ОҮИТБС-ын гэрээний ил тод байдлын шаардлага нь ТӨК-ийг тусгайлан авч үздэггүй боловч ил тод болгох шаардлагатай, олборлох салбарын хамгийн чухал гэрээний дийлэнх нь ТӨК гарын үсэг зурсан эсхүл ТӨК-ийн удирддаг төсөлтэй холбоотой байдаг. Олборлох салбарт ашигладаг гэрээний цар хүрээг тогтооход ярвигтай бөгөөд олон тооны гэрээг хамруулах боломжтой. ОҮИТБС болон ББЗХ хамтран гэрээний ил тод байдлын тухай тусдаа судалгааг боловсруулсан болно.

ТӨК-тай холбоотой хамгийн чухал гэрээнд хөрөнгө оруулалтын (хөрөнгө оруулалтыг болон өмчийн хамгааллыг баталгаажуулах, мөн татварыг тогтворжуулах), тогтворжуулах гэрчилгээ (татварыг тогтворжуулах), хувьцаа эзэмшигчийн гэрээ (төр болон хувийн хэвшлийн хооронд хамтарсан компани байгуулсан тохиолдолд байгуулах), орон нутгийн гэрээ (уул уурхайн компани болон орон нутгийн хооронд байгуулах) зэрэг орно. Энд дурдсан гэрээнээс зөвхөн орон нутгийн гэрээг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу ил тод мэдээлэхийг шаарддаг бол одоо мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад гэрээг ил тод

[37] “Байр суурь: Нүүрсний хэргийн талаарх эхний сонсголд хэн, хэн юу өгүүлэв..”
[38] ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар. ОҮИТБС-ын 2023 оны стандарт.”

нийтлэх шаардлага байхгүй байна. ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэл тайланд ТӨК-ийн байгуулсан 30 гэрээг тайлагнасан ба эдгээр нь бүгд орон нутгийн удирдлагатай байгуулсан, хамтран ажиллах эсхүл газар ашиглах гэрээ байна. Оюу Толгой гэх мэт хамтарсан компанийн хувьд Рио Тинто компанитай байгуулсан хөрөнгө оруулалтын, хувьцаа эзэмшигчдийн зэрэг үндсэн гэрээг тухайн компанийн болон засгийн газрын сувгаар дамжуулж ил нийтэлсэн. Бусад тохиолдолд ТӨК-иуд нь хуульд заасны дагуу ихэвчлэн орон нутгийн гэрээг ил нийтэлдэг. Харин нэг онцгой жишээ бол Эрдэнэс Тавантолгой бөгөөд бусад компаниудтай байгуулсан оффтэйк, дэд бүтцийн буюу бартер солилцооны гэрээ, түүнчлэн худалдах, худалдан авах гэрээний загвараа ил тод нийтэлжээ.

Монголын ОҮИТБС нь орон нутгийн гэрээнээс бусад гэрээг ил тод болгох, ТӨК-ийн ялангуяа хувийн хэвшилтэй хамтарсан компанийн гэрээг ил тод болгохын тулд хууль эрх зүйн орчныг сайжруулах ажлаа үргэлжлүүлэх нь чухал байна.

2.5.c "... компаниуд нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг олон нийтэд зориулж нийтлэх шаардлагатай."[39]

Эцсийн өмчлөлийг ил тод болгох асуудлыг дээрх 1.2.b хэсэгт ерөнхийд нь хэлэлцсэн. Төр бүхэлд нь эзэмшдэгээс бусад ТӨК нь Монголын ОҮИТБС-ын тогтсон эцсийн өмчлөлийн тодорхойлолтод хамаарах (жишээ нь, таван хувийн босгоос дээш хувьцаа эзэмших) эцсийн өмчлөлийн талаарх мэдээллийг нийтлэх ёстой. ОҮИТБС-ын нэгтгэл тайланд ТӨК-ийн эцсийн өмчлөлийн тухай мэдээллийг оруулдаггүй боловч зарим нэгэн төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани нь хувьцаагаа бүртгүүлсэн хөрөнгийн биржийн нэрийг ил нийтэлсэн байдаг. Монголын ОҮИТБС нь энэхүү зөрүүтэй байдлыг арилгаснаар төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд нь хамтрагчдынхаа тодорхойлолтод хамаарах эцсийн өмчлөгчдийн талаарх мэдээллийг ил мэдээлэх ёстой.

2.5.e.3 "Хөрөнгийн биржид бүртгэлтэй компани, тэдний 100% эзэмшлийн охин компанийн хувьд тухайн биржийн нэрийг мэдээлж, эцсийн өмчлөгчийн тухай мэдээллийг олон нийтэд үзэх боломжийг олгох үүднээс хөрөнгийн биржид гаргасан тайлангийн холбоосыг ил нийтэлнэ."

[39] ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар.

Төрийн өмчит хэд хэдэн компаниуд хувьцаат компани хэлбэртэй бөгөөд эдгээр компанийн заримынх нь хувьцаа Монголын хөрөнгийн бирж дээр нээлттэй, чөлөөтэй арилжаалагддаг бол зарим нь хаалттай (хувьцааг арилждаггүй) хувьцаат компани юм. Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй боловч Багануур[40], Шивээ-Овоо[41] компанийн аль аль нь хөрөнгийн биржийн нэр, бирж дээрх бүртгэл, эсхүл эцсийн өмчлөлийн мэдээллээ өөрсдийн вэбсайт дээр нийтлээгүй байна. Харин үүний эсрэг жишээ нь Таван Толгой хувьцаат компани бөгөөд Монголын хөрөнгийн биржийн вэбсайт дээрх компанийн танилцуулгын линкийг өөрийн вэбсайтад[42] нийтэлсэн байна. ОҮИТБС-ын нэгтгэл тайланд хувьцаат компанийн хувьцаа чөлөөтэй арилжигддаг хөрөнгийн биржийн мэдээллийг[43] харуулсан бөгөөд үүнд Багануур компани нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй гэсэн мэдээлэл багтсан байна. Гэвч хувьцаат компаниудын хувьд хамгийн чухал байр суурь эзэлдэг Эрдэнэс Тавантолгой зэрэг компанийн тухай мэдээлэл байхгүй нь тайлангийн чанар хангалтгүй гэж дүгнэхэд хүргэж байна. Үүнээс гадна зарим нэгэн мэдээлэл буруу бөгөөд компаниудын тухай мэдээлэл бус тухайн аж ахуйн нэгжийн хувьцааг эзэмшигч компаниудын хөрөнгийн биржийн мэдээллийг оруулсан байна. Жишээлбэл, Оюу Толгой нь төрийн оролцоотой, гэхдээ хувьцаат компани биш боловч Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй гэж нийтэлсэн нь тус компанийн эцсийн том хувьцаа эзэмшигч болох Рио Тинто компанийн биржийн мэдээллийг оруулсан бололтой. Монголын ОҮИТБС нь энэ асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ ТӨК-иудтай холбоотой мэдээллийг үнэ зөв тайлагнах тал дээр ажиллах хэрэгтэй байна.

2.5.e.5 “ТӨК нь тухайн компанийг өмчилдөг эсхүл хянадаг улсын нэр, өмчлөлийн хэмжээ, өмчлөлийн хэлбэрийг хэрхэн хянадаг талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ил тод болгох ёстой. Хэрэв ТӨК-ийг төр бүхэлд нь өмчилдөггүй бол Шаардлага 2.5(c)-ын дагуу эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил нийтлэх үүрэгтэй.”

ОҮИТБС-ын нэгтгэл тайланд Монголын уул уурхайн компаниудыг гадаадын төр өмчилж буй талаарх мэдээлэл байхгүй байна. Монгол Улсын Засгийн газар уул уурхайн компанид хувь эзэмшдэг тохиолдолд энэ мэдээлэл нь ОҮИТБС-ын тайлан болон бусад эх сурвалжид ихэнхдээ агуулагдсан байдаг.

[40] Багануур компанийн вэбсайт. www.baganuurmine.mn.
[41] Шивээ-Овоо компанийн вэбсайт. www.shivee-ovoo.mn.
[42] Таван толгой ХК-ийн вэбсайт. www.tavantolgoi.mn.
[43] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. “Монголын ОҮИТБС-ын 2022 нэгтгэл тайлан. Хавсралт 20с.”

Уул уурхайн компанид төр хувь эзэмших асуудлыг зохицуулдаг хууль тогтоомж нь гол төлөв “стратегийн” гэж нэрлэгддэг ордуудад хамаардаг. Одоогийн байдлаар 16 ордыг стратегийн гэсэн ангилалд жагсаасан байна. Ашигт малтмалын тухай хуульд зааснаар энэ төрлийн ордыг хэрэв хувийн хөрөнгө оруулалтаар нээж, засгийн газар хамтрахаар шийдсэн бол тухайн ордыг эзэмшигч компанийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг, хэрэв улсын төсвийн хөрөнгөөр нээсэн бол 50 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг засгийн газар эзэмшиж болно.[44] Харин ураны ордын хувьд Засгийн газар нь наад зах нь 34 ба 51 хувийн хувьцааг тус тус эзэмшинэ гэж заасан.[45] Төрийн өмчит компани байгуулах шийдвэрийг хууль тогтоогч буюу УИХ гаргах боломжтой. Жишээлбэл, Цөмийн энергийн тухай хуульд тусгасан нэг шаардлага нь засгийн газар ураны хайгуул, олборлолтын компанийн өмчлөлийг удирдахын тулд ТӨК байгуулах ёстой гэсэн утгатай байдаг. Гэвч дийлэнх тохиолдолд ТӨК байгуулж, уул уурхайн компанид хувь эзэмших замаар уул уурхайн төсөлд оролцох эрхээ эдлэх эсэхийг шийдэх нь Засгийн газрын (гүйцэтгэх засаглалын) бүрэн эрх байдаг. Мөн ТӨК байгуулах бүрэн эрхийг тухайлбал харьяа компани байгуулах шаардлагатай тохиолдолд Эрдэнэс Монгол зэрэг компанид Засгийн газрын зүгээс шилжүүлж болно. Засгийн газар нь аль агентлаг эсхүл ТӨК нь шинээр байгуулж буй ТӨК-т хувьцаа эзэмшихийг шийдвэрлэж, тухайн хувьцаа эзэмшигч агентлагт юм уу эсхүл ТӨК-т хувьцаа эзэмшигчийн болон хяналт тавих эрхийг олгодог.

ОҮИТБС-ын нэгтгэл тайланд уул уурхайн компани дах засгийн газрын хувь эзэмшлийг нийтэлдэг бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эсхүл уул уурхайн томоохон гэж болох ТӨК-иудад хувьцаа эзэмшдэг холдинг компани болох Эрдэнэс Монгол зэрэг компаниар дамжуулж энэ мэдээллийг мөн ил нийтэлдэг.

ТӨК нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод нийтлэх асуудлыг дээрх Шаардлага 2.5.с-ын хүрээнд тайлбарласан.

2.5.g “Компаниуд нь эцсийн өмчлөгч хүртэлх завсрын өмчлөгч хуулийн этгээдийн бүхий л сүлжээг харуулсан өмчлөлийн бүтцийг ил нийтлэхийг дэмжиж байна.”

Монголын ОҮИТБС-ын тайлангийн маягт нь эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл цуглуулдаг боловч компанийн өмчлөлийн бүтцэд байх эцсийн өмчлөгч хүртэлх бүх үе шатан дахь хуулийн этгээдийн холбоог харуулах зорилготой нарийвчилсан асуулт байхгүй учраас учир

[44] Ашигт малтмалын тухай хууль.
[45] Цөмийн энергийн тухай хууль.

дутагдалтай байна.[46] ОУИТБС-ын нэгтгэл тайланд ч мөн эцсийн өмчлөгчийг хүртэлх өмчлөлийн бүтцийн мэдээллийг тусгадаггүй.[47]

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар нь компанийн хувь эзэмшигчдийн талаарх мэдээллийг нээлттэй нийтэлдэг.[48] Гэвч уг мэдээлэлд эцсийн өмчлөгч бус зөвхөн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл байдаг тул хэрэв өмчлөл нь хуулийн этгээдтэй холбоотой бол эдгээр хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийг тусад нь хайх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сан нь мэдээллийг шүүх, ашиглахад хялбар байдлаар буюу нээлттэй өгөгдлийн хэлбэрээр нийтэлдэггүй байна.

2.6.a "Олборлох салбар дахь төрийн оролцооноос үүдэн материаллаг орлогын төлбөр төлөх тохиолдолд санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд нь дараах мэдээллийг ил тод болгох ёстой..."

Олборлох салбар дахь төрийн оролцоо нь материаллаг хэмжээний орлогын төлөхөд хүргэдэг. Жишээ нь ОУИТБС-ын 2022 оны нэгтгэл тайланд Засгийн газрын тайлагнасан 104 компанийн нийт төлбөрийг дурдсан байна. Эдгээрээс төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 12 аж ахуйн нэгж нь нийт компанийн төсөвт төвлөрүүлсэн орлогын 72.5 хувийг бүрдүүлсэн байна.[49] Монголын ОУИТБС нь аудитортай зөвшилцөх замаар нэгтгэл тайланд оруулах компанийг сонгох шийдвэр гаргадаг. Жишээлбэл, 2022 оны тайланд нийт төлбөрийн 98 хувийг бүрдүүлсэн бүх компанийг оруулахыг Олон талт оролцогчдын бүлэг зөвшөөрсөн. Ингэснээр жижиг компаниуд уг тайланд ороогүй гэсэн үг. Түүнчлэн, иргэний нийгмийн байгууллагын хүсэлтээр дөрвөн компанийг нэмж тайлагнасан. Өөрөөр хэлбэл, материаллаг босго нь дан ганц төлбөрийн дүнтэй уялдах шаардлагагүй бөгөөд Монголын ОУИТБС нь нэгтгэл тайланд олборлох салбарт оруулж буй үр дүнг нь харгалзан үзэж салбарын бүх ТӨК-ийг хэмжээнээс үл хамааран оруулах боломжтой.

2.6.a.i "...хэрэгжүүлэгч улс орнууд нь дараах мэдээллийг ил тод нийтлэх үүрэгтэй ... Салбар дахь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэх үүрэг, Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгж хоорондын санхүүгийн харилцааг зохицуулсан үндсэн дүрэм, практик туршлагын тухай дэлгэрэнгүй тайлбар. Үүнд төрийн өмчит аж ахуйн

[46] "Монголын ОУИТБС-ын тайлангийн маягт 1," www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2022/06/16/mtqisa3dat6jvban/EITI-Template-1_v3.pdf.
[47] Монголын ОУИТБС-ын Ажлын алба. "Монголын ОУИТБС-ын 2022 нэгтгэл тайлан."
[48] Улсын бүртгэлийн ерөнхий газрын вэбсайт."
[49] Монголын ОУИТБС-ын Ажлын алба. "Монголын ОУИТБС-ын 2022 нэгтгэл тайлан, Хавсралт 10."

нэгж болон засгийн газрын хооронд хөрөнгө шилжүүлэх дүрэм, хуримтлагдсан ашиг, нэмж хийсэн хөрөнгө оруулалт болон гуравдагч талын санхүүжилт гэх мэт асуудал орно. Түүнчлэн төрийн өмчит аж ахуйн нэгжийн охин болон харьяа компанитай холбоотойгоор хийсэн хоорондын шилжүүлэг, хуримтлагдсан ашиг, нэмж хийсэн хөрөнгө оруулалт болон гуравдагч талын санхүүжилт зэргийг ил нийтлэх ёстой. ”

Монголын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ТӨК-ийн тоо болон нарийн төвөгтэй байдал зэргээс шалтгаалж ТӨК-ийг зохицуулдаг дүрэм, журмыг олон нийт ойлгоход энэ шаардлага нэн чухал. ОҮИТБС-ын нэгтгэл тайланд ТӨК-ийг зохицуулдаг хууль тогтоомж[50], Засгийн газар ба ТӨК-ийн хоорондын санхүүгийн харилцааны[51] тухай мэдээллийг тусгадаг. Уг тайланд хуримтлагдсан ашиг, нэмж хийсэн хөрөнгө оруулалт зэрэг мэдээллийг агуулсан санхүүгийн тайланг олон нийтэд ил тод нийтэлсэн эсэхийг оруулсан боловч зөвхөн найман ТӨК-ийг хамруулсан байна. Тайланд гуравдагч талын санхүүжилтийн мэдээллийг шууд тусгаагүй боловч зургаан ТӨК-ийн өглөгийн талаарх мэдээллийг тайлагнасан. Харин охин болон харьяа компанитай холбоотой эдгээр үзүүлэлтийн дагуу дэлгэрэнгүй мэдээллийг тайланд тусгаагүй байна.

ТӨК санхүүгийн нарийвчилсан мэдээллээ Шилэн дансны мэдээллийн санд нийтэлдэг бөгөөд уг вэбсайтад нийтлэх шаардлагатай мэдээллийн жагсаалтыг Хавсралт 3-д харуулав. Монголын ОҮИТБС тайлангаа сайжруулахын тулд нэгтгэл тайланг Шилэн дансны вэбсайт дээр нийтэлдэг тайлантай холбох, мөн холбогдох бүх ТӨК-ийг хамарсан тайлан бэлтгэх нь зүйтэй. Түүнчлэн, Багануур, Шивээ-Овоо зэрэг томоохон ТӨК-ийн зарим нь Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэгдсэн тул хөрөнгийн биржийн вэбсайт дээр өөрсдийн санхүүгийн нарийвчилсан мэдээллийг нийтэлдэг.

2.6.a.ii “”...Хэрэгжүүлэгч улс орнууд дараах мэдээллийг ил тод нийтлэх үүрэгтэй.... Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгж нь тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос болон байгалийн хийн компаниудад эзэмших өөрсдийн хувь эзэмшлийн хэмжээ. Энэ нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн охин болон харьяа аж ахуйн нэгж болон тайлангийн хугацаанд эзэмшилд гарсан өөрчлөлтийн тухай мэдээллийн хувьд нэгэн адил хамааралтай.”

[50] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. 5.7.2-р хэсэг.
[51] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. 5.7.7-р хэсэг.

ОҮИТБС-ын жилийн тайланд уул уурхайн салбарын голлох ТӨК-ийн өмчлөлийн хувь хэмжээний мэдээллийг нийтэлдэг. Гэвч зөвхөн найман компанийн мэдээллийг оруулж, тэдний хувьд хамтарсан компаниудын талаарх мэдээллийг ил болгосон хэдий ч охин компанийн нарийвчилсан мэдээллийг тайланд тусгаагүй байна. Тайлангийн хугацаанд өмчлөлийн хэмжээнд гарсан өөрчлөлтийг мөн тайлбарласан байна.[52]

Төрийн өмчийг хариуцсан агентлаг нь ТӨК-ийн талаарх жилийн тайланг мөн гаргадаг. Эдгээр тайлан нь зөвхөн уул уурхайн салбараар хязгаарлагддаггүй буюу нийт төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн тухай мэдээллийг хамардаг.[53] Монголын ОҮИТБС нь ТӨК-ийн талаар өөрсдийн бэлтгэдэг тайлан болон уг агентлагийн тайлангийн хоорондын уялдааг сайжруулах нь зүйтэй. Жишээлбэл, ОҮИТБС-ын тайланд уул уурхайн олон ТӨК-ийг орхигдуулдаг. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тайланд орон нутгийн өмчит компанийг тайлагнадаггүй байхад энэ төрлийн нэг ТӨК-ийг ОҮИТБС-ын 2022 оны тайланд оруулсан байна. Түүнчлэн Монгол Улсын томоохон нүүрс олборлогч болох Эрдэнэс Тавантолгой компанийн төрийн өмчийн хувь эзэмшлийн мэдээлэл нь 2022 оныг хамарсан хоёр тайланд зөрүүтэй байх жишээний байна. Нэг тайланд уг үзүүлэлтийг 85.2 хувь, нөгөө тайланд 81.5 хувийн төрийн өмчит гэж дурдсан байна. Охин болон харьяа компанийн өмчлөлийн бүтэц буюу хэлхээг тодорхой харуулсан мэдээлэл байхгүй учир ийм төрлийн компанийн өмчлөлийн хувь хэмжээг ямар ч тайлангаас олоход төвөгтэй байна.

Шилэн данс нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай мэдээллийн чухал эх сурвалж юм. Вэбсайтын шинэчилсэн хувилбар дээр “Дэлгэрэнгүй мэдээлэл” гэсэн талбарт компаниудын ерөнхий буюу мета өгөгдлийг нийтэлсэн байна. Хэдийгээр мета өгөгдлийг хуулиар нийтлэхийг шаарддаггүй боловч Сангийн яам тайлагнадаг бүх компаниудад зориулж энэ цэсийг нэмсэн. Энэ хэсэгт тухайн компанийн төрийн өмчийн хэмжээг хувиар илэрхийлсэн мэдээллийг нийтэлсэн байна. Мета өгөгдлийн “Салбар байгууллагууд” хэсэгт харьяа компанийн жагсаалтыг оруулсан. Жишээлбэл, Эрдэнэс Монгол нэгдэл 15 харьяа компани, Багануур хоёр харьяа компани жагсаасан байна. Гэвч бүх компаниуд төрийн өмчийн хэмжээ, салбар компанийн мэдээллээ нийтлээгүй учраас энэ хэсгийг цаашид сайжруулах хэрэгтэй байна.

[52] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. 5.7.3-р хэсэг.
[53] “Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 оны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.

Заримдаа компанийн вэбсайт нь хувь эзэмшлийн тухай мэдээллийг авах сайн эх сурвалж болж өгдөг. Уул уурхайн ТӨК болон тэдний төрийн өмчийн хувь хэмжээг харуулсан жагсаалтыг Хавсралт 1-д оруулав.

2.6.b "Төрийн өмчит компаниуд нь аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг, боломжгүй бол санхүүгийн гол үзүүлэлтүүдийг (баланс, ашиг/алдагдлын тайлан, мөнгөн урсгал гэх мэт) олон нийтэд ил тод болгох шаардлагатай. Тайлан гаргагч нь аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг хугацаанд нь нийтлэхэд саад болж буй хууль эрх зүйн болон зохицуулалтын бэрхшээлийг тодорхой баримтжуулах ёстой."

ОҮИТБС-ын тайланд ТӨК-ийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан эсэх, санхүүгийн тайланг олон нийтэд зориулж нийтэлсэн эсэх мэдээллийг тусгадаг.[54] Үндэсний аудитын газар нь аудитын тайлангийн мэдээллийн нэгдсэн сантай боловч вэбсайтдаа уул уурхайн бүх ТӨК-ийн санхүүгийн тайланг баталгаажуулсан эсэх, санхүүгийн тайланг олон нийтэд зориулж нийтэлсэн эсэхийг тодорхой мэдээлдэггүй. Жишээлбэл, тус газрын вэбсайтаас 2021 оны тайланг (2022 онд аудитаар баталгаажсан) хайхад Эрдэнэс Тавантолгой гэх мэт том компанийн тайланг олох[55] боломжгүй байна. Шилэн дансанд ТӨК-ийн санхүүгийн тайланг нийтэлдэг ч хавсаргасан файл нь ихэвчлэн аудитаар баталгаажуулаагүй тайлан байна. Шилэн дансанд мэдээллээ нийтэлсэн ТӨК-ийн жагсаалтыг Хавсралт 6-д нэгтгэв. Зарим ТӨК өөрийн вэбсайтдаа аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа нийтэлдэг.

Монгол Улсын хууль тогтоомжид ТӨК-ийг аудитын дээд байгууллагаар жил бүр аудит хийлгэхийг шаарддаг.[56] Үндэсний аудитын газар нь гурван төрлийн буюу санхүү, гүйцэтгэл болон нийцлийн аудитыг гүйцэтгэдэг. Уг аудитын газар нь олон улсын аудитын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд Аудитын дээд байгууллагуудын олон улсын институтийн гишүүн юм. ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэл тайланд дурдсанаар Үндэсний аудитын газар нь Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажилладаг. Гэвч аудит хийлгэх шаардлагатай компани маш олон байдаг учраас зарим аудитын ажлыг хувийн аудитын компаниар гүйцэтгүүлж, Үндэсний аудитын газар чанарын хяналт тавьдаг.

[54] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. Монголын ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэлийн тайлан. 5.7.9, 5.7.11-р хэсэг.
[55] Үндэсний аудитын газрын вэбсайт."
[56] УИХ. Төрийн аудитын тухай хууль. 8.1 заалт.

Шилэн дансны тухай хуулийн шаардлагын дагуу ТӨК нь аудитаар баталгаажуулсан тайлангаа Шилэн дансны нэгдсэн санд илгээх ёстой.[57] Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд ТӨК-ийг тогтмол хугацаанд аудитын дүгнэлт, тайлангаа нийтлэхийг тодорхой заасан байна.[58] Зээлдүүлэгч аудитын тайлан шаарддаг зэрэг янз бүрийн шалтгаанаар зарим том компани санхүүгийн тайландаа хувийн компаниар аудит хийлгэдэг. Гэвч олон тооны компани аудитын тайлангаа хуулиар тогтоосон хугацаанд нь ил тод нийтлэхгүй байгаа нь одоо үйлчилж байгаа дүрэм журам үр дүнтэй хэрэгжихгүй байгаатай холбоотой. Түүнчлэн Шилэн дансны тухай зэрэг хууль тогтоомж төр цөөнх хувийг эзэмшдэг компанид хамаарахгүй байна. Эдгээр компаниуд нь эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой байсан ч аудитаар баталгаажсан тайлангаа нийтлэх шаардлагагүй байдалтай байна. Монголын ОҮИТБС нь дээр дурдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцсан төр засгийн байгууллага болон зарим компаниудтай хамтран ажиллах замаар ТӨК болон төрийн эзэмшлийн хувь хэмжээ бага боловч томоохон компаниудын аудитаар баталгаажсан тайланг бүрэн нийтлэх ажлыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

2.6.с "Санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны болон хөрөнгийн зардал, худалдан авалт, туслан гүйцэтгэгч ажиллуулах болон компанийн засаглалтай (ТУЗ-ийн бүрэлдэхүүн, томилгоо, чиг үүрэг, ёс зүйн дүрэм гэх мэт) холбоотой дүрэм журам болон практикийг тайлбарлан мэдээлэх шаардлагатай."

Монголын ОҮИТБС нь ТӨК-ийн зардал, худалдан авалт, гэрээлэгчтэй холбоотой журам, практикийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тайлагнадаг.[59] ТӨК-ийн үйл ажиллагааны болон хөрөнгийн зардлын талаарх мэдээлэл ТӨК-ийн санхүүгийн нэгдсэн тайланд ихэвчлэн тусгагддаг. Шилэн дансны тухай хуульд[60] төрийн байгууллага, ТӨК нь санхүү, үйл ажиллагааныхаа тухай дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд зориулсан вэбсайтдаа нийтлэхийг шаарддаг. Мөн санхүүгийн гол тайлангаас гадна, уул уурхайн ТӨК-ийн дийлэнх нь таван сая төгрөг (ойролцоогоор 1,480 ам.доллар)-өөс дээш дүнтэй гүйлгээг Шилэн дансны мэдээллийн санд нийтлэх ёстой.[61] Гэвч аль ТӨК тайлагнах ёстой гэдэг хуулийн шаардлага

[57] УИХ. Шилэн дансны тухай хууль. 6.1.5 заалт.
[58] Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль. 8.4.3, 8.4.9 заалт.
[59] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. "Монголын ОҮИТБС-ын 2022 нэгтгэл тайлан, 5.7.12-р хэсэг."
[60] УИХ. Шилэн дансны тухай хууль (2014). www.legalinfo.mn/mn/detail?lawId=10497.
[61] Сангийн яам. Шилэн дансны мэдээлэл. www.shilendans.gov.mn/.

бүрхэг байгаа учраас уул уурхайн ТӨК-ууд жигд бус тайлагнаж байна.[62] Ямар төрийн өмчит аж ахуйн нэгж тайлагнах ёстой вэ гэдгийг нарийн тодорхойлоогүйн улмаас томоохон компаниуд, жишээлбэл, уул уурхайн салбарын хувьд хамгийн томд тооцогддог Оюу Толгой компани (төрийн өмчийн оролцоотой) нь Шилэн дансанд тайлагнахгүй байна. ОҮИТБС энэ асуудлыг судалж, чухал ач холбогдолтой ТӨК-ийг Шилэн дансны тайланд хамруулах зөвлөмж боловсруулах хэрэгтэй байна.

Шилэн дансны тухай хууль нь уул уурхайн бүх ТӨК-ийг жилийн худалдан авалтын төлөвлөгөөгөө жил бүрийн нэгдүгээр сарын 10-ны дотор нийтлэхийг шаарддаг. Хэдийгээр уул уурхайн олон компани 2024 онд төлөвлөгөөгөө илгээсэн боловч Эрдэнэс Метан, Гашуун сухайт авто зам зэрэг компаниуд нийтлээгүй байна. Түүнчлэн, tender.gov.mn гэсэн Засгийн газрын худалдан авалтын порталд засгийн газрын байгууллагууд тендерийн урилгаа нийтэлдэг. Энэ вэбсайт нь ТӨК-ийн худалдан авалтын үйл ажиллагаанд олон нийт хяналт тавих, ил тод байдлыг сайжруулах боломжийг олгодог.

ТӨК-ийн засаглалыг зохицуулдаг дүрэм журмыг ОҮИТБС-ын жилийн тайланд тусгай бүлэг болгон тайлбарладаг.[63] Уг тайланд зарим компанийн, тэр дотроо долоон ТӨК-ийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний тухай мэдээлсэн байна.[64] Гол холдинг компани болох Эрдэнэс Монгол өөрийн вэбсайтад охин болон харьяа компанийн мэдээллийг нийтэлдэг. Гэхдээ уг жагсаалт нь бүрэн бус гэж харагдаж байна. Тухайлбал Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр, Монголросцветмет, Таван толгой түлш, Эрдэнэс Баянбогд компанийн мэдээлэл байхгүй байна. Эдгээр охин болон харьяа компанийн удирдах зөвлөлийн мэдээлэл уг вэбсайтад мөн байхгүй байна. Зарим охин болон харьяа компани вэбсайтдаа удирдах зөвлөлийн мэдээллээ нийтэлдэг ч мөн л жигд бус байна. Олон тохиолдолд удирдах зөвлөлийн мэдээлэл огт байхгүй эсхүл вэбсайт нь ажилладаггүй. Багануур, Шивээ-Овоо, Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэс Монгол зэрэг компаниуд томилогдсон удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг жагсааж, хараат бус гишүүн сонгон шалгаруулах зарыг нийтэлжээ. Монголын газрын тосны үйлдвэр, Эрдэнэс Оюутолгой компани удирдах

[62] Намхайжанцангийн Дорждарь. “Монголын төрийн өмчит уул уурхайн компаниуд: Шилэн дансны мэдээллийн гүнд,” 2022 оны 5-р сар. www.resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolia_mining_soe_deeper_look_into_glass_accounts_data.pdf.
[63] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. “Монголын ОҮИТБС-ын 2022 нэгтгэл тайлан. 5.7.13-р хэсэг.”
[64] ОҮИТБС-ын Ажлын алба. Хавсралт 19.

зөвлөлийн гишүүдийн жагсаалтыг нийтэлсэн ч хараат бус гишүүн сонгон шалгаруулж байгаа эсэх мэдээлэл байхгүй байна.

2.6.c "ТӨК-ууд авлигын эсрэг бодлогоо нийтлэхийг хүлээж байгаа бөгөөд магадлан шалгах нухацтай үйл явцыг мөрдөхийг дэмжиж байна."

Цөөн ТӨК ОҮИТБС-ын Стандартын 1.2.b-ын дагуу авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг вэбсайтдаа нийтэлсэн байна. Хүснэгт 5-д энэ төрлийн төлөвлөгөөгөө вэбсайтдаа нийтэлсэн болон нийтлээгүй компанийг жагсаалаа. Харин ОҮИТБС-ын жилийн нэгтгэл тайланд эдгээр төлөвлөгөөг боловсруулсан эсэх тухай мэдээллийг ч оруулаагүй байна.

Хүснэгт 5. ТӨК-ууд вэбсайтдаа авлигын эсрэг бодлогоо нийтэлсэн явц

Нийтэлсэн эсэх	**Компани**
Тийм	**Багануур, Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэт, Шивээ-Овоо, Таван толгой түлш, Таван толгой төмөр зам**
Үгүй	Бадрах Энержи, Баян хишиг хараа, Баянтээг, Цемент шохой, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Эрдэнэс Алт Ресурс, Эрдэнэс Баянбогд, Эрдэнэс Метан, Эрдэнэс Монгол, Эрдэнэс Оюу Толгой, Гашуун сухай авто зам, Могойн гол, Мон-Атом, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр, Монголросцветмет, Оюу Толгой, Сэлэнгэ байгалийн нөөц, Тавантолгой, Улаанбаатар төмөр зам

ОҮИТБС нь ил тод байдлын энэхүү цоорхойг шийдвэрлэхийн тулд асуудлыг хэлэлцэж, компаниудыг авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан эсэх, хэрэв төлөвлөгөөтэй бол олон нийтэд зориулж нийтэлсэн эсэхээ тайлагнахыг шаардах хэрэгтэй. Түүнчлэн авлигын эсрэг төлөвлөгөөг тогтмол нийтлэх ёстой мэдээллийн төрөлд багтааж, компанийн вэбсайт, мөн магадгүй Шилэн дансны мэдээллийн санд нийтлэх нэмэлт өөрчлөлтийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд оруулах нь зүйтэй.

2.6.d "Холбогдох тохиолдолд ТӨК олборлох салбарт хийж буй хөрөнгө оруулалт (үндсэн хөрөнгө, өглөг зэргийг оруулсан)-аа ил тод нийтлэхийг дэмжиж байна. ТӨК нь эдгээр хөрөнгө оруулалт нь эрчим хүчний шилжилт, уур амьсгалын эрсдэлийн асуудалтай хэрхэн уялдаж байгааг ил тод нийтлэхийг мөн дэмжиж байна."

Шилэн дансны тухай хуульд бүх ТӨК-ийг хөрөнгө оруулалтын төслийн жагсаалт, төсвийг тайлагнахыг шаарддаг. Гэвч Багануур, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Монголросцветмет, Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэт, Эрдэнэс Монгол зэрэг цөөн тооны том компаниуд хөрөнгө оруулалтын мэдээллээ Шилэн дансны порталд нийтэлжээ. Бусад компаниуд "мэдээлэл байхгүй" гэж тайлагнасан эсхүл огт мэдээлэл оруулаагүй байна. Эрдэнэт үйлдвэр нь уур

амьсгалын өөрчлөлтийг бууруулах ажилд хөрөнгө оруулж буйгаа Ерөнхийлөгчийн Тэрбум мод санаачилгад[65] хандивласан санхүүжилтээ нийтлэх замаар тайлагнасан байна. Зарим ТӨК-ууд байгаль орчны төлөвлөгөө, нийгмийн хариуцлагын төслөөр дамжуулж Тэрбум мод санаачилгад нэгдсэн боловч зөвхөн гурван компани мод тарихад төсөвлөсөн хөрөнгө оруулалтын дүнгээ вэбсайтдаа нийтэлжээ.

ОҮИТБС-ын нэгтгэл тайланд зарим компанийн, тэр дундаа гурван ТӨК-ийн, 100 тэрбум төгрөг[66] (ойролцоогоор 29,670 ам.доллар) давсан дэд бүтцийн хөрөнгө оруулалтын мэдээллийг оруулсан боловч эрчим хүчний шилжилт, уур амьсгалын эрсдэлтэй холбоотой хөрөнгө оруулалтын шийдвэрийн талаар дурдаагүй байна.

2.6.e "Боломжтой тохиолдолд ТӨК нь төлөөлөгч эсхүл зуучлагч, материаллаг гүйлгээнд оролцож буй ханган нийлүүлэгчид эсхүл гэрээлэгчдийн хэн болох болон эцсийн өмчлөлийг нь ил нийтлэхийг дэмжиж байна."

ОҮИТБС-ын одоо хэрэглэж буй маягтад материаллаг гүйлгээнд оролцож буй төлөөлөгч, зуучлагч, ханган нийлүүлэгч, гэрээлэгч нарын эцсийн өмчлөгчийг ил тод болгохыг ТӨК-иас шаарддаггүй. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй ТӨК-ийн хувьд[67] зөвхөн компанийн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг хөрөнгийн биржийн вэбсайтад нийтэлж, харин эдгээр ТӨК-тай бизнесийн харилцаатай компаниудын дээрх мэдээллийг нийтэлдэггүй. Улсын бүртгэлийн газрын хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас хувьцаа эзэмшигчдийн тухай мэдээллийг авч болох бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд эцсийн өмчлөгчийн мэдээллийг нийтлэхийг шаардаж байгаа энэ үед уг эх сурвалжийг ашиглан эцсийн өмчлөгчийг тодорхой ТӨК-ийн өмчлөгч гэж тогтоох боломжгүй байна.

Шаардлага 3. Хайгуул ба бүтээгдэхүүн үйлдвэрлэл

3.1.b "...компаниуд нь боломжтой тохиолдолд газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын ордын эдийн засгийн хувьд үр ашигтай батлагдсан нөөцийн мэдээллийг ил нийтлэхийг дэмжиж байна."

[65] *Монцамэ*. "'Нэг тэрбум мод хөтөлбөр батлагдлаа." 2023 оны 3 дугаар сарын 15. www.montsame.mn/en/read/314707.
[66] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. "Монголын ОҮИТБС-ын 2022 нэгтгэл тайлан. Хавсралт 33."
[67] Монголын хөрөнгийн биржийн вэбсайт. ww.mse.mn.

ОҮИТБС-ын тайлангийн маягтад компаниудын батлагдсан нөөцөө мэдээлэх шаардлага байдаг. Тайлангийн систем шинэчлэгдэж, одоогоор ажиллахгүй байгаа тул энэ мэдээллийг илгээсэн компаниудын тоог авах боломжгүй байв. Түүнчлэн ОҮИТБС-ын нэгтгэл тайланд энэ мэдээллийг компани тус бүрээр задалсан мэдээлэл, хавсралт байхгүй бөгөөд хэдийгээр хавсралтын жагсаалтад "нөөцийн мэдээлэл" гэж дурдсан боловч ийм мэдээллийг орхигдуулсан байна. Энэ дутагдал нь Ашигт малтмал, газрын тосны газарт ч хамаатай бөгөөд тус газар батлагдсан нөөцийг компани тус бүрээр ангилж нийтэлдэггүй. Хэдийгээр зарим мэдээллийг авах боломжтой бөгөөд тухайлбал зургаан том компани өөрийн вэбсайт дээр батлагдсан нөөцийн мэдээллээ нийтэлсэн байгаа ч энэ төрлийн мэдээллийг хайж олоход бэрхшээлтэй байна.

3.2.d "Компаниуд нь борлуулалтын бодит хэмжээ болон үнийн дүнг төсөл тус бүрээр ил нийтлэхийг дэмжиж байна."

ОҮИТБС-ын тайлангийн маягтад компаниудыг борлуулалтын хэмжээг төсөл тус бүрээр нийтлэхийг зөвлөмж болгодог ч ОҮИТБС-ын 2022 оны тайланд[68] зөвхөн дөрвөн ТӨК-ийн мэдээлэл багтжээ. Эдгээр нь Баганuур, Бадрах Энержи, Оюу Толгой, Эрдэнэс Силвер Ресурс компани бөгөөд тухайн мэдээллийг төсөл бүрээр ангилж тайлагнаагүй байна. Хэрэв нэг компани хэд хэдэн төслийг зэрэг хэрэгжүүлж байвал борлуулалтын хэмжээг төслөөр задлах нь ярвигтай боловч ихэнх ТӨК-иуд цөөн тооны төслийг хариуцдаг учраас энэ мэдээллийг боловсруулах нь боломжгүй зүйл биш юм. Ер нь бол ТӨК нь том хэмжээний хэд хэдэн төсөл удирдаж байвал төсөл тус бүрийг хариуцах бие даасан ТӨК байгуулах нь тохиромжтой байх магадлалтай бөгөөд ингэснээр хуулийн этгээд болон төсөл бүрээр задалсан мэдээллийг тайлагнахад бэрхшээл гарахгүй юм.

ОҮИТБС-ын нэгтгэл тайланд компани тус бүрийн борлуулалтын хэмжээ, үнийн дүнг мэдээлдэг. Олборлолтын тоо баримтын талаарх ОҮИТБС-ын болон засгийн газрын бусад статистик нь ихэнх тохиолдолд зөрдөг тул мэдээллийн чанар хангалтгүй хэвээр байна. Энэ нь нэгтгэл тайланд зөвхөн цөөн тооны компанийг сонгон оруулж, борлуулалтын хэмжээнээс илүү төлбөрийн үнэн зөв байдалд илүү анхаардагтай холбоотой байх магадлалтай. ОҮИТБС төсөл бүрээр задалсан борлуулалтын мэдээллийг тайлагнадаггүйгээс гадна Шилэн дансны тухай эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн аль аль нь энэ мэдээллийг ил тод

[68] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. "Монголын ОҮИТБС-ын 2022 нэгтгэл тайлан. Хавсралт 22."

нийтлэхийг шаарддаггүй. Харин нэг хуулийн этгээд буюу нэг компани зөвхөн нэг төслийг хариуцан тайлан бэлтгэх тохиолдолд үүнийг төслийн түвшний мэдээлэл гэж үзэх боломжтой.

3.3.d "Экспортлогч компаниуд, мөн түүхий эдийн арилжаанд оролцогч болон бусад бүтээгдэхүүн худалдан авагчид нь борлуулалтын бодит хэмжээ болон үнийн дүнг төсөл тус бүрээр ил нийтлэхийг дэмжиж байна."

ОҮИТБС-ын тайлангийн маягт (шаардлага 3.2.d хэсэгт тайлбарласны дагуу) нь төсөл бүрээр ангилсан борлуулалтын хэмжээг мэдээлэхийг компаниудаас шаарддаг. ОҮИТБС-ын тайлан, хавсралтад бүтээгдэхүүн худалдан авагч мөн олборлогч ба худалдан авагчийн хоорондын зуучлагч нарын талаар хязгаарлагдмал мэдээллийг нийтэлдэг. ТӨК-ийн хувьд таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээг Шилэн дансанд тайлагнах ёстой бөгөөд гүйлгээ хийсэн этгээдийг уг тайлангаас харах боломжтой. Энэ мэдээллээр дамжуулан түүхий эдийн арилжаанд оролцогчийн борлуулалтын орлогыг шууд бусаар ажиглах боломжтой. Гэвч олон нэрсийн жагсаалтаас худалдан авагчийг (ТӨК-ийн орлогоо авч буй гэж тайлагнасан этгээд) хялбар ялгаж олох боломжгүй бөгөөд Шилэн дансанд гүйлгээний талаарх тайлбар мэдээллийг системтэйгээр нийтэлдэггүй. Түүнчлэн Шилэн данс нь бүх ТӨК-ийг, тухайлбал засгийн газар бага хэмжээний хувийг нь эзэмшдэг компанийг, үүнд олон нийтийн анхаарлын төвд байдаг Оюу Толгой зэрэг том компанийг хүртэл хамардаггүй.

3.3.e "Экспортлогч компаниуд болон хэрэгжүүлэгч улс орнууд нь худалдан авагч нь харилцан хамааралтай этгээд эсэхийг ил тод нийтлэхийг дэмжиж байна."

Энэ мэдээлэл нь ОҮИТБС-ын тайлан болон ихэнх компанийн вэбсайтад байдаггүй. Компаниудаас Татварын алба, Сангийн яаманд илгээдэг санхүүгийн тайланд харилцан хамааралтай этгээдтэй хийсэн гүйлгээний мэдээллийг хавсаргадаг бөгөөд компаниуд тайлангаа нийтлэхдээ хавсралтыг оруулдаггүй байна.

3.4.a "Компаниуд нь хүлэмжийн хий ялгаруулалтын мэдээллийг ил тайлагналын мөрдөгдөж буй шилдэг стандартад нийцүүлэн нийтлэхийг дэмжиж байна."

ОҮИТБС-ын тайланд одоогоор компанийн хүлэмжийн хийн ялгаруулалтын мэдээлэл ордоггүй. Бадрах Энержи, Оюу Толгой зэрэг компани вэбсайт дээрээ энэ мэдээллийг нийтэлж буй зэрэг зарим нэгэн ахиц гарч буй ч бүх ТӨК олон нийтэд зориулж энэ мэдээллийг бэлтгэдэг

болгохын тулд цогц арга хэмжээ авах хэрэгтэй байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд компанийн хүлэмжийн хийн ялгаруулалтыг мэдээлэх шаардлага байдаггүй.

Шаардлага 4. Орлого төвлөрүүлэлт

4.1.a "компаниуд нь шаардлагатай мэдээлэл (газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниас төрд төлж буй материаллаг төлбөр)-ийг засгийн газрын болон компанийн тайлангаар (вэбсайт, жилийн тайлан гэх мэт) дамжуулж ил мэдээлэхийг хүлээж байна."

ОҮИТБС-ын жилийн тайланд олборлох компаниас төсөвт төлсөн төлбөрийн тухай нарийвчлан мэдээлж, төлбөрийн төрлийн хувьд маш дэлгэрэнгүй тайлагнадаг. Монголын ОҮИТБС-ын тайланд 104 компани, үүнээс 14 ТӨК-ийн[69] дэлгэрэнгүй мэдээлэл орсон. Тайлангаа илгээсэн 2,000 компани дундаас эдгээр компанийг материаллаг босгод үндэслэн сонгожээ. ОҮИТБС нь тайлагнаж буй компанийг төрийн эзэмшлийн хэлбэрээр тодорхой ангилдаггүй учраас тайлан эсхүл хавсралтаас аль компани нь төрийн оролцоотой болохыг мэдэхэд төвөгтэй. Төлбөрийн тухай мэдээлэл нь төрийн болон орон нутгийн өмчит 13 компанийг хамарсан. Монголын ОҮИТБС нь ТӨК-ийг таньж ялгах, хянах явдлыг хялбар болгох нь зүйтэй.

ТӨК нь татвар, төлбөрийн мэдээллийг жилийн санхүүгийн тайландаа мөн тусгаж, эдгээр тайлан нь Шилэн дансанд нийтлэгддэг (Шилэн дансны тухай дээрх Шаардлага 2.6 хэсэгт тайлбарлав). Таван саяас дээш төгрөгийн гүйлгээг ТӨК-иуд Шилэн дансанд тайлагнадаг нь төсөвт төлж буй төлбөрийн мэдээллийг нарийвчлан ялган харуулж байгаа ч Шилэн дансанд мэдээлэх шаардлага бүх ТӨК-ийг хамрахгүй байгаа нь дутагдалтай тал юм. ТӨК нь хувийн хэвшлийн компанийн нэгэн адил бүх төрлийн татвар, төлбөрийг төлөх үүрэгтэй бөгөөд ОҮИТБС-ын тайлангийн маягт нь бүх төрлийн төлбөрийн мэдээллийг багтаасан байдаг.

4.1.d "... Төсөвт материаллаг төлбөр төлж буй газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд нь тогтоосон цар хүрээний дагуу материаллаг төлбөрийн иж бүрэн мэдээллийг ил нийтлэх шаардлагатай."

ТӨК-ийн төсөвт төлж буй материаллаг төлбөрийг тайлагнах асуудлыг дээрх Шаардлага 4.1.а хэсэг тайлбарлав.

[69] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба.

4.1.е Аж ахуйн нэгжүүд нь аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг, боломжгүй бол санхүүгийн гол үзүүлэлт (баланс, ашиг/алдагдлын тайлан, мөнгөн урсгал, татварын хувь хэмжээ гэх мэт)-ийг олон нийтэд ил тод болгох арга хэмжээ авна. Тайлант хугацаанд хамаарах татвар хасалт болон урамшууллыг нийтлэхийг дэмжиж байна.”

ТӨК-ууд нь төрийн аудитын дээд байгууллага болох Үндэсний аудитын газраар аудит хийлгэх үүрэгтэй бөгөөд ихэнхдээ аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг вэбсайт дээрээ нийтэлдэг. Үүнээс гадна ТӨК нь аудит хийлгэсэн тайланг Шилэн дансанд мэдээлэх шаардлагатай. Гэвч энэ хоёр эх сурвалжийн аль алинд бүх компанийн аудитын тайланг нийтлээгүй байна. Монголын ОҮИТБС нь Үндэсний аудитын газраас аудит хийсэн бүх ТӨК-ийн тайлангийн жагсаалтыг авах талаар ажиллах нь зүйтэй бөгөөд ингэснээр бүх санхүүгийн тайланг аудитаар баталгаажсан хувилбараар ил нийтэлж буй эсэх нь тодорхой болох юм.

ОҮИТБС-ын тайланд компанийн татвар хасалт, урамшууллын мэдээллийг нийтэлдэггүй. Шилэн дансанд тайлагнасан жилийн санхүүгийн тайлангаас зарим мэдээллийг гарган авах боломжтой ч ийм мэдээллийг дүгнэн шинжлэх хэмжээний нарийвчлал, тодорхой байдал дутмаг юм. ОҮИТБС нь энэхүү заавал бус тайлагналыг ТӨК-ийн түвшинд хэрэгжүүлэх талаар хэлэлцэх нь зүйтэй юм.

4.2.а “Газрын тос, байгалийн хий эсхүл ашигт малтмалын олборлосон баялгаас төрд ногдох хэсгийг борлуулсан эсхүл бүтээгдэхүүн хэлбэрээр хүлээн авсан бусад орлого нь материаллаг бол Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгж нь төрийн хүлээн авсан хэмжээ, төрийн (эсхүл төрийг төлөөлөн гуравдагч талын хийсэн) борлуулсан хэмжээ, борлуулалтын орлого, борлуулсан газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын орлогоос төрд шилжүүлсэн хэмжээ зэргийг ил тод мэдээлэх үүрэгтэй. Үүнд мөн своп гэрээ болон баялгаар баталгаажсан зээл (Шаардлага 4.3-ыг харна уу) байгаа бол тэдгээртэй холбоотой төлбөрийг (мөнгөн ба мөнгөн бус) багтаасан байх ёстой.”

ОҮИТБС-ын нэгтгэл тайланд газрын тосны олборлолтын компаниас засгийн газарт ногдох бүтээгдэхүүний борлуулалтын орлогын мөнгөн дүнг мэдээлдэг.[70] Гэвч төр ямар хэмжээний газрын тосны хувь хэмжээ авах, түүнчлэн энэ дүн нь борлуулалтын орлого эсхүл засгийн газар өөрөө борлуулах бүтээгдэхүүн хэлбэртэй гэх мэт нарийвчилсан мэдээлэл дутмаг байна. Өнөөдрийн байдлаар газрын тос олборлох үйл ажиллагаа эрхэлдэг ТӨК байхгүй.

[70] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. Хавсралт 12.

Газрын тосны олборлолтын хэдэн хувь нь ашиг, зардал, эсхүл төрийн эзэмшлийнх болох тухай мэдээллийг газрын тосны олборлолтын бүтээгдэхүүн хуваах гэрээнээс авч болно. Харин эдгээр гэрээг ил тод нийтлэх хуулийн шаардлага байдаггүй. Гэрээний нэгдсэн мэдээллийн санд нийтэлсэн гэрээнүүд нь дээрх мэдээллийг нууцалсан буюу засварласан хувилбар байдаг. Дахин дурдахад газрын тос олборлох үйл ажиллагаа эрхэлдэг ТӨК одоогоор байхгүй.

ОҮИТБС-ын жилийн тайланд ТӨК-ийн өрийн тухай мэдээллийг нийтэлдэг.[71] Гэвч энэ мэдээлэл нь дэлгэрэнгүй бус бөгөөд тайлагнасан мэдээллийг ашиглан баялгаар баталгаажсан зээл эсхүл своп гэрээ эсэхийг ойлгож, мэдэх боломжгүй байна. Уг тайланд компаниудын ихэвчлэн орон нутгийн засаг захиргаатай байгуулсан бартер солилцооны гэрээний мэдээллийг оруулдаг. Иймхүү тайлагнасан мэдээлэл нь баялгаар баталгаажсан зээл эсхүл своп гэрээг биш байж болно.

Нүүрсний салбарт 2023 онд гарсан “нүүрсний хулгайн” гэх дуулианаас хойш ТӨК-иуд нь урьдчилсан борлуулалт эсхүл хеджинг гэрээ (үнийн эрсдэлээс хамгаалах зорилгоор хийдэг гэрээ) байгуулахаас зайлсхийж байна. Нүүрс экспортлогчид худалдах-худалдан авах гэрээг татварын албанд илгээдэг бөгөөд ОҮИТБС нь татварын алба хүлээн авсан бүх гэрээний мэдээлэл, тухайлбал своп гэрээ, баялгаар баталгаажсан зээл эдгээр гэрээнд багтсан эсэх талаарх мэдээллийг нийтлэх талаар тус газартай хамтран ажиллах хэрэгтэй.

4.2.b “Санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд, тухайн орнуудын төрийн өмчит аж ахуйн нэгж нь бүтээгдэхүүнийг нь худалдан авагч компанийг сонгох үйл явцын тухай тайлбар, сонгон шалгаруулалтад ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд, сонгон авсан худалдан авагч компаниудын жагсаалт болон эцсийн өмчлөлийн мэдээлэл (боломжтой тохиолдолд), зуучлагч эсхүл төлөөлөгчийн мэдээлэл (байгаа тохиолдолд), худалдан авагч компанийг сонгохтой холбоотой эрх зүй, зохицуулалтын хүрээнээс материаллаг байдлаар давсан нөхцөлүүд, хамаарах борлуулалтын гэрээ зэргийг ил тод болгохыг дэмжиж байна.”

ОҮИТБС-ын жилийн тайланд худалдан авагч, ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулахдаа ТӨК-ийн баримтлах ёстой хууль эрх зүйн орчны талаарх мэдээллийг оруулдаг. Эдгээр асуудлын заримыг дээрх Шаардлага 2.6.c хэсэгтэй холбон тайлбарласан. Эрдэнэс Тавантолгой зэрэг зарим компани худалдан авагчийг сонгон шалгаруулах тухай дэлгэрэнгүй мэдээлэл,

[71] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. Хавсралт 30.

тендерийн урилга болон бусад холбогдох мэдээллийг вэбсайтдаа нийтэлдэг. Гэвч дийлэнх ТӨК худалдан авах ажиллагааны тухай буюу сонгон шалгаруулалтын шалгуур, эцсийн өмчлөлийн мэдээлэл, зуучлагч эсхүл төлөөлөгч томилох зэрэг мэдээллийг огт нийтэлдэггүй эсхүл дэлгэрэнгүй мэдээлэл өгдөггүй. Саяхнаас татварын газар экспортын бүх компанийг өөрсдийн худалдан авагчийн мэдээллийг илгээхийг шаардаж эхэлсэн. Энэ мэдээлэл нь эсхүл компаниудын илгээсэн гэрээний жагсаалт нь ОҮИТБС-ын тайлангаар дамжиж ил тод нийтлэгдэх боломжтой.

4.4.а "Газрын тос, байгалийн хий, ашигт малтмал тээвэрлэлтийн орлого нь материаллаг бол Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нь хүлээн авсан орлогыг ил тод болгох шаардлагатай."

ОҮИТБС-ын нэгтгэл тайланд ТӨК-ийн тээврийн үйл ажиллагааны талаарх бүлэг болон хавсралт ордог. Жишээлбэл, Тавантолгойн нүүрсний уурхайгаас БНХАУ-ын хил хүртэлх нүүрс тээврийн замыг Эрдэнэс Монгол ТӨК (холдинг компани) эзэмшдэг бөгөөд энэ үйл ажиллагаа компанийн хувьд орлогын чухал эх үүсвэр болдог. ОҮИТБС-ын цуглуулдаг мэдээлэл бүрэн бус учраас тээврийн компанийн талаар хангалттай ойлголт өгч чадахгүй байна. ОҮИТБС нь энэ шаардлагыг анхааралдаа авч, мэдээлэл цуглуулах, нийтлэх явцыг тогтмол бөгөөд үр дүнтэй болгох талаар ажиллах нь зүйтэй. Гашуун сухайт авто зам ТӨК нь нүүрс тээврийн автозамыг хариуцан ажилдаг Эрдэнэс Монголын охин компани бөгөөд Шилэн дансанд тайлангаа нийтэлдэг. Монголын ОҮИТБС болон түүний тайлангуудад тээврийн чиглэлд ажилладаг ямар ТӨК байдгийг баталгаажуулж, тэдгээрийн орлогын мэдээллийг Шилэн дансаар дамжуулан хянах боломжийг хангах хэрэгтэй. Одоогоор ОҮИТБС болон бусад эх сурвалжаас тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг ТӨК-ийн талаар мэдээлэл авах боломжгүй байна.

4.5.а "Олон талт оролцогчдын бүлэг нь тайлагнах үйл явцад төрийн өмчит аж ахуйн нэгжийн гүйцэтгэх үүргийг тодорхой гарган, тэднийг бүрэн хамруулж, газрын тос, байгалийн хий болон ашигт малтмал олборлох компаниудын зүгээс төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд хийсэн төлбөр, төрийн өмчит аж ахуйн нэгж төрийн байгууллагуудын хооронд хийгдэж буй материаллаг төлбөрийг хамруулах үүрэгтэй."

ОҮИТБС нь ТӨК-ийн гүйцэтгэх үүрэг, ТӨК-ийн төлбөр, гүйлгээг[72] ил тод нийтлэхийг зохицуулдаг дүрэм журмын талаар нэлээд задаргаатай тайлагнадаг ч ОҮИТБС-ын стандартад

[72] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. 5.7-р хэсэг.

нийцсэн байдлаар практик туршлагыг дэлгэрэнгүй мэдээлэх нь харьцангуй сул байна. Мөн мэдээллийн үнэн зөв байдал эргэлзээтэй бөгөөд үүнд ТӨК-ийн жагсаалт, хувь эзэмшлийн байдал, удирдах зөвлөл, ТӨК болон төр хоорондын төлбөрийн гүйлгээ зэрэг мэдээлэл орно. Монголын ОҮИТБС нь мэдээлэл цуглуулах үйл явцдаа ямар мэдээллийг орхигдуулж буйгаа судалж, тайлангийн зөрүү, давхардал зэрэгтэй холбоотойгоор ТӨК болон бусад компанийг зааглан харуулах аргачлалыг боловсруулах хэрэгтэй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь бүх салбарын ТӨК-ийн санхүү, үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл бүхий ТӨК-ийн нөхцөл байдлын тухай жилийн тайланг боловсруулдаг. Үндэсний аудитын газрын зарим ТӨК-т хийдэг гүйцэтгэлийн аудитад ТӨК-ийн эдийн засагт үзүүлэх үр нөлөөг илтгэх мэдээлэл ихэвчлэн ордог боловч санхүүгийн аудиттай харьцуулахад гүйцэтгэлийн аудитыг тогтмол хийдэггүйгээс гадна хуулиар шаардаггүй. ТӨК-иас засгийн газрын агентлаг, бусад ТӨК-т шилжүүлсэн төлбөрийг Шилэн дансанд тайлагнадаг таван сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээний жагсаалтаас харж болох ч төрийн эзэмших хувь хэмжээ бага байдаг компанийн мэдээллийг авах боломжгүй, гүйлгээний хүлээн авагчийг төрийн байгууллага эсхүл хувийн хэвшил гэдгээр шууд ялгаж, дүн шинжилгээ хийх боломжгүй байна.

4.10.c “Компаниуд болон хэрэгжүүлэгч улс орнууд нь зардлыг төсөл бүрээр, мөн үйл ажиллагааны болон капитал зардал гэж ангилсан мэдээллийг ил тод нийтлэхийг дэмжиж байна. Тайлант хугацаанд мэдүүлсэн үйл ажиллагааны зардалд өмнөх жилүүдэд гарсан зардлын элэгдэл, хорогдлыг тооцож болно. Компани болон хэрэгжүүлэгч улс орон нь төсөл эхэлснээс хойш гарсан бүх зардлыг тайлагнахыг дэмжиж байна.”

Төсөл тус бүрээр ангилсан мэдээлэл бэлтгэх нь Монголын ТӨК-ийн хувьд нэлээд бэрхшээлтэй асуудал юм. Үүний нэг шалтгаан нь аливаа татварыг хуулийн этгээдийн хүрээнд төлдөг бөгөөд уул уурхайн төслийн тодорхойлолт мөн хялбар биш юм. Тусгай зөвшөөрлийг төсөл гэж тодорхойлох санал гардаг боловч зарим төсөл хэд хэдэн тусгай зөвшөөрлийн хүрээнд явагддаг учраас энэ тодорхойлолт нь хэрэгжих боломжгүй юм. Нэг компани зөвхөн нэг төсөл хэрэгжүүлнэ гэж үзвэл хуулийн этгээд болон төслийн хоорондын ялгааг зааглах нь амар боловч бодит бус юм. Ийм нөхцөл байдалд төсөл бүрээр ангилсан тайлан бэлтгэх нь ярвигтай ажил болж байна. Монголын ОҮИТБС-ын нэгтгэл тайланд төслийн тодорхойлолтыг гаргах гэж оролдсон бөгөөд төслийн түвшний мэдээлэл бүхий хавсралт оруулсан ч мэдээлэл

нь дутуу, хэт ерөнхий тул татварын төлбөр гэх мэт гол асуудлын талаар мэдээлэл авахад хангалтгүй байна. Монголын ОҮИТБС нь ТӨК-ийн төсөл бүрээр ангилсан тайлангийн асуудлыг эргэн харж, хуулийн этгээдэд үндэслэсэн одоогийн тайланд төслийн түвшний мэдээллийг задалж харуулах хэрэгтэй байна. Төсөл эхэлснээс хойших нийт зардлыг ОҮИТБС-ын тайлан эсхүл өөр эх сурвалжид харуулдаггүй бөгөөд цөөн тооны том төслүүд өөрсдийн төслийн өсөн нэмэгдсэн зардлыг илтгэсэн ерөнхий бөгөөд чанарын мэдээлэл бэлтгэхээс бусад тохиолдолд ийм мэдээллийг авах боломжгүй байна.

Шаардлага 5. Орлогын менежмент ба зарцуулалт

5.3.c "Олон талт оролцогчдын бүлэг хүсэлт гаргасан тохиолдолд газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд нь төслийн үйлдвэрлэлийн хэмжээний талаарх төсөөлөл, зардлаа нөхөхөөр таамаглаж буй хугацаа зэрэг мэдээллийг ил тод болгохыг дэмжиж байна."

ОҮИТБС-ын нэгтгэл тайланд төслийн үйлдвэрлэлийн хэмжээний талаарх төсөөлөл эсхүл зардлаа нөхөхөөр таамаглаж буй хугацаа зэрэг мэдээлэл байдаггүй. Энэ төрлийн мэдээлэл нь техник-эдийн засгийн үндэслэлийн баримтад агуулагддаг боловч ийм судалгааг нийтэд зориулж нийтэлдэггүй. Засгийн газартай гэрээ байгуулах шаардлагатай эсхүл олон нийтийн дэмжлэг хэрэгтэй, ихэвчлэн том хэмжээний төслийн хувьд үйлдвэрлэлийн хэмжээний талаарх төсөөлөл эсхүл зардлаа нөхөх тооцоолол зэрэг мэдээлэл олон нийтийн анхаарал, хэлэлцүүлэгт өртөх тохиолдол гарч байсан. Жишээлбэл, хөрөнгө оруулагч болон засгийн газрын хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээний шатанд Оюутолгой, Тавантолгой зэрэг төслийн энэ төрлийн мэдээлэл олон нийтэд хүрч байсан. Эдгээр нь түгээмэл практик гэхээсээ илүү онцгой тохиолдол юм. Монголын ОҮИТБС нь компаниудаас энэ төрлийн мэдээллийг хүсэж байсан гэсэн нотолгоог судалгааны явцад олдоогүй болно.

Шаардлага 6. Нийгэм ба эдийн засгийн зардал

6.2.a "Олборлох салбар дахь төрийн оролцоотой холбоотойгоор эрдэс баялгийн салбараас материаллаг хэмжээний төлбөр, орлогыг олдог бол хэрэгжүүлэгч улс орнууд ТӨК-ийн төсвийн шинжтэй зарцуулалтын талаарх мэдээллийг ил нийтлэх шаардлагатай. Олон талт оролцогчдын бүлэг бусад төлбөр болон орлогын урсгалын нэгэн адил түвшинд тайлагнах явцыг хэрэгжүүлэх бөгөөд үүнд ТӨК-ийн охин болон хамтарсан компаниуд мөн хамаарна."

ОҮИТБС-ын нэгтгэл тайланд ТӨК-ийн төсвийн шинжтэй зардлын мэдээллийг Шилэн дансны ТӨК-ийн тайлантай[73] холбох байдлаар оруулдаг. Гэвч төсвийн шинжтэй зардлын тодорхойлолт нь ойлгомжгүй, мөн Шилэн дансанд энэ төрлийн зардлыг шүүх боломжтой тодорхой тайланг нийтэлдэггүй. Жишээлбэл, ТӨК-ийн нүүрсний уурхайд өгсөн нүүрсний татаас эсхүл нүүрсний дээд үнийн хязгаарыг тайлбарласан хэсэг Шилэн дансанд байдаггүй. ОҮИТБС-ын тайлагналын хүрээнд тухайн бусдад өгсөн хандив, дэмжлэгтэй холбоотойгоор компанийн нийгмийн хариуцлага эсхүл нийгмийн чиглэлийн хөрөнгө оруулалтынхаа талаар компаниуд тайлагнадаг.

6.3.a.iv "...Компаниуд жендерт суурилсан цалингийн ялгаатай байдлыг ил тод нийтлэхийг дэмжиж байна."

ОҮИТБС нь цахим тайлангийн системээрээ дамжуулж компаниудаас энэ төрлийн мэдээллийг цуглуулахыг хичээдэг.[74] ОҮИТБС-ын нэгтгэл тайланд компанийн нийт ажиллагсдын тоог хүйсээр ангилсан[75] мэдээлэл багтсан боловч цалингийн ялгааны талаар дурддаггүй. Оюу Толгой, Багануур зэрэг цөөн хэдэн том компани жилийн тайландаа жендерийн эсхүл компанийн нийгмийн хариуцлагын талаар мэдээлдэг ч эдгээр тайлангийн тоо баримт нь ажиллах хүчний тоог хүйсээр ангилахаас хэтрэхгүй байна.

6.4.b "Хэрэгжүүлэгч улс орнууд болон тайлагнагч компаниуд нь хууль тогтоомж болон гэрээний дагуу шаарддаг байгаль орчин, нийгэм, засаглалын үр нөлөөний судалгаа, мониторингийн тайлан, ердийн болон тусгай зөвшөөрлийн мэдээлэл нь бодит байдал дээр олон нийтэд хүртээмжтэй байхыг хангаж ажиллах үүрэгтэй."

Ихэнх компаниуд байгаль орчин, нийгэм, засаглалын үр нөлөөний судалгааг тогтмол бэлтгэх эсхүл нийтлэх практик байдаггүй. ОҮИТБС-ын тайланд байгаль орчин, нийгэм, засаглалтай холбоотой буюу химийн бодисын хэрэглээ, ус ашиглалт, орон нутгийн иргэд, орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ гэх мэт хэрэгтэй мэдээлэл ордог боловч энэ чиглэлийн тоо баримт эсхүл нөлөөллийн үнэлгээ байдаггүй. ОҮИТБС нь ТӨК-ийн байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг ОҮИТБС-ын тайлангаар дамжуулж ил тод нийтлэх тал дээр анхаарах хэрэгтэй байна. Багануур гэх мэт зарим нэгэн том ТӨК байгаль

[73] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. 5.7.14-р хэсэг.
[74] ОҮИТБС-ын вэбсайт нь системийн шинэчлэлийн улмаас идэвхгүй байсан тул мэдээллийг нийтлэх түвшин, мэдээллийн чанарыг баталгаажуулах боломжгүй байв.
[75] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. "Монголын ОҮИТБС-ын 2022 нэгтгэл тайлан. Хавсралт 14"

орчин, нийгэм, засаглалын тайланг өмнө нь боловсруулж байсан ч энэ нь салбарын хэмжээнд түгээмэл практик болж амжаагүй байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шаардлагаар уул уурхайгаас байгаль орчин, эрүүл мэнд, ан амьтанд үзүүлэх үр нөлөөг олон нийтэд тогтмол мэдээлэх ёстой. Гэвч энэ шаардлагыг биелүүлж буй нотолгоог судалгааны явцад олсонгүй.

6.4.c "Компаниуд нь нийгэм, жендер болон байгаль орчны менежмент, үр нөлөөний талаарх нэмэлт мэдээллийг ил нийтлэхийг дэмжиж байна."

Энэ асуудлыг дээр Шаардлага 6.4.b. хэсэгт тайлбарлав.

4. Дүгнэлт, зөвлөмж

Дүгнэлт

Монгол Улсын олборлох салбар нь улс орны эдийн засгийн гол нуруу бөгөөд хайгуул болон олборлолтын тусгай зөвшөөрөл, үйлчилгээ зэрэг чиглэлээр энэ салбарт олон компани үйл ажиллагаа эрхэлж байна. Түүнчлэн уул уурхайн болон уул уурхайтай холбоотой төслийг удирдах, хэрэгжүүлэх, хайгуул хийх зэрэг чиглэлд олон ТӨК-иуд ажиллаж байна. ТӨК-тай холбогдох авлига, буруу менежмент, алдагдалтай ажиллагаатай холбоотой хэрэг дуулиан байнга давтагдаж байгаа энэ үед ТӨК-ийн ил тод байдал, засаглал нь улам бүр чухал сэдэв болж байна. Энэ байдалд нөлөөлж буй зарим нэг шалтгааныг дурдвал уул уурхайн салбарт маш олон тооны ТӨК үйл ажиллагаа явуулж байгаа, ТӨК байгуулах нь харьцангуй хялбар, ТӨК-ийн олон төрлийг зөвшөөрдөг, ТӨК нь бизнесийн бус үйл ажиллагаанд оролцдог, чухал албан тушаалд улс төрийн томилгоо хийгддэг зэрэг орно. Удирдлага болон чухал албан тушаалтнууд байнга солигддог, тайлагналын арга хэрэгслүүд тэр бүр үр дүнтэй байж чадахгүй байгаа зэргээс шалтгаалж олон нийтийн үр дүнтэй хяналтыг бий болгох, дотоод хяналтын суурь бүтцийг бүрдүүлэхэд нэлээд бэрхшээлтэй байна. Энэ сэдвээр ББЗХ[76] зэрэг байгууллагаас олон судалгаа, үнэлгээг гүйцэтгээд байна.

ОҮИТБС нь Засгийн газар болон нийт уул уурхайн компаниудад, түүнчлэн уул уурхайн чиглэлийн ТӨК-д чиглэсэн нэлээд өргөн хүрээтэй шаардлагуудыг тавьдаг. Анх 2003 онд үүссэн цагаасаа хойш ОҮИТБС нэлээд боловсронгуй болж, 2023 оны Стандарт нь ТӨК-ийн ил тайлагнал, засаглалыг сайжруулах зорилгоор олон нийтэд зориулж мэдээллийг ил тод нийтлэх өргөн хүрээний шаардлагыг хамруулсан нь ОҮИТБС-ын хөгжлийн чухал үе шат болсон юм. Энэ санаачилгыг хэрэгжүүлж буй улс орны нэг тул Монгол Улс нь ОҮИТБС-ын Стандартыг ашиглан уул уурхайн ТӨК-ийг үр нөлөөтэй удирдах тогтолцоогоо сайжруулах нь зүйтэй юм. Гэвч ОҮИТБС нь дангаараа оршдоггүй бөгөөд ОҮИТБС-ын шаардлагууд нь ТӨК-ийг удирдах дотоодын өргөн хүрээний хууль эрх зүйн орчин болон Монгол Улсад 2006 оноос хойш ОҮИТБС-ыг хэрэгжүүлж ирсэн туршлагатай нягт уялдана. ОҮИТБС нь ТӨК-ийн ил тайлагналын талаарх мэдээллийг тогтмол нийтлэх хамгийн цогц бөгөөд системтэй арга барилыг санал болгодог тул Монгол Улс энэ санаачилгын тайлангийн тогтолцоо, олон талт

[76] Жишээ: Эндрю Бауэр, Намхайжанцангийн Дорждарь. "Барьцгүй өсөлт: Эрдэнэс Монголын үнэлгээ, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн. “Монгол Улсын уул уурхайн засаглал бага зэрэг сайжирсан боловч олон нийтэд мэдээлэл хүргэх болон төрийн өмчит компаниудын засаглалын асуудалд анхаарах шаардлагатай байна.

оролцогчдыг татан оролцуулдаг арга барилыг ашиглан ОҮИТБС-ын шаардлагыг бүрэн биелүүлэх чиглэлд дорвитой дэвшил гаргах шаардлагатай байна.

ОҮИТБС-ын өнөөгийн тайлагнал, мэдээлэл нь ихээхэн дэвшлийг авчирсан бөгөөд үнэн зөв, ач холбогдолтой бөгөөд бүх оролцогч талууд ашигладаг мэдээллийг бүрдүүлэх үндэс суурийг тавьсан. Гэвч бэрхшээл, сорилтууд олон байгаа бөгөөд тайлагналын тоо баримт, тогтолцоог хэд хэдэн чиглэлд сайжруулах хэрэгтэй байна. Үүнд:

- Өнөөдөр ил тод нийтэлж буй мэдээлэл нь уул уурхайн салбарын ТӨК-ийн үйл ажиллагааны олон чиглэлийг хамарч байгаа боловч нэг төрлийн мэдээллийг өөр өөр эх сурвалжаас авахад зөрүүтэй, мөн иж бүрэн биш байна. Жишээлбэл, уул уурхайн салбарт хэдэн ТӨК үйл ажиллагаа эрхэлж буй, эсхүл эдгээр ТӨК дахь төрийн хувь эзэмшлийн талаарх мэдээлэл зөрүүтэй байна. Ийм үндсэн мэдээлэл тодорхой бус, бодитой биш байх тохиолдолд түүнд итгэх итгэл буурч, мэдээллийг гуйвуулж гажуудуулах боломжтойгоос гадна бодлого, хяналтын чиглэлээр ашиглахад төвөгтэй.
- ОҮИТБС нь компани болон ТӨК-иас олон төрлийн мэдээлэл цуглуулдаг ч чанар, иж бүрэн байдал нь мэдээллийн төрөл болон компани тус бүрээр нэлээд ялгаатай байна. Татвар, бусад төлбөртэй холбоотой мэдээлэл дэлгэрэнгүй бөгөөд ерөнхийдөө чанартай байхад харьяа компанийн эцсийн өмчлөл, түүхий эдийн борлуулалт зэрэг ОҮИТБС-ын тайланд шаарддаг мэдээллийн чанар хангалтгүй байна. Үүнээс гадна ОҮИТБС-ын нэгтгэл тайланд их хэмжээний мэдээлэл оруулдаг ч эдгээр нь тоймлох шинжтэй бөгөөд ялангуяа татварын бус тоо баримт, мэдээллийн хувьд чанартай, нарийвчилсан буюу задгай мэдээллийг тулган тайлагнахад анхааралтай байна.
- Шилэн дансны тогтолцоо нь ТӨК-ийн тухай мэдээллийн хувьд чухал эх сурвалж юм. Гэвч энэ систем нь засгийн газрын бусад мэдээллийн сантай болон ОҮИТБС-ын мэдээлэлтэй холбогдоогүй. Түүнчлэн тодорхой төрлийн ТӨК-ийг хамруулдаггүй гэсэн зарим дутагдал байгаа боловч Шилэн дансны ТӨК-ийн тайлангийн хэсэг нь маш эерэг өөрчлөлт авчирсан тул цаашид сайжруулж, ОҮИТБС болон бусад зорилгоор мэдээлэл, тоо баримт цуглуулах ажилтай уялдуулж, холбох шаардлагатай байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас боловсруулдаг санхүү, эдийн засгийн статистикийн тайланд мөн үүнтэй төстэй байдал ажиглагдсан. ОҮИТБС-ын Стандартад нийтлэхийг шаарддаг зарим мэдээллийг, жишээлбэл ТӨК дахь төрийн хувь эзэмшил, засгийн газарт төлдөг төлбөр, охин компаниудын жагсаалт, худалдан авагч болон ханган нийлүүлэгчдийн мэдээлэл зэргийг Шилэн дансанд нийтэлдэг ч эдгээрийн заримыг нь

ОҮИТБС-ын тайлангийн маягт, шаардлагуудтай шууд харьцуулах боломжгүй байна. Шилэн данс нь ТӨК-ийн санхүүгийн төлөвийг тайлагнахад түлхүү анхаардаг учраас олборлолт, экспорт зэрэг зарим мэдээллийг хамруулахгүй байна.

- Олон эх сурвалжаас бэлтгэдэг ТӨК-ийн мэдээлэл, тоо баримтын дийлэнх хэсэг нь нээлттэй мэдээллийн форматын шаардлага хангахгүй байна. Ялангуяа Шилэн дансанд нийтэлдэг нэн хэрэгцээтэй мэдээлэл болох санхүүгийн тайланг программаар шууд таних хэлбэрээр бус зурган файлаар нийтэлдэг.
- Монголын ОҮИТБС болон олон талт оролцогчид ОҮИТБС-ын 2023 оны стандартын дагуу заавал шаарддаг эсхүл сайн дурааараа тайлагнах ТӨК-ийн тайлангийн сэдвээр яриа, хэлэлцүүлэг хараахан өрнүүлээгүй байна. ОҮИТБС-ын тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг энэ зорилгоор ашиглах нь зүйтэй байна.

Энэ тайлангийн “Судалгааны үр дүн” бүлэг дэх дэлгэрэнгүй тайлбар дээр нэмж эдгээр ерөнхий дүгнэлтийг танилцуулж байгаа болно.

Зөвлөмж

Энэ тайлангийн судалгааны үр дүн болон дүгнэлт хэсгүүдэд үндэслэн ТӨК-ийн ил тайлагналыг сайжруулахын тулд гүйцэтгэх ажлыг ерөнхий байдлаар дараах зөвлөмжид тусгаж, Монголын ОҮИТБС-ын оролцогч талуудад санал болгож байна. Үүнд:

- Тойм судалгааны тайланд үндэслэн олон талт оролцогчдын уулзалтыг зохион байгуулж, судалгааны гол үр дүн, дүгнэлтийг хэлэлцэн, ОҮИТБС-ын хэрэгжүүлбэл зохих ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх замын зураг, төлөвлөгөөг боловсруулах.
- Мэдээлэл, тоо баримт цуглуулах, тайлагнах, мэдээлэл солилцох ажлыг уялдаатай болгох, хялбаршуулах талаар Шилэн дансны үйл ажиллагааг хариуцдаг Сангийн яам, мөн татварын байгууллага, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрдэнэс Монгол нэгдэлтэй уулзалт зохион байгуулах. Жишээлбэл, мэдээлэл, тоо баримтын чанарыг сайжруулах, тайлан бэлтгэхэд компаниудад тулгардаг дарамтыг багасгах зорилгоор ОҮИТБС цахим систем нь Шилэн данс эсхүл татварын албанаас холбогдох мэдээллийг автоматаар шууд татах ажлыг хэрэгжүүлэх боломжтой. Үүнтэй зэрэгцүүлэн, ОҮИТБС-ын Стандартын дагуу шаарддаг ч Шилэн дансанд дутуу байдаг мэдээллийг хамруулахын тулд ОҮИТБС нь Шилэн дансыг сайжруулах ажлыг засгийн газарт санал болгох хэрэгтэй. Шилэн дансыг ТӨК-д тавигддаг ОҮИТБС-ын бүх шаардлагыг системтэйгээр нийтэлдэг суваг маягаар ашиглах нь хамгийн оновчтой

шийдэл байж болох юм. Гэхдээ тайланд хамруулдаг компаниуд, тайлагнах агуулгаас гадна тайлангийн хэлбэр, хугацаа, аудит болон нэгтгэлийн шаардлага зэрэг нь энэ хоёр системд ялгаатай байна. Эдгээр асуудлыг уялдаатай болгож шийдвэл Шилэн данс нь ТӨК-иуд ОҮИТБС-ын Стандартын шаардлагад нийцсэн тайланг агуулдаг платформ болж чадна.

- Уул уурхайн салбарын бүх ТӨК-д тайлангаа дэлгэрэнгүй, үнэн зөв, хугацаанд нь илгээх боломжийг бүрдүүлэх, байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулах зорилгоор ОҮИТБС-ын тайлангийн маягт, цахим тайлангийн системийг шинэчлэх зөвлөмж боловсруулах. Үүнд ОҮИТБС-аас шаарддаг боловч тайлагнадаггүй мэдээлэл буюу ТӨК-ийн тээврийн үйл ажиллагаа, гэрээний ил тод байдал, хүлэмжийн хийн ялгаруулалт, чулуужсан түлшинд хийх хөрөнгө оруулалт, жендерт суурилсан цалингийн ялгаатай байдал болон бусад мэдээлэл багтана.
- Жилийн нэгтгэл тайланг боловсруулдаг зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг ТӨК-тай холбоотой мэдээллийн чанарыг сайжруулах зорилгоор шинэчлэх.

Эдгээр ерөнхий зөвлөмжөөс гадна ТӨК-ийн тайлан гаргах тодорхой практиктай холбоотойгоор Монголын ОҮИТБС-ын хэрэгжүүлж болох дараах зөвлөмжийг санал болгож байна.

- ОҮИТБС-ын засаглалын бүтцэд том хэмжээний бүх ТӨК-ийн албан төлөөллийг өндөр түвшинд оруулах, ялангуяа ТӨК-тай холбоотой тайлантай холбоотой бүх ажилд идэвхтэй оролцуулах.
- Нэгтгэл тайланд хамрагдах ёстой компаниудыг ялгах жилийн материаллаг босгыг хянаж, бүх ТӨК-ийг нэгтгэлд хамрагдах шаардлага тавих.
- Эдийн засагт гол үүрэг гүйцэтгэдэг, төр цөөнх хувийг нь эзэмшдэг бүх төрлийн ТӨК-ийг багтаасан нэр томьёог ОҮИТБС-д хүрээнд нарийн тодорхойлох. Мөн түүнчлэн энэ салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бүх төрлийн ТӨК-ийн жагсаалтыг бүрдүүлж, тогтмол шинэчилж байх.
- Төр цөөнх хувийг эзэмшдэг хамтарсан компаниудын хамтрагч, томоохон ханган нийлүүлэгч ба түүхий эд худалдан авагчийн мэдээлэлд анхаарлаа хандуулах зорилгоор ТӨК-тэй хамаарал бүхий дээрх хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөлийн тайлангийн маягтыг шинэчлэх.
- Хэдийгээр төр цөөнх хувийг эзэмшдэг ТӨК нь Шилэн дансанд тайлагнах хуулийн шаардлага байхгүй ч ийм компанийг Шилэн дансны тухай хуулийн шаардлагыг

мөрдөхийг дэмжин ажиллах. Монголын ОҮИТБС нь төр цөөнх хувийг эзэмшдэг (стратегийн орд гэж хязгаарлаж болно) бүх ТӨК-ийг Шилэн дансны тухай хуульд хамруулах нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах зорилгоор засгийн газартай хамтран ажиллах.

- Үндэсний аудитын газар болон ТӨК-тай шууд ажиллаж, аудитаар баталгаажсан уул уурхайн ТӨК-ийн тайланг нийтлэх, хүртээмжийг хялбарчлах, аудит болон аудиторын жагсаалтыг ОҮИТБС-ын жилийн тайланд оруулах. Энэ ажилд мөн хувийн аудиторын гүйцэтгэдэг аудитын тайланг хамруулах нь зөв.
- ТӨК-иуд авлигын эсрэг бодлого боловсруулах, нийтлэх, бодлогын хэрэгжилтийг тайлагнах талаар Авлигатай тэмцэх газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрдэнэс Монгол болон бусад ТӨК-тай хамтран ажиллах.
- ТӨК-ийн удирдах зөвлөл, томилгоо болон өөрчлөлтийг тогтмол нийтэлж, цаг алдалгүй шинэчилдэг байх талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон ТӨК-тай хамтран ажиллах.
- Сангийн яам, татварын албатай ажиллах замаар ТӨК-ийн эдгээр байгууллагад илгээдэг борлуулалтын гэрээний жагсаалтыг авч, олон нийтэд зориулан тогтмол нийтлэх
- ОҮИТБС-ын хүрээнд хүлэмжийн хийн ялгаруулалтыг тайлагнах талаар хэлэлцүүлэг өрнүүлж, ажлын төлөвлөгөө боловсруулах.

Эдгээр зөвлөмжийг ажил хэрэг болгох нь ОҮИТБС-ын бүх оролцогч талын сонирхолтой нийцнэ гэдэгт итгэлтэй байна.

Хавсралт 1. ТӨК болон төрийн эзэмшил (хувиар)-ийн жагсаалт

ТӨК нэр, салбар	Төрийн эзэмшил (%)
Холдинг	
Эрдэнэс Монгол	100
Уул уурхай	
Адуунчулуун	0
Багануур	75
Баянтээг	70
Эрдэнэс Алт Ресурс	100
Эрдэнэс Оюу Толгой	100
Эрдэнэс Тавантолгой	73.51
Эрдэнэт	100
Могойн гол	51
Монголросцветмет	100
Оюу Толгой	34
Сэлэнгэ байгалийн нөөц	-
Шивээ-Овоо	90
Тавантолгой	51
Хайгуул	
Бадрах Энержи	34
Баян Хишиг Хараа	-
Эрдэнэс Баянбогд	34
Эрдэнэс Метан	100
Гурван сайхан	85
Метан Газ Ресурс	-

ТӨК нэр, салбар	Төрийн эзэмшил (%)
Хайгуул	
Мон-Атом	100
Мончех Ураниум	51
Боловсруулах	
Дарханы төмөрлөгийн үйлдвэр	100
Эрдэнэс Стийл	50
Монгол газрын тосны боловсруулах үйлдвэр	100
Таван Толгой Түлш	49
Үйлчилгээ	
Багануур илч	100
Эрдэнэт медикал эмнэлэг	-
Эрдэнэт Минерал Солюшн	-
Шивээ сервис	-
Дэд бүтэц	
Цемент шохой	100
Эрдэнэс шивээ эрчим	50
Эрдэнэс үйлдвэрлэл, технологийн парк	100
Гашуун сухайт авто зам	42
Уул уурхайн бирж	100
Мон Цахим	-
Таван толгой төмөр зам	100
Улаанбаатар төмөр зам	50
Санхүү	
Эрдэнэс ашид	34
Эрдэнэс ассет менежмент	100

Хавсралт 2. ТӨК-ийн мэдээллийг ил тод нийтлэх талаарх ОУИТБС-ын шаардлага

Шаардлага 1. Олон талт оролцогчдын бүлгийн хяналт

Шаардлага	**Түвшин**	**Заалт**	**Зөвхөн ТӨК-т хамаатай эсэх**	**Бүх ТӨК мөрдөх эсэх**
Шаардлага 1. Олон талт оролцогчдын бүлгийн зүгээс тавих хяналт	Шаардлагатай	1.2.a Компаниуд нь ОУИТБС-ын үйл ажиллагаанд бүрэн дүүрэн, идэвхтэй, үр дүнтэйгээр оролцох шаардлагатай.	Үгүй	Тийм
	Хүлээж байгаа	1.2.b Тайлагнагч компаниуд нь авлигын эсрэг бодлогоо, үүнд эцсийн өмчлөгчийн мэдээллээ нийтлэх нь зүйтэй.	Үгүй	Тийм

Шаардлага 2. Эрх зүйн болон институтийн тогтолцоо

Шаардлага	**Түвшин**	**Заалт**	**Зөвхөн ТӨК-т хамаатай эсэх**	**Бүх ТӨК мөрдөх эсэх**
Шаардлага 2. Эрх зүйн болон институтийн тогтолцоо, гэрээ, тусгай зөвшөөрөл	Шаардлагатай	2. 5.c "... компаниуд нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг олон нийтэд зориулж нийтлэх шаардлагатай.	Үгүй	Тийм
		2.5.e.3 "Хөрөнгийн биржид бүртгэлтэй компани, тэдний 100% эзэмшлийн охин компанийн хувьд тухайн биржийн нэрийг мэдээлж, эцсийн өмчлөгчийн тухай мэдээллийг олон нийтэд үзэх боломжийг олгох үүднээс хөрөнгийн биржид гаргасан тайлангийн холбоосыг ил нийтэлнэ.	Үгүй	Зарим
		2.5.e.5 "ТӨК нь тухайн компанийг өмчилдөг эсхүл хянадаг улсын нэр, өмчлөлийн хэмжээ, өмчлөлийн хэлбэрийг хэрхэн хянадаг талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ил тод болгох ёстой.	Тийм	Тийм
		2.5.e.5 "Хэрэв ТӨК-ийг төр бүхэлд нь өмчилдөггүй бол Шаардлага 2.5(c)-ын дагуу эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил нийтлэх үүрэгтэй."	Тийм	Тийм
		2.6.a.i "...хэрэгжүүлэгч улс орнууд нь дараах мэдээллийг ил тод нийтлэх үүрэгтэй ... Салбар дахь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэх үүрэг, Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгж хоорондын санхүүгийн харилцааг зохицуулсан үндсэн журам, практикийн тухай дэлгэрэнгүй тайлбар. Үүнд төрийн өмчит аж ахуйн нэгж болон засгийн газрын хооронд хөрөнгө шилжүүлэх	Тийм	Үгүй

		дүрэм, хуримтлагдсан ашиг, нэмж хийсэн хөрөнгө оруулалт болон гуравдагч талын санхүүжилт гэх мэт асуудал орно. Түүнчлэн төрийн өмчит аж ахуйн нэгжийн охин болон харьяа компанитай холбоотойгоор хийсэн хоорондын шилжүүлэг, хуримтлагдсан ашиг, нэмж хийсэн хөрөнгө оруулалт болон гуравдагч талын санхүүжилт зэргийг ил нийтлэх ёстой".		
		2.6.a.ii ""...Хэрэгжүүлэгч улс орнууд дараах мэдээллийг ил тод нийтлэх үүрэгтэй.... Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгж нь тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос болон байгалийн хийн компаниудад эзэмших өөрсдийн хувь эзэмшлийн хэмжээ. Энэ нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн охин болон харьяа аж ахуйн нэгж болон тайлангийн хугацаанд эзэмшилд гарсан өөрчлөлтийн тухай мэдээллийн хувьд нэгэн адил хамааралтай."	Тийм	Үгүй
		2.6.b "Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нь аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг, боломжгүй бол санхүүгийн гол үзүүлэлтүүдийг (баланс, ашиг/алдагдлын тайлан, мөнгөн урсгал гэх мэт) олон нийтэд ил тод болгох шаардлагатай. Тайлан гаргагч нь аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг хугацаанд нь нийтлэхэд саад болж буй хууль эрх зүйн болон зохицуулалтын бэрхшээлийг тодорхой баримтжуулах ёстой."	Тийм	Тийм
		2.6.c "Санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны болон хөрөнгийн зардал, худалдан авалт, туслан гүйцэтгэгч ажиллуулах болон компанийн засаглалтай (ТУЗ-ийн бүрэлдэхүүн, томилгоо, чиг үүрэг, ёс зүйн дүрэм гэх мэт) холбоотой дүрэм журам болон практикийг тайлбарлан мэдээлэх шаардлагатай."	Тийм	Үгүй
	Хүлээж байгаа	2.6.c "ТӨК-ууд нь авлигын эсрэг бодлогоо нийтлэхийг хүлээж байгаа...	Тийм	Тийм
	Дэмжиж байгаа	2.5.g "Компаниуд нь эцсийн өмчлөгч хүртэлх завсрын өмчлөгч хуулийн этгээдийн бүхий л сүлжээг харуулсан өмчлөлийн бүтцийг ил нийтлэхийг дэмжиж байна."	Үгүй	Зарим

		2.6.c “ТӨК-ууд нь ... магадлан шалгах нухацтай үйл явцыг мөрдөхийг дэмжиж байгаа.”	Тийм	Тийм
		2.6.d “Холбогдох тохиолдолд ТӨК олборлох салбарт хийж буй хөрөнгө оруулалт (үндсэн хөрөнгө, өглөг зэргийг оруулсан)-аа ил тод нийтлэхийг дэмжиж байна. ТӨК нь эдгээр хөрөнгө оруулалт нь эрчим хүчний шилжилт, уур амьсгалын эрсдэлийн асуудалтай хэрхэн уялдаж байгааг ил тод нийтлэхийг мөн дэмжиж байна.”	Тийм	Тийм
		2.6.e “Боломжтой тохиолдолд ТӨК нь төлөөлөгч эсхүл зуучлагч, материаллаг гүйлгээнд оролцож буй ханган нийлүүлэгчид эсхүл гэрээлэгчдийн хэн болох болон эцсийн өмчлөлийг нь ил нийтлэхийг дэмжиж байна.”	Тийм	Тийм

Шаардлага 3. Хайгуул ба бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Шаардлага	**Түвшин**	**Заалт**	**Зөвхөн ТӨК-т хамаатай эсэх**	**Бүх ТӨК мөрдөх эсэх**
Шаардлага 3. Хайгуул ба бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Дэмжиж байгаа	3.1.b “...компаниуд нь боломжтой тохиолдолд газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын ордын эдийн засгийн хувьд үр ашигтай батлагдсан нөөцийн мэдээллийг ил нийтлэхийг дэмжиж байна.”	Үгүй	Тийм
		3.2.d “компаниуд нь борлуулалтын бодит хэмжээ болон үнийн дүнг төсөл тус бүрээр ил нийтлэхийг дэмжиж байна.”	Үгүй	Тийм
		3.3.d “Экспортлогч компаниуд, мөн түүхий эдийн арилжаанд оролцогч болон бусад бүтээгдэхүүн худалдан авагчид нь борлуулалтын бодит хэмжээ болон үнийн дүнг төсөл тус бүрээр ил нийтлэхийг дэмжиж байна.”	Үгүй	Зарим
		3.3.e “Экспортлогч компаниуд болон хэрэгжүүлэгч улс орнууд нь худалдан авагч нь харилцан хамааралтай этгээд эсэхийг ил тод нийтлэхийг дэмжиж байна.”	Үгүй	Зарим
		3.4.a “Компаниуд нь хүлэмжийн хий ялгаруулалтын мэдээллийг ил тайлагналын мөрдөгдөж буй шилдэг стандартад нийцүүлэн нийтлэхийг дэмжиж байна.”	Үгүй	Тийм

Шаардлага 4. Орлого төвлөрүүлэлт

Шаардлага	**Түвшин**	**Заалт**	**Зөвхөн ТӨК-т хамаатай эсэх**	**Бүх ТӨК мөрдөх эсэх**
Шаардлага 4. Орлого төвлөрүүлэлт	Шаардлагатай	4.1.d "... Төсөвт материаллаг төлбөр төлж буй газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд нь тогтоосон цар хүрээний дагуу материаллаг төлбөрийн иж бүрэн мэдээллийг ил нийтлэх шаардлагатай."	Үгүй	Зарим
		4.2.a "Газрын тос, байгалийн хий эсхүл ашигт малтмалын олборлосон баялгаас төрд ногдох хэсгийг борлуулсан эсхүл бүтээгдэхүүн хэлбэрээр хүлээн авсан бусад орлого нь материаллаг бол Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгж нь төрийн хүлээн авсан хэмжээ, төрийн (эсхүл төрийг төлөөлөн гуравдагч талын хийсэн) борлуулсан хэмжээ, борлуулалтын орлого, борлуулсан газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын орлогоос төрд шилжүүлсэн хэмжээ зэргийг ил тод мэдээлэх үүрэгтэй. Үүнд мөн своп гэрээ болон баялгаар баталгаажсан зээл (Шаардлага 4.3-ыг харна уу) байгаа бол тэдгээртэй холбоотой төлбөрийг (мөнгөн ба мөнгөн бус) багтаасан байх ёстой."	Тийм	Тийм
		4.4.a "Газрын тос, байгалийн хий, ашигт малтмал тээвэрлэлтийн орлого нь материаллаг бол Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нь хүлээн авсан орлогыг ил тод болгох шаардлагатай."	Тийм	Зарим
		4.5.a "Олон талт оролцогчдын бүлэг нь тайлагнах үйл явцад төрийн өмчит аж ахуйн нэгжийн гүйцэтгэх үүргийг тодорхой гарган, тэднийг бүрэн хамруулж, газрын тос, байгалийн хий болон ашигт малтмал олборлох компаниудын зүгээс төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд хийсэн төлбөр, төрийн өмчит аж ахуйн нэгж төрийн байгууллагуудын хооронд хийгдэж буй материаллаг төлбөрийг хамруулах үүрэгтэй."	Тийм	Үгүй
	Хүлээж байгаа	4.1.a "компаниуд нь шаардлагатай мэдээлэл (газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниас төрд төлж буй материаллаг төлбөр)-ийг засгийн газрын болон компанийн тайлангаар (вэбсайт, жилийн тайлан гэх мэт) дамжуулж ил мэдээлэхийг хүлээж байна."	Үгүй	Тийм
		4.1.e Аж ахуйн нэгжүүд нь аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг, боломжгүй бол санхүүгийн гол үзүүлэлт (баланс, ашиг/алдагдлын	Үгүй	Тийм

		тайлан, мөнгөн урсгал, татварын хувь хэмжээ гэх мэт)-ийг олон нийтэд ил тод болгох арга хэмжээ авна.		
	Дэмжиж байгаа	4.1.e ...Тайлант хугацаанд хамаарах татварын хасалт болон урамшууллыг нийтлэхийг дэмжиж байна.”	Үгүй	Тийм
		4.2.b “Санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд, тухайн орнуудын төрийн өмчит аж ахуйн нэгж нь бүтээгдэхүүнийг нь худалдан авагч компанийг сонгох үйл явцын тухай тайлбар, сонгон шалгаруулалтад ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд, сонгон авсан худалдан авагч компаниудын жагсаалт болон эцсийн өмчлөлийн мэдээлэл (боломжтой тохиолдолд), зуучлагч эсхүл төлөөлөгчийн мэдээлэл (байгаа тохиолдолд), худалдан авагч компанийг сонгохтой холбоотой эрх зүй, зохицуулалтын хүрээнээс материаллаг байдлаар давсан нөхцөлүүд, хамаарах борлуулалтын гэрээ зэргийг ил тод болгохыг дэмжиж байна.”	Тийм	Тийм
		4.10.c “Компаниуд болон хэрэгжүүлэгч улс орнууд нь зардлыг төсөл бүрээр, мөн үйл ажиллагааны болон капитал зардал гэж ангилсан мэдээллийг ил тод нийтлэхийг дэмжиж байна. Тайлант хугацаанд мэдүүлсэн үйл ажиллагааны зардалд өмнөх жилүүдэд гарсан зардлын элэгдэл, хорогдлыг тооцож болно. Компани болон хэрэгжүүлэгч улс орон нь төсөл эхэлснээс хойш гарсан бүх зардлыг тайлагнахыг дэмжиж байна.”	Үгүй	Тийм

Шаардлага 5. Орлогын менежмент ба зарцуулалт

Шаардлага	**Түвшин**	**Заалт**	**Зөвхөн ТӨК-т хамаатай эсэх**	**Бүх ТӨК мөрдөх эсэх**
Шаардлага 5. Орлогын менежмент ба зарцуулалт	Дэмжиж байгаа	5.3.c “Олон талт оролцогчдын бүлэг хүсэлт гаргасан тохиолдолд газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд нь төслийн үйлдвэрлэлийн хэмжээний талаарх төсөөлөл, зардлаа нөхөхөөр таамаглаж буй хугацаа зэрэг мэдээллийг ил тод болгохыг дэмжиж байна.”	Үгүй	Тийм

Шаардлага 6. Нийгэм ба эдийн засгийн зардал

Шаардлага	**Түвшин**	**Заалт**	**Зөвхөн ТӨК-т хамаатай эсэх**	**Бүх ТӨК мөрдөх эсэх**
Шаардлага 6. Нийгэм ба эдийн засгийн зардал	Шаардлагатай	6.2.a “Олборлох салбар дахь төр оролцоотой холбоотойгоор эрдэс баялгийн салбараас материаллаг хэмжээний төлбөр, орлогыг олдог бол хэрэгжүүлэгч улс орнууд ТӨК-ийн төсвийн шинжтэй зарцуулалтын талаарх мэдээллийг ил нийтлэх шаардлагатай…	Тийм	Үгүй
		6.2.a “…Олон талт оролцогчдын бүлэг бусад төлбөр болон орлогын урсгалын нэгэн адил түвшинд тайлагнах явцыг хэрэгжүүлэх бөгөөд үүнд ТӨК-ийн охин болон хамтарсан компаниуд мөн хамаарна.”	Тийм	Үгүй
		6.4.b “Хэрэгжүүлэгч улс орнууд болон тайлагнагч компаниуд нь хууль тогтоомж болон гэрээний дагуу шаарддаг байгаль орчин, нийгэм, засаглалын үр нөлөөний судалгаа, мониторингийн тайлан, ердийн болон тусгай зөвшөөрлийн мэдээлэл нь бодит байдал дээр олон нийтэд хүртээмжтэй байхыг хангаж ажиллах үүрэгтэй.”	Үгүй	Тийм
	Дэмжиж байгаа	6.3.a.iv “…компаниуд жендерт суурилсан цалингийн ялгаатай байдлыг ил тод нийтлэхийг дэмжиж байна.”	Үгүй	Тийм
		6.4.c “Компаниуд нь нийгэм, жендер болон байгаль орчны менежмент, үр нөлөөний талаарх нэмэлт мэдээллийг ил тод нийтлэхийг дэмжиж байна.”	Үгүй	Тийм

Хавсралт 3. Шилэн дансны ТӨК-ийн ил тайлагналын шаардлага

ТӨК-аас Шилэн дансны мэдээлэл бэлтгэх шаардлага

6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;
6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;
6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;
6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;
6.1.5.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор;
6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.
6.4.1.тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт;
6.4.2.тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт;
6.4.3.тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;
6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;
6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;
6.4.6.худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн;
6.4.7.байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт;
6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

Хавсралт 4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль дах ТӨК-д тавих ил тайлагналын шаардлага

Санхүү, төсөвтэй холбоотой шаардлага

8.4.1.өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл, Төсвийн тухай хуулийн 8.4.3-т заасан төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн санал, Төсвийн тухай хуулийн 54.5.4-т заасан мэдээлэл;

8.4.2.төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;

8.4.3.санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;

8.4.4.хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;

8.4.5.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;

8.4.6.таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

8.4.7.цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;

8.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

8.4.9.шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;

8.4.11.худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;

8.2.3.эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;

8.6.5.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;

8.6.7.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьд нэгдсэн төсөв болон Үндэсний баялгийн санд оруулж байгаа татвар, хөрөнгийн хэмжээ;

8.6.8.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;

Засаглал, зохион байгуулалттай холбоотой шаардлага

8.4.9.шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;

8.4.10.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

8.4.11.худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;

8.4.27.мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;

8.2.2.чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;

8.2.3.эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;

8.2.6.үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;

8.2.7.албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;

8.2.8.өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;

8.3.2.албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;

8.3.3.албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;

8.3.4.хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;

8.3.5.хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;

8.3.6.албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.

8.5.2.зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа

8.6.2.эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;

8.6.4.мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;

8.6.5.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;

8.6.6.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;

8.6.8.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;

8.6.21.мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, суралцсан болон суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;

Монгол Улсын олборлох салбарын төрийн өмчит компаниудын ил тайлагналын тойм судалгаа

ТӨК-ийн үүрэг, үйл ажиллагаа, гэрээлэгч, байгаль орчин, нийгэм, засаглал, эцсийн өмчлөл зэрэг бусад асуудалтай холбогдох шаардлага

8.4.12.мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;

8.4.23.төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулсан тухай бүрд хувийн хэвшлийн түншлэгч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, түншлэлийн зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл;

8.2.1.эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;

8.2.10.мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.

8.3.1.ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;

8.6.9.хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл;

8.6.10.мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;

8.6.12.тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт олгосон газар ашиглах гэрчилгээ, байгуулсан гэрээ, газар ашигласны төлбөр төлөлтийн байдал;

8.6.13.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;

8.6.19.хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;

Хавсралт 5. Уул уурхайн салбарын ТӨК, бүтээгдэхүүний төрлөөр

	Бүтээгдэхүүн	**ТӨК-ийн тоо**
	Үйлчилгээ	14
	Нүүрс	10
	Уран	4
	Зэс	3
	Төмрийн хүдэр	2
	Алт	2
	Цемент	1
	Уламжлалт бус газрын тос	1
	Метан	1
	Газрын тос	1
	Жонш	1
Нийт		**40**

Хавсралт 6. ТӨК-ийн Шилэн дансанд нийтэлсэн байдал

Компани, дэд салбараар	**Шилэн дансны тайлан**
Уран	
Бадрах Энержи	Үгүй
Гурван сайхан	Үгүй
Мончех Ураниум	Үгүй
Нүүрс	
Багануур	Тийм
Эрдэнэс Баянбогд	Тийм
Эрдэнэс Тавантолгой	Тийм
Могойн гол	Тийм
Шивээ-Овоо	Тийм
Таван Толгой	Тийм
Цемент	
Цемент шохой	Тийм
Төмрийн хүдэр	
Дарханы төмөрлөгийн үйлдвэр	Тийм
Алт	
Эрдэнэс Алт Ресурс	Тийм
Сэлэнгэ байгалийн нөөц	Үгүй
Үйлчилгээ	
Эрдэнэс Монгол	Тийм
Улаанбаатар төмөр зам	Тийм
Зэс	
Эрдэнэт	Тийм
Оюу Толгой	Үгүй
Жонш	
Монголросцветмет	Тийм

Хавсралт 7. ОҮИТБС-ын стандарт болон хууль эрх зүйн шаардлагын харьцуулалт

Шаардлага	ОҮИТБС-ын заалт	Хууль эрх зүйн шаардлага	Практикийн талаарх тайлбар
Шаардлага 1	1.2. Компаниудын оролцоо Компаниуд нь ОҮИТБС-ын үйл ажиллагаанд бүрэн дүүрэн, идэвхтэй, үр дүнтэйгээр оролцох шаардлагатай.	Хамаарахгүй	Ашигт малтмалын хуулийн 48.10-д борлуулалтын хэмжээ болон төсөвт төлсөн төлбөрийг нийтэд мэдээлэхийг шаарддагаас бусад тохиолдолд компанийг ОҮИТБС-д оролцохыг шаарддаг хууль тогтоомж байхгүй. Засгийн газрын 2006 оны 1 тоот тогтоолын дагуу Монгол Улс нь ОҮИТБС-д нэгдэж, томоохон компаниуд гарын үсэг зурсан гурван талт санамж бичиг байгуулсан нь хууль эрх зүйн гол баримт бичиг хэвээр байна. Хууль тогтоомжийн үндэслэлийг сайжруулах хэрэгтэй.
Шаардлага 2	2.5. Эцсийн өмчлөл “...компаниуд нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг олон нийтэд зориулж нийтлэх шаардлагатай” “Хөрөнгийн биржид бүртгэлтэй компани, тэдний 100% эзэмшлийн охин компанийн хувьд тухайн биржийн нэрийг мэдээлж, эцсийн өмчлөгчийн тухай мэдээллийг олон нийтэд үзэх боломжийг олгох үүднээс хөрөнгийн биржид гаргасан тайлангийн холбоосыг ил нийтэлнэ.” “ТӨК нь тухайн компанийг өмчилдөг эсхүл хянадаг улсын нэр, өмчлөлийн хэмжээ, өмчлөлийн хэлбэрийг хэрхэн хянадаг талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ил тод болгох ёстой...” “... Хэрэв ТӨК-ыг төр бүхэлд нь өмчилдөггүй бол Шаардлага 2.5(c)-ын дагуу эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил нийтлэх үүрэгтэй.” “Компаниуд нь эцсийн өмчлөгч хүртэлх завсрын өмчлөгч хуулийн этгээдийн бүхий л сүлжээг харуулсан өмчлөлийн бүтцийг ил нийтлэхийг дэмжиж байна.”	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу засгийн газар нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөл, компанийн эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээний тухай мэдээллийг нийтлэх ёстой.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын бүртгэлийн мэдээллийн санд бүх төрлийн хуулийн этгээдийн мэдээлэл байдаг бөгөөд үүнд хувьцаат компани болон компанийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл багтана. ОҮИТБС-ын нэгтгэл тайланд эцсийн өмчлөлийн тухай мэдээлэл байдаг ч мэдээллийн чанарыг нягталдаггүй. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас компаниудын дэлгэрэнгүй жагсаалт бүхий тайланг гаргадаг ч ТӨК-ийн охин компанийн мэдээлэл багтдаггүй. Монголын хөрөнгийн биржид бүх хувьцаат компанийн мэдээлэл байдаг. Шилэн дансанд эдгээр мэдээллийг нэгтгэхийн тулд уг платформыг сайжруулах шаардлагатай.

Монгол Улсын олборлох салбарын төрийн өмчит компаниудын ил тайлагналын тойм судалгаа

Шаардлага 2	2.6. Төрийн оролцоо “Олборлох салбар дахь төрийн оролцооноос үүдэн материаллаг орлогын төлбөр төлөх тохиолдолд санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд нь дараах мэдээллийг ил тод болгох ёстой ... “ “Салбар дахь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэх үүрэг, Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгж хоорондын санхүүгийн харилцааг зохицуулсан үндсэн дүрэм, практик туршлагын тухай дэлгэрэнгүй тайлбар. Үүнд төрийн өмчит аж ахуйн нэгж болон засгийн газрын хооронд хөрөнгө шилжүүлэх дүрэм, хуримтлагдсан ашиг, нэмж хийсэн хөрөнгө оруулалт болон гуравдагч талын санхүүжилт гэх мэт асуудал орно.” “Олборлох салбар дахь төрийн оролцооноос үүдэн материаллаг орлогын төлбөр төлөх тохиолдолд санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд нь дараах мэдээллийг ил тод болгох ёстой... “ “Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгж нь тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос болон байгалийн хийн компаниудад эзэмших өөрсдийн хувь эзэмшлийн хэмжээ. Энэ нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн охин болон харьяа аж ахуйн нэгж болон тайлангийн хугацаанд эзэмшилд гарсан өөрчлөлтийн тухай мэдээллийн хувьд нэгэн адил хамааралтай”. “Төрийн өмчит компаниуд нь аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг, боломжгүй бол санхүүгийн гол үзүүлэлтүүдийг (баланс, ашиг/алдагдлын тайлан, мөнгөн урсгал гэх мэт) олон нийтэд ил тод болгох шаардлагатай. Тайлан гаргагч нь аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг хугацаанд нь нийтлэхэд саад болж буй хууль эрх зүйн болон зохицуулалтын бэрхшээлийг тодорхой баримтжуулах ёстой.” “Санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны болон хөрөнгийн зардал, худалдан авалт,	Шилэн дансны тухай хууль хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, аудитын тайлан, хуримтлагдсан ашгийн мэдээлэл бүхий санхүүгийн тайлан (балансын хамт) мэдээллийг нийтлэхийг шаарддаг. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль үндсэн үйл ажиллагаанаас гадна татвар, хуваарилсан ногдол ашиг зэрэг мэдээллийг нийтлэхийг шаарддаг. Уг хууль ТӨК-ийн хувь эзэмшил, Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, томилгоо болон сонгон шалгаруулалтын мэдээллийг нийтлэхийг мөн шаарддаг.	ОУИТБС-ын нэгтгэл тайланд ТӨК-ийг зохицуулдаг гол хууль тогтоомж, Засгийн газар ба ТӨК-ийн хоорондын санхүүгийн харилцааны тухай мэдээллийг тусгадаг. Уг тайланд хуримтлагдсан ашиг, нэмж хийсэн хөрөнгө оруулалт зэрэг мэдээллийг агуулсан санхүүгийн тайланг олон нийтэд ил тод нийтэлсэн эсэхийг оруулсан боловч зөвхөн найман ТӨК-ийг хамруулсан байна. Харин охин болон харьяа компанитай холбоотой эдгээр үзүүлэлтийн дагуух дэлгэрэнгүй мэдээллийг тайланд тусгаагүй байна. Төрийн өмчийг хариуцсан агентлаг нь ТӨК-ийн талаарх жилийн тайланг мөн гаргадаг. Эдгээр тайлан нь зөвхөн уул уурхайн салбараар хязгаарлагддаггүй буюу нийт төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн тухай мэдээллийг хамардаг. Монголын ОУИТБС нь ТӨК-ийн талаар өөрсдийн бэлтгэдэг тайлан болон уг агентлагийн тайлангийн хоорондын уялдааг сайжруулах нь зүйтэй ОУИТБС-ын тайланд ТӨК-ийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан эсэх, санхүүгийн тайланг олон нийтэд зориулж нийтэлсэн эсэх мэдээллийг тусгадаг. ТӨК санхүүгийн нарийвчилсан мэдээллээ Шилэн дансны мэдээллийн санд нийтэлдэг. Түүнчлэн Шилэн дансны тухай зэрэг хууль тогтоомж төр цөөнх хувийг эзэмшдэг компанид хамаарахгүй байна. Эдгээр компаниуд нь эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой байсан ч аудитаар баталгаажсан тайлангаа нийтлэх шаардлагагүй байдалтай байна. Монголын ОУИТБС нь дээр дурдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцсан төр засгийн байгууллага болон зарим компаниудтай хамтран ажиллах замаар ТӨК болон төрийн эзэмшлийн хувь хэмжээ бага боловч томоохон компаниудын аудитаар баталгаажсан тайланг бүрэн нийтлэх ажлыг хэрэгжүүлэх нь зүйтэй. ТӨК-ийн засаглалыг зохицуулдаг дүрэм журмыг ОУИТБС-ын жилийн тайланд тусгай бүлэг болгон тайлбарладаг. Уг тайланд зарим компанийн, тэр дотроо долоон ТӨК-ийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний тухай мэдээлсэн байна. Гэхдээ уг жагсаалт нь бүрэн бус гэж харагдаж байна. Түүнчлэн охин болон харьяа компанийн удирдах зөвлөлийн мэдээлэл уг вэбсайтад мөн байхгүй байна. Зарим охин болон харьяа компани вэбсайтдаа удирдах зөвлөлийн мэдээллээ нийтэлдэг ч мөн л жигд бус байна. Зөвхөн цөөн тооны ТӨК нь авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нийтэлдэг. ОУИТБС-ын жилийн нэгтгэл тайлангууд компаниуд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөтэй эсэх талаар мэдээллийг дурдаагүй.

	туслан гүйцэтгэгч ажиллуулах болон компанийн засаглалтай (ТУЗ-ийн бүрэлдэхүүн, томилгоо, чиг үүрэг, ёс зүйн дүрэм гэх мэт) холбоотой дүрэм журам болон практикийг тайлбарлан мэдээлэх шаардлагатай." "ТӨК-иуд нь авлигын эсрэг бодлогоо нийтлэхийг хүлээж байна..." "ТӨК-иуд нь магадлан шалгах нухацтай үйл явцыг мөрдөхийг дэмжиж байна." "Холбогдох тохиолдолд ТӨК олборлох салбарт хийж буй хөрөнгө оруулалт (үндсэн хөрөнгө, өглөг зэргийг оруулсан)-аа ил тод нийтлэхийг дэмжиж байна. ТӨК нь эдгээр хөрөнгө оруулалт нь эрчим хүчний шилжилт, уур амьсгалын эрсдэлийн асуудалтай хэрхэн уялдаж байгааг ил тод нийтлэхийг мөн дэмжиж байна." "Боломжтой тохиолдолд ТӨК нь төлөөлөгч эсхүл зуучлагч, материаллаг гүйлгээнд оролцож буй ханган нийлүүлэгчид эсхүл гэрээлэгчдийн хэн болох болон эцсийн өмчлөлийг нь ил нийтлэхийг дэмжиж байна."		
Шаардлага 3	3.1.b "...компаниуд нь боломжтой тохиолдолд газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын ордын эдийн засгийн хувьд үр ашигтай батлагдсан нөөцийн мэдээллийг ил нийтлэхийг дэмжиж байна."	Хуулиар шаарддаггүй	ОУИТБС-ын тайлангийн маягтад компаниудын батлагдсан нөөцөө мэдээлэх шаардлага байдаг. Тайлангийн систем шинэчлэгдэж, одоогоор ажиллахгүй байгаа тул энэ мэдээллийг илгээсэн компаниудын тоог авах боломжгүй байв. Түүнчлэн ОУИТБС-ын нэгтгэл тайланд энэ мэдээллийг компани тус бүрээр задалсан мэдээлэл, хавсралт байхгүй.
Шаардлага 3	3.2.d "компаниуд нь борлуулалтын бодит хэмжээ болон дүнг төсөл тус бүрээр ил нийтлэхийг дэмжиж байна."	Хуулиар шаарддаггүй	ОУИТБС-ын нэгтгэл тайланд компани тус бүрийн борлуулалтын хэмжээ, үнийн дүнг мэдээлдэг. Олборлолтын тоо баримтын талаарх ОУИТБС-ын болон засгийн газрын бусад статистик нь ихэнх тохиолдолд зөрдөг тул мэдээллийн чанар хангалтгүй хэвээр байна. ОУИТБС-ын 2022 оны тайланд[77] зөвхөн дөрвөн ТӨК-ийн мэдээлэл багтсан ч төсөл бүрээр ангилж тайлагнаагүй байна.
Шаардлага 3	3.3.d "Экспортлогч компаниуд, мөн түүхий эдийн арилжаанд оролцогч болон бусад бүтээгдэхүүн худалдан авагчид нь борлуулалтын бодит хэмжээ болон үнийн дүнг төсөл тус бүрээр ил нийтлэхийг дэмжиж байна."	Шилэн дансны тухай хуульд таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээг нийтлэхийг шаарддаг.	ТӨК-ийн хувьд таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээг Шилэн дансанд тайлагнах ёстой бөгөөд гүйлгээ хийсэн этгээдийг уг тайлангаас харах боломжтой. Энэ мэдээллээр дамжуулан түүхий эдийн арилжаанд оролцогчийн борлуулалтын орлогыг шууд бусаар ажиглах боломжтой. Гэвч олон нэрсийн жагсаалтаас худалдан авагчийг (ТӨК-ийн орлогоо авч буй гэж тайлагнасан этгээд) хялбар ялгаж олох боломжгүй бөгөөд Шилэн дансанд гүйлгээний

[77] Монголын ОУИТБС-ын Ажлын алба. "Монголын ОУИТБС-ын 2022 нэгтгэл тайлан. Хавсралт 22."

Монгол Улсын олборлох салбарын төрийн өмчит компаниудын ил тайлагналын тойм судалгаа

			талаарх тайлбар мэдээллийг системтэйгээр нийтэлдэггүй. Түүнчлэн Шилэн данс нь бүх ТӨК-ийг, тухайлбал засгийн газар бага хэмжээний хувийг нь эзэмшдэг компанийг том компанийг хүртэл хамардаггүй.
Шаардлага 3	3.3.е “Экспортлогч компаниуд болон хэрэгжүүлэгч улс орнууд нь худалдан авагч нь харилцан хамааралтай этгээд эсэхийг ил тод нийтлэхийг дэмжиж байна.”	Шилэн дансны тухай хуульд аудитаар баталгаажсан тайлан, баланс бүхий санхүүгийн тайлан нийтлэхийг шаарддаг.	Энэ мэдээлэл нь ОУИТБС-ын тайлан болон ихэнх компанийн вэбсайтад байдаггүй. Компаниудаас Татварын алба, Сангийн яаманд илгээдэг санхүүгийн тайланд харилцан хамааралтай этгээдтэй хийсэн гүйлгээний мэдээллийг хавсаргадаг бөгөөд компаниуд тайлангаа нийтлэхдээ хавсралтыг оруулдаггүй байна
Шаардлага 3	3.4.”Компаниуд нь хүлэмжийн хий ялгаруулалтын мэдээллийг ил тайлагналын мөрдөж буй шилдэг стандартад нийцүүлэн нийтлэхийг дэмжиж байна.”	Хуулиар шаарддаггүй	ОУИТБС-ын тайланд одоогоор компанийн хүлэмжийн хийн ялгаруулалтын мэдээлэл ордоггүй. Бадрах Энержи, Оюу Толгой зэрэг компани вэбсайт дээрээ энэ мэдээллийг нийтэлж буй зэрэг зарим нэгэн ахиц гарч буй ч бүх ТӨК олон нийтэд зориулж энэ мэдээллийг бэлтгэдэг болгохын тулд цогц арга хэмжээ авах хэрэгтэй байна.
Шаардлага 4	4.1. Татвар болон орлогын ил тайлагнал “Компаниуд нь шаардлагатай мэдээлэл (газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниас төрд төлж буй материаллаг төлбөр)-ийг засгийн газрын болон компанийн тайлангаар (вэбсайт, жилийн тайлан гэх мэт) дамжуулж ил мэдээлэхийг хүлээж байна.” “Төсөвт материаллаг төлбөр төлж буй газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд нь тогтоосон цар хүрээний дагуу материаллаг төлбөрийн иж бүрэн мэдээллийг ил нийтлэх шаардлагатай.” “Аж ахуйн нэгжүүд нь аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг, боломжгүй бол санхүүгийн гол үзүүлэлт (баланс, ашиг/алдагдлын тайлан, мөнгөн урсгал, татварын хувь хэмжээ гэх мэт)-ийг олон нийтэд ил тод болгох арга хэмжээ авна.” “...Тайлант хугацаанд хамаарах татварын хасалт болон урамшууллыг нийтлэхийг дэмжиж байна.”	Шилэн дансны тухай хуульд аудитаар баталгаажсан тайлан, баланс бүхий санхүүгийн тайлан нийтлэхийг шаарддаг.	ОУИТБС-ын жилийн тайланд олборлох компаниас төсөвт төлсөн төлбөрийн тухай нарийвчлан мэдээлж, төлбөрийн төрлийн хувьд маш дэлгэрэнгүй тайлагнадаг. ТӨК-иуд нь төрийн аудитын дээд байгууллага болох Үндэсний аудитын газраар аудит хийлгэх үүрэгтэй бөгөөд ихэнхдээ аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг вэбсайт дээрээ нийтэлдэг. Үүнээс гадна ТӨК нь аудит хийлгэсэн тайланг Шилэн дансанд мэдээлэх шаардлагатай. Гэвч энэ хоёр эх сурвалжийн аль алинд бүх компанийн аудитын тайланг нийтлээгүй байна. Монголын ОУИТБС нь Үндэсний аудитын газраас аудит хийсэн бүх ТӨК-ийн тайлангийн жагсаалтыг авах талаар ажиллах нь зүйтэй бөгөөд ингэснээр бүх санхүүгийн тайланг аудитаар баталгаажсан хувилбараар ил нийтэлж буй эсэх нь тодорхой болох юм.

Монгол Улсын олборлох салбарын төрийн өмчит компаниудын ил тайлагналын тойм судалгаа

Шаардлага 4	4.2. “Газрын тос, байгалийн хий эсхүл ашигт малтмалын олборлосон баялгаас төрд ногдох хэсгийг борлуулсан эсхүл бүтээгдэхүүн хэлбэрээр хүлээн авсан бусад орлого нь материаллаг бол Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгж нь төрийн хүлээн авсан хэмжээ, төрийн (эсхүл төрийг төлөөлөн гуравдагч талын хийсэн) борлуулсан хэмжээ, борлуулалтын орлого, борлуулсан газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын орлогоос төрд шилжүүлсэн хэмжээ зэргийг ил тод болгон мэдээлэх үүрэгтэй. Үүнд мөн своп гэрээ болон баялгаар баталгаажсан зээл (Шаардлага 4.3-ыг харна уу) байгаа бол тэдгээртэй холбоотой төлбөрийг (мөнгөн ба мөнгөн бус) багтаасан байх ёстой.” “Санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд, тухайн орнуудын төрийн өмчит аж ахуйн нэгж нь бүтээгдэхүүнийг нь худалдан авагч компанийг сонгох үйл явцын тухай тайлбар, сонгон шалгаруулалтад ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд, сонгон авсан худалдан авагч компаниудын жагсаалт болон эцсийн өмчлөлийн мэдээлэл (боломжтой тохиолдолд), зуучлагч эсхүл төлөөлөгчийн мэдээлэл (байгаа тохиолдолд), худалдан авагч компанийг сонгохтой холбоотой эрх зүй, зохицуулалтын хүрээнээс материаллаг байдлаар давсан нөхцөлүүд, хамаарах борлуулалтын гэрээ зэргийг ил тод болгохыг дэмжиж байна.”	Шаардлага байхгүй	ОҮИТБС-ын нэгтгэл тайланд газрын тосны олборлолтын компаниас засгийн газарт ногдох бүтээгдэхүүний борлуулалтын орлогын мөнгөн дүнг мэдээлдэг. Гэвч төр ямар хэмжээний газрын тосны хувь хэмжээ авах, түүнчлэн энэ дүн нь борлуулалтын орлого эсхүл засгийн газар өөрөө борлуулах бүтээгдэхүүн хэлбэртэй гэх мэт нарийвчилсан мэдээлэл дутмаг байна. Өнөөдрийн байдлаар газрын тос олборлох үйл ажиллагаа эрхэлдэг ТӨК байхгүй. Нүүрсний салбарт 2023 онд гарсан “нүүрсний хулгайн” гэх дуулианаас хойш ТӨК-иуд нь урьдчилсан борлуулалт эсхүл хеджинг гэрээ (үнийн эрсдэлээс хамгаалах зорилгоор хийдэг гэрээ) байгуулахаас зайлсхийж байна. Нүүрс экспортлогчид худалдах-худалдан авах гэрээг татварын албанд илгээдэг бөгөөд ОҮИТБС нь татварын алба хүлээн авсан бүх гэрээний мэдээлэл, тухайлбал своп гэрээ, баялгаар баталгаажсан зээл эдгээр гэрээнд багтсан эсэх талаарх мэдээллийг нийтлэх талаар тус газартай хамтран ажиллах хэрэгтэй. ОҮИТБС-ын жилийн тайланд худалдан авагч, ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулахдаа ТӨК-ийн баримтлах ёстой хууль эрх зүйн орчны талаарх мэдээллийг оруулдаг. Гэвч дийлэнх ТӨК худалдан авах ажиллагааны тухай буюу сонгон шалгаруулалтын шалгуур, эцсийн өмчлөлийн мэдээлэл, зуучлагч эсхүл төлөөлөгч томилох зэрэг мэдээллийг огт нийтэлдэггүй эсхүл дэлгэрэнгүй мэдээлэл өгдөггүй. Саяхнаас татварын газар экспортын бүх компанийг өөрсдийн худалдан авагчийн мэдээллийг илгээхийг шаардаж эхэлсэн. Энэ мэдээлэл нь эсхүл компаниудын илгээсэн гэрээний жагсаалт нь ОҮИТБС-ын тайлангаар дамжиж ил тод нийтлэгдэх боломжтой.
Шаардлага 4	4.4.а “Газрын тос, байгалийн хий, ашигт малтмал тээвэрлэлтийн орлого нь материаллаг бол Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нь хүлээн авсан орлогыг ил тод болгох шаардлагатай”	Хуулиар шаарддаггүй	ОҮИТБС-ын нэгтгэл тайланд ТӨК-ийн тээврийн үйл ажиллагааны талаарх бүлэг болон хавсралт ордог. ОҮИТБС-ын цуглуулдаг мэдээлэл бүрэн бус учраас тээврийн компанийн талаар хангалттай ойлголт өгч чадахгүй байна. ОҮИТБС нь энэ шаардлагыг анхааралдаа авч, мэдээлэл цуглуулах, нийтлэх явцыг тогтмол бөгөөд үр дүнтэй болгох талаар ажиллах нь зүйтэй.

Монгол Улсын олборлох салбарын төрийн өмчит компаниудын ил тайлагналын тойм судалгаа

Шаардлага 4	4.5.а “Олон талт оролцогчдын бүлэг нь тайлагнах үйл явцад төрийн өмчит аж ахуйн нэгжийн гүйцэтгэх үүргийг тодорхой гарган, тэднийг бүрэн хамруулж, газрын тос, байгалийн хий болон ашигт малтмал олборлох компаниудын зүгээс төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд хийсэн төлбөр, төрийн өмчит аж ахуйн нэгж төрийн байгууллагуудын хооронд хийгдэж буй материаллаг төлбөрийг хамруулах үүрэгтэй.”	Шилэн дансны тухай хууль нь таван сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ бүрийг тайлагнах шаардлагыг ТӨК-т тавьдаг.	ОҮИТБС нь ТӨК-ийн гүйцэтгэх үүрэг, ТӨК-ийн төлбөр, гүйлгээг ил тод нийтлэхийг зохицуулдаг дүрэм журмын талаар нэлээд задаргаатай тайлагнадаг ч ОҮИТБС-ын стандартад нийцсэн байдлаар практик туршлагыг дэлгэрэнгүй мэдээлэх нь харьцангуй сул байна. Мөн мэдээллийн үнэн зөв байдал эргэлзээтэй бөгөөд үүнд ТӨК-ийн жагсаалт, хувь эзэмшлийн байдал, удирдах зөвлөл, ТӨК болон төрийн хооронд төлбөрийн гүйлгээ зэрэг мэдээлэл орно. Монголын ОҮИТБС нь мэдээлэл цуглуулах үйл явцдаа ямар мэдээллийг орхигдуулж буйгаа судалж, тайлангийн зөрүү, давхардал зэрэгтэй холбоотойгоор ТӨК болон бусад компанийг зааглан харуулах аргачлалыг боловсруулах хэрэгтэй байна
Шаардлага 4	4.10.с “Компаниуд болон хэрэгжүүлэгч улс орнууд нь зардлыг төсөл бүрээр, мөн үйл ажиллагааны болон капитал зардал гэж ангилсан мэдээллийг ил тод нийтлэхийг дэмжиж байна. Тайлант хугацаанд мэдүүлсэн үйл ажиллагааны зардалд өмнөх жилүүдэд гарсан зардлын элэгдэл, хорогдлыг тооцож болно. Компани болон хэрэгжүүлэгч улс орон нь төсөл эхэлснээс хойш гарсан бүх зардлыг тайлагнахыг дэмжиж байна”.	Хуулиар шаарддаггүй	Төсөл тус бүрээр ангилсан мэдээлэл бэлтгэх нь Монголын ТӨК-ийн хувьд нэлээд бэрхшээлтэй асуудал юм. Үүний нэг шалтгаан нь аливаа татварыг хуулийн этгээдийн хүрээнд төлдөг бөгөөд уул уурхайн төслийн тодорхойлолт мөн хялбар биш юм. Монголын ОҮИТБС-ын нэгтгэл тайланд төслийн тодорхойлолтыг гаргах гэж оролдсон бөгөөд төслийн түвшний мэдээлэл бүхий хавсралт оруулсан ч мэдээлэл нь дутуу, хэт ерөнхий тул татварын төлбөр гэх мэт гол асуудлын талаар мэдээлэл авахад хангалтгүй байна. Монголын ОҮИТБС нь ТӨК-ийн төсөл бүрээр ангилсан тайлангийн асуудлыг эргэн харж, хуулийн этгээдэд үндэслэсэн одоогийн тайланд төслийн түвшний мэдээллийг задалж харуулах хэрэгтэй байна.
Шаардлага 5	5.3.с "Олон талт оролцогчдын бүлэг хүсэлт гаргасан тохиолдолд газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд нь төслийн үйлдвэрлэлийн хэмжээний талаарх төсөөлөл, зардлаа нөхөхөөр таамаглаж буй хугацаа зэрэг мэдээллийг ил тод болгохыг дэмжиж байна.”	Хуулиар шаарддаггүй	ОҮИТБС-ын нэгтгэл тайланд төслийн үйлдвэрлэлийн хэмжээний талаарх төсөөлөл эсхүл зардлаа нөхөхөөр таамаглаж буй хугацаа зэрэг мэдээлэл байдаггүй. Энэ төрлийн мэдээлэл нь техник-эдийн засгийн үндэслэлийн баримтад агуулагддаг боловч ийм судалгааг нийтэд зориулж нийтэлдэггүй.
Шаардлага 6	6.2.а “Олборлох салбар дахь төрийн оролцоотой холбоотойгоор эрдэс баялгийн салбараас материаллаг хэмжээний төлбөр, орлогыг олдог бол хэрэгжүүлэгч улс орнууд ТӨК-ийн төсвийн шинжтэй зарцуулалтын талаарх мэдээллийг ил нийтлэх шаардлагатай.” “Олон талт оролцогчдын бүлэг бусад төлбөр болон орлогын урсгалын нэгэн адил түвшинд тайлагнах явцыг хэрэгжүүлэх бөгөөд үүнд ТӨК-ийн охин болон хамтарсан компаниуд мөн хамаарна.”	Хуулиар шаарддаггүй	ОҮИТБС-ын нэгтгэл тайланд ТӨК-ийн төсвийн шинжтэй зардлын мэдээллийг Шилэн дансны ТӨК-ийн тайлантай холбох байдлаар оруулдаг. Гэвч төсвийн шинжтэй зардлын тодорхойлолт нь ойлгомжгүй, мөн Шилэн дансанд энэ төрлийн зардлыг шүүх боломжтой тодорхой тайланг нийтэлдэггүй.

Монгол Улсын олборлох салбарын төрийн өмчит компаниудын ил тайлагналын тойм судалгаа

Шаардлага 6	6.3.a.iv "...компаниуд жендерт суурилсан цалингийн ялгаатай байдлыг ил тод нийтлэхийг дэмжиж байна."	Хуулиар шаарддаггүй	ОҮИТБС-ын нэгтгэл тайланд компанийн нийт ажиллагсдын тоог хүйсээр ангилсан мэдээлэл багтсан боловч цалингийн ялгааны талаар дурддаггүй
Шаардлага 6	Байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр нөлөө "Хэрэгжүүлэгч улс орнууд болон тайлагнагч компаниуд нь хууль тогтоомж болон гэрээний дагуу шаарддаг байгаль орчин, нийгэм, засаглалын үр нөлөөний судалгаа, мониторингийн тайлан, ердийн болон тусгай зөвшөөрлийн мэдээлэл нь бодит байдал дээр олон нийтэд хүртээмжтэй байхыг хангаж ажиллах үүрэгтэй." "Компаниуд нь нийгэм, жендер болон байгаль орчны менежмент, үр нөлөөний талаарх нэмэлт мэдээллийг ил нийтлэхийг дэмжиж байна."	Хуулиар шаарддаггүй	Ихэнх компаниуд байгаль орчин, нийгэм, засаглалын үр нөлөөний судалгааг тогтмол бэлтгэх эсхүл нийтлэх практик байдаггүй. ОҮИТБС-ын тайланд байгаль орчин, нийгэм, засаглалтай холбоотой буюу химийн бодисын хэрэглээ, ус ашиглалт, орон нутгийн иргэд, орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ гэх мэт хэрэгтэй мэдээлэл ордог боловч энэ чиглэлийн тоо баримт эсхүл нөлөөллийн үнэлгээ байдаггүй. ОҮИТБС нь ТӨК-ийн байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг ОҮИТБС-ын тайлангаар дамжуулж ил тод нийтлэх тал дээр анхаарах хэрэгтэй байна

Эх сурвалж

Эндрю Бауэр, Намхайжанцангийн Дорждарь. "Барьцгүй өсөлт: Эрдэнэс Монголын үнэлгээ", 2019 оны 6 дугаар сарын 16. www.resourcegovernance.org/sites/default/files/documents/wild-growth-an-assessment-of-erdenes-mongol-full-report.pdf.

Намхайжанцангийн Дорждарь. "Монголын төрийн өмчит уул уурхайн компаниуд: Шилэн дансны мэдээллийн гүнд". 2022 оны 5 дугаар сар. www.resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolia_mining_soe_deeper_look_into_glass_accounts_data.pdf.

ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар. ОҮИТБС-ын 2023 оны стандарт. 2023 оны 6 дугаар сар. www.eiti.org/sites/default/files/2023-06/2023%20EITI%20Standard.pdf.

———. “Монгол Улсын 2022 оны баталгаажуулалтын тайлан,” 2022 оны 10 дугаар сар. www.eiti.org/sites/default/files/2022-10/EITI%20Validation%20of%20Mongolia%20%282022%29%20-%20Final%20Validation%20report%20%28July%202022%29%20%28EN%29.pdf.

Монголын ОҮИТБС-ын Ажлын алба. “Монголын ОҮИТБС-ын 2022 нэгтгэл тайлан,” 2023 он. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2024/01/26/ccgk80kk82n69ur3/17-%D1%80%20%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD.pdf.

“ОҮИТБС дүрэм 2010.” ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар, 2010. www.eiti.org/sites/default/files/2022-04/2010-02-24%20EITI%20Rules.pdf.

Эрдэнэс Монгол. “Эрдэнэс Монгол нэгдлийн 2022 оны санхүүгийн тайлан,” www.erdenesmongol.mn/mn/news/116.

Улсын бүртгэлийн ерөнхий газар. “Улсын бүртгэлийн ерөнхий газрын вэбсайт.” Мэдээлэл авсан огноо: 2024 оны 4 дүгээр сарын 27,. www.opendata.burtgel.gov.mn/les.

Монгол Улсын Засгийн газар. “Эрдэнэт үйлдвэр, Монголросцветмет ТӨК-ийн тухай тогтоол". 2022 оны 6 дугаар сарын 8. www.legalinfo.mn/mn/detail?lawId=16530635530451.

www.erdenesmongol.mn/mn. “Эрдэнэс Монгол вэбсайт.” Мэдээлэл авсан огноо: 2024 оны 4 дугаар сарын 25. www.erdenesmongol.mn/mn.

“Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 оны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.” Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, 2023. www.pcsp.gov.mn/files/statistic/2022_FR_SOE_Hevleh_Zassan.pdf.

Ашигт малтмалын тухай хууль (2006). www.legalinfo.mn/mn/detail/63.

“Мөнгө угаах, терроризмтой тэмцэх олон улсын байгууллага (FATF): Монгол Улсын үнэлгээ.” Мэдээлэл авсан огноо: 2024 оны 5 дугаар сарын 27. www.fatf-gafi.org/en/countries/detail/Mongolia.html.

Үндэсний аудитын газар. “Үндэсний аудитын газрын вэбсайт.” Мэдээлэл авсан огноо: 2024 оны 4 дүгээр сарын 27. www.open.audit.mn/report.

Үндэсний статистикийн хороо. “Хуулийн этгээдийн бүртгэл,” 2024. www.1212.mn/mn/statistic/statcate/573067/table-view/DT_NSO_2600_014V2.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн. “Уул уурхайн салбарын авлигатай хэрхэн тэмцэх вэ: Авлига оношлох хэрэгслийг Монгол Улсад турших нь”, 2023 оны 5 дугаар сарын 23. www.resourcegovernance.org/blog/how-to-fight-corruption-mining-piloting-corruption-diagnostic-tool-mongolia.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн. “Монгол Улсын уул уурхайн засаглал бага зэрэг сайжирсан боловч олон нийтэд мэдээлэл хүргэх болон төрийн өмчит компаниудын

засаглалын асуудалд анхаарах шаардлагатай байна,” 2021 оны 6 дугаар сарын 30. www.resourcegovernance.org/articles/mining-governance-mongolia-improves-slightly-public-disclosures-and-governance-state-owned.

Цөмийн энергийн тухай хууль (2009).

Нээлттэй засгийн түншлэл. “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө,” 2024 оны 1 дүгээр сарын 8. www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-2023-2027-december/.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021). www.legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601.

УИХ. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030,” 2023 он. www.legalinfo.mn/mn/detail?lawId=16760139781851.

———. Шилэн дансны тухай хууль (2014). www.legalinfo.mn/mn/detail?lawId=10497.

———. Төрийн аудитын тухай хууль (2020). www.legalinfo.mn/mn/detail/15357.

UB Post. “Эрдэнэс Монголын гүйцэтгэх захирал Д.Хаянхярваа авлига авснаа хүлээн зөвшөөрөв.” 2021 оны 11 дүгээр сарын 17. www.pressreader.com/mongolia/the-ub-post/20211117/page/1.

UB Post. “Эрдэнэс Тавантолгой ХХК-ын гүйцэтгэх захирал асан Б.Ганхуяг, УИХ-ын гишүүн асан Т.Аюурсайхан нарыг цагдан хорив.” 2024 оны 2 дугаар сарын 2. www.pressreader.com/mongolia/the-ub-post/20240202/page/1.

“Байр суурь: Нүүрсний хэргийн талаарх эхний сонсголд хэн, хэн юу өгүүлэв.” Мэдээлэл авсан огноо: 2024 оны 5 дугаар сарын 27. www.dorgio.mn/p/148903.

www.eitimongolia.mn. “ОҮИТБС-ын вэбсайт, ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн.” Мэдээлэл авсан огноо: 2024 оны 4 дугаар сарын 26. www.eitimongolia.mn/p/3.

www.eitimongolia.mn. “ОҮИТБС-ын вэбсайт, ОҮИТБС-ын Ажлын хэсгийн бүрэлдэхүүн..” Мэдээлэл авсан огноо: 2024 оны 4 дугаар сарын 26. www.eitimongolia.mn/p/8.